



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 оны 12 дугаар сарын 16
№49 (1247)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

941.	Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай	3457
942.	Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	3492
943.	Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	3493
944.	Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	3495
945.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай	3496
946.	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай	3498
947.	Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	3499
948.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай	3503
949.	Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай	3504
950.	Улсын гэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	3505
951.	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	3506

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

952.	Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 73	3508
953.	Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай	Дугаар 76	3510



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

954.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 204	3511
955.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 205	3511
956.	Албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 208	3512
957.	Албан тушаалд томилох тухай	Дугаар 209	3512
958.	Албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 210	3513
959.	Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 211	3513

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

960.	Үндэсний хоршооны ажиллах журам, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	Дугаар 247	3514
961.	Журам батлах тухай	Дугаар 253	3520
962.	Дүрэм батлах тухай	Дугаар 257	3524
963.	Журам батлах тухай	Дугаар 260	3554
964.	Хөтөлбөр батлах тухай	Дугаар 265	3557

ТЭГШ	
Зөвлөлөгч Гиймэр Мр Нийгэм	
᠘᠒᠒᠙᠓᠐	᠖᠑᠔
7᠒᠒᠙᠓᠑	7᠒᠔
7᠒᠒᠙᠓᠒	10᠑᠔
᠒᠒᠒᠙᠓᠓	᠑᠑᠔
᠑᠒᠒᠙᠓᠔	᠒᠒᠔
7᠒᠒᠙᠓᠕	᠑᠒᠔
᠑᠒᠒᠙᠓᠖	᠘᠑᠔
7᠒᠒᠙᠓᠗	7᠑᠔
᠑᠒᠒᠙᠓᠘	᠑᠒᠔
7᠒᠒᠙᠓᠙	᠑᠒᠔
᠒᠒᠒᠙᠔᠐	᠑᠒᠔
᠑᠒᠒᠙᠔᠑	᠑᠒᠔
7᠒᠒᠙᠔᠒	᠑᠒᠔
᠑᠒᠒᠙᠔᠓	᠑᠒᠔
7᠒᠒᠙᠔᠔	᠑᠒᠔
᠑᠒᠒᠙᠔᠕	᠑᠒᠔
7᠒᠒᠙᠔᠖	᠑᠒᠔
᠑᠒᠒᠙᠔᠗	᠑᠒᠔
7᠒᠒᠙᠔᠘	᠑᠒᠔
᠑᠒᠒᠙᠔᠙	᠑᠒᠔
7᠒᠒᠙᠕᠐	᠑᠒᠔
Зөвлөлөгч Гиймэр Мр Хүрэн Намжил	
7᠒᠒᠙᠕᠑	᠑᠒᠔
᠐᠖᠒᠙᠕᠒	10᠒᠔
Зөвлөлөгч Гиймэр Мр Кэцэвэрэнхүү Хэр Хүндэр	
66᠒᠙᠕᠓	᠑᠒᠔
66᠒᠙᠕᠔	᠒᠒᠔
7᠒᠒᠙᠕᠕	7᠒᠔



᠗᠖᠒᠘᠗	᠑᠐᠓᠓	᠑᠐᠓᠓	᠑᠒᠒᠗	᠑᠒᠒᠗
᠗᠗᠖᠒᠘᠗	᠐᠖᠒᠒	᠐᠖᠒᠒	᠗᠗᠖᠒᠘᠗	᠗᠗᠖᠒᠘᠗
᠗᠗᠖᠒᠘᠗	᠖᠖᠒᠒	᠖᠖᠒᠒	᠗᠗᠖᠒᠘᠗	᠗᠗᠖᠒᠘᠗
᠑᠖᠒᠘᠗	᠘᠑᠒᠒	᠘᠑᠒᠒	᠑᠖᠒᠘᠗	᠑᠖᠒᠘᠗
᠐᠓᠒᠘᠗	᠗᠒᠒᠒	᠗᠒᠒᠒	᠐᠓᠒᠘᠗	᠐᠓᠒᠘᠗
᠑᠓᠒᠘᠗	᠘᠒᠒᠒	᠘᠒᠒᠒	᠑᠓᠒᠘᠗	᠑᠓᠒᠘᠗
᠑᠒᠒᠘᠗	᠐᠑᠒᠒	᠐᠑᠒᠒	᠑᠒᠒᠘᠗	᠑᠒᠒᠘᠗
᠘᠒᠒᠘᠗	᠒᠑᠒᠒	᠒᠑᠒᠒	᠘᠒᠒᠘᠗	᠘᠒᠒᠘᠗



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 11 дүгээр
сарын 04-ний өдөр

Улаанбаатар
хот

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд, мөнгөн зээлийн үйл ажиллагааг байнга, ашиг олох зорилгоор эрхлэх иргэнийг бүртгэх, хяналт тавих, тэдгээрээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох, зээл, түүний хүүг төлөх болон мөнгөн зээлийн үйл ажиллагаанд хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах хууль тогтоомж

2.1.Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Иргэний хууль², энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулиар барьцаалан зээлдүүлэх журмаар олгох болон иргэнээс байнга, ашиг олох зорилгоор олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа /цаашид “мөнгөн зээлийн үйл ажиллагаа” гэх/-тай холбогдсон харилцааг зохицуулна.

3.2.Банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршооноос олгох зээлийн үйл ажиллагаатай холбогдсон харилцаанд энэ хууль үйлчлэхгүй.

3.3.Хуульд өөрөөр заагаагүй бол иргэнээс олгох нэг удаагийн шинжтэй, эсхүл ашиг олох зорилгогүй зээлийн харилцаанд энэ хууль үйлчлэхгүй.

¹Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

²Иргэний хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.



**ХОЁРДУГААР БҮЛЭГ
МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЭТГЭЭДЭД ТАВИХ ШААРДЛАГА**

4 дүгээр зүйл. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд

4.1. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагааг ашгийн төлөө хэлбэрээр байгуулагдсан хуулийн этгээд эрхэлнэ.

4.2. Байнга, ашиг олох зорилгоор олгох мөнгөн зээлийн үйл ажиллагааг энэ хуульд заасны дагуу эрх бүхий этгээдэд бүртгүүлсний үндсэн дээр Монгол Улсын иргэн эрхэлж болно.

**5 дугаар зүйл. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх
этгээдэд тавих шаардлага**

5.1. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд дараах шаардлагыг хангасан байна:

5.1.1. мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэний мөнгөн хөрөнгийн хэмжээ, хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 10 000 000 төгрөг, түүнээс багагүй байх;

5.1.2. энэ хуулийн 8.1-д заасан мөнгөн зээлийн үйл ажиллагааны журмын талаарх сургалтад хамрагдсан байх;

5.1.3. мөнгөн зээлийн үйл ажиллагаанд зориулсан банкны харилцах данстай байх;

5.1.4. татвар төлөгчөөр бүртгүүлсэн байх;

5.1.5. татварын нэгдсэн системд холбогдсон кассын машин, хэвлэх төхөөрөмжтэй байх;

5.1.6. барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бол тухайн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлага, стандартыг хангасан ажлын байртай байх;

5.1.7. барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бол тухайн мөнгөн зээлийн үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийг агуулсан, энэ хуульд заасан эрх бүхий албан тушаалтан тухайн мөнгөн зээлийн үйл ажиллагаатай холбогдсон шаардлагатай мэдээлэл авах боломжийг хангасан цахим бүртгэлтэй байх;

5.1.8.энэ хуулийн 16.2-т заасан цахим мэдээллийн санд холбогдсон байх;

5.1.9.барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бол гүйцэтгэх удирдлага, менежер нь энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байх;

5.1.10.байнга, ашиг олох зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэн бол Эрүүгийн хуулийн³ Арван долдугаар бүлэгт заасан Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, Арван наймдугаар бүлэгт заасан Эдийн засгийн гэмт хэрэг, 29.10 дугаар зүйлд заасан Тэрроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт хариуцлага хүлээж байгаагүй.

5.2.Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тавигдах нэмэлт шаардлага, үйл ажиллагаа явуулах нөхцөл, шаардлагыг Санхүүгийн зохицуулах хороо тогтоож болно.

5.3.Энэ хуулийн 5.1.6-д заасан ажлын байранд тавигдах шаардлага, стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

6 дугаар зүйл. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн нэр

6.1.Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн нэр нь түүний оноосон нэр болон “барьцаалан зээлдүүлэх газар”, байнга, ашиг олох зорилгоор зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэн бол “зээлийн үйлчилгээ” гэсэн тэмдэглэгээнээс бүрдэнэ.

6.2.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээр бүртгүүлээгүй этгээд нэрэндээ “барьцаалан зээлдүүлэх газар”, “зээлийн үйлчилгээ” гэсэн тэмдэглэгээ, эсхүл түүнтэй төсөөтэй тэмдэглэгээ хэрэглэхийг хориглоно.

6.3.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд өөрийн нэрээр мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг бусдад зөвшөөрөхийг хориглоно.

7 дугаар зүйл. Гүйцэтгэх удирдлага, менежер тавих шаардлага

7.1.Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн гүйцэтгэх удирдлага, менежер нь дараах шаардлагыг хангасан байна:

³Эрүүгийн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 7 дугаарт нийтлэгдсэн.



7.1.1.насанд хүрсэн, иргэний эрх зүйн бүрэн чадамжтай этгээд;

7.1.2.энэ хуулийн 5.1.10-т заасан гэмт хэрэгт хариуцлага хүлээж байгаагүй;

7.1.3.энэ хуулийн 8.1-д заасан мөнгөн зээлийн үйл ажиллагааны журмын талаарх сургалтад хамрагдсан байх.

7.2.Тухайн этгээд гүйцэтгэх удирдлага, эсхүл менежерээр томилогдсоны дараа энэ хуулийн 7.1.1, 7.1.2-т заасан шаардлагыг хангахгүй болох нь тогтоогдсон бол тухайн этгээд албан тушаалаасаа татгалзах, эсхүл түүнийг томилсон этгээд албан тушаалаас нь чөлөөлнө.

7.3.Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд хоёр ба түүнээс дээш зээлийн үйлчилгээний салбар ажиллуулах бол салбар бүрд менежер ажиллуулна.

8 дугаар зүйл.Мөнгөн зээлийн үйл ажиллагааны журмын талаарх сургалт

8.1.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд болон түүний холбогдох ажилтан мөнгөн зээлийн үйл ажиллагааны журмын талаарх сургалтад хамрагдах үүрэгтэй.

8.2.Энэ хуулийн 8.1-д заасан сургалтын үргэлжлэх хугацаа гурван өдрөөс илүүгүй байх бөгөөд сургалт явуулах байгууллагад тавигдах шаардлага, сургалтын хөтөлбөр, арга хэлбэр, сургалтын төлбөрийн хэмжээ, сургалт явуулахтай холбогдсон журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛ

9 дүгээр зүйл.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээр бүртгүүлэх өргөдөл гаргах

9.1.Энэ хуулийн 9.2-т зааснаас бусад, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн, энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан этгээд аймаг, нийслэлийн Засаг даргад өргөдөл гаргаж бүртгүүлнэ.

9.2.Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан, аймагт 100 000 000 төгрөг, түүнээс дээш, нийслэлд 300 000 000 төгрөг,

түүнээс дээш хэмжээний хувь нийлүүлсэн хөрөнгөтэй мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн хуулийн этгээд Санхүүгийн зохицуулах хороонд өргөдөл гаргаж бүртгүүлнэ.

9.3.Энэ хуулийн 9.1, 9.2-т заасан өргөдөлд дараах мэдээллийг тусгана:

9.3.1.өргөдөл гаргасан он, сар, өдөр;

9.3.2.өргөдөл гаргагчийн нэр, хаяг;

9.3.3.өргөдөл гаргагч нь иргэн бол иргэний бүртгэлийн дугаар, хуулийн этгээд бол регистрийн дугаар;

9.3.4.өргөдөл гаргагч нь хуулийн этгээд бол гүйцэтгэх удирдлагын болон менежерийн нэр, хаяг;

9.3.5.мөнгөн зээлийн үйл ажиллагаа явуулах арга хэлбэр, дансны мэдээлэл;

9.3.6.мөнгөн зээлийн үйл ажиллагаа явуулах байршил;

9.3.7.мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх мөнгөн хөрөнгийн хэмжээ;

9.3.8.энэ хуулийн 20.2.5-д заасан зар сурталчилгаанд ашиглах харилцах утасны дугаар болон олон нийтэд мэдээлэл хүргэх цахим хуудас.

10 дугаар зүйл.Бүрдүүлэх баримт бичиг

10.1.Энэ хуулийн 9.1, 9.2-т заасны дагуу өргөдөл гаргах мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн этгээд дараах баримт бичгийг өргөдөлд хавсаргана:

10.1.1.энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан талаарх болон мөнгөн хөрөнгийг нотлох баримт;

10.1.2.мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг нотлох баримт;

10.1.3.шаардлагатай тохиолдолд итгэмжлэл.

11 дүгээр зүйл.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл

11.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 9.1-д заасан, Санхүүгийн зохицуулах хороо энэ хуулийн 9.2-т заасан өргөдөл, холбогдох баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор хянаж,

шаардлагыг хангасан өргөдөл гаргагчийг мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл /цаашид “бүртгэл” гэх/-д бүртгэж, гэрчилгээ олгоно.

11.2.Бүртгэлд бүртгүүлсэн мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хувийн дугаар олгох бөгөөд холбогдох журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална.

11.3.Аймаг, нийслэлийн Засаг дарга, эсхүл Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “бүртгэх байгууллага” гэх/ шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 11.1-д заасан хугацааг ажлын таван өдрөөр нэг удаа сунгаж болох бөгөөд энэ тухай өргөдөл гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

11.4.Өргөдөл гаргагчийн ирүүлсэн баримт бичгийн бүрдэл дутуу бол бүртгэх байгууллага энэ тухай өргөдөл гаргагчид бичгээр мэдэгдэх бөгөөд өргөдөл гаргагч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан баримт бичгийн бүрдлийг ажлын таван өдрийн дотор хангаж ирүүлнэ. Энэ хугацаанд дутуу баримт бичгийг ирүүлээгүй бол бүртгэх байгууллага тухайн өргөдөл гаргагчийг бүртгэхээс татгалзсанд тооцно.

11.5.Өргөдөл гаргагч энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй, энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан баримт бичгийг бүрдүүлээгүй бол бүртгэх байгууллага өргөдөл гаргагчийг бүртгэхээс татгалзаж, энэ тухай өргөдөл гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

11.6.Бүртгэх байгууллага энэ хуулийн 11.5-д заасан мэдэгдэлд татгалзсан үндэслэлийг тодорхой заана.

11.7.Өргөдөл гаргагч энэ хуулийн 11.6-д заасан бүртгэхээс татгалзсан үндэслэлийг арилгасны дараа бүртгүүлэх өргөдлөө дахин гаргаж болно.

11.8.Өргөдөл гаргагчийн ирүүлсэн баримт бичиг хуурамч болох нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол бүртгэх байгууллага бүртгэхээс татгалзана.

11.9.Бүртгэх байгууллага энэ хуулийн 11.1, 11.3-т заасан хугацаанд өргөдөл гаргагчид бүртгэсэн эсэх талаар мэдэгдээгүй бол тухайн өргөдөл гаргагчийг мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээр бүртгэсэнд тооцно.

11.10.Бүртгэх байгууллага энэ хуулийн 11.1-д заасан бүртгэлийг Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлийн цахим санд оруулах бөгөөд холбогдох журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална.

11.11.Бүртгэх байгууллага энэ хуулийн 11.1-д заасан бүртгэлтэй холбоотой, хувь хүн, байгууллагын нууцтай холбоотой мэдээллээс бусад мэдээллийг холбогдох шийдвэр гарсны дараах өдөр олон нийтэд мэдээлэл хүргэх цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулна.

11.12.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэх маягт, заавар, бүртгэл хөтлөх журам, гэрчилгээний загварыг Санхүүгийн зохицуулах хороо батална.

12 дугаар зүйл.Бүртгэлд бүртгүүлээгүй этгээдэд тавигдах хязгаарлалт

12.1.Бүртгэлд бүртгүүлээгүй этгээд мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх, эсхүл мөнгөн зээлийн үйл ажиллагааны талаар зар сурталчилгаа хийхийг хориглоно.

13 дугаар зүйл.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэлд өөрчлөлт оруулах

13.1.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд энэ хуулийн 11.1-д заасан бүртгэлийн мэдээлэлтэй холбогдсон өөрчлөлтийг бүртгүүлэх өргөдлийг тухайн мэдээлэлд өөрчлөлт оруулснаас хойш ажлын гурван өдрийн дотор харьяалах бүртгэх байгууллагад гаргана.

13.2.Бүртгэх байгууллага мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэлийн мэдээлэлтэй холбогдсон өөрчлөлтийг бүртгүүлэх өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор бүртгэх эсэхийг шийдвэрлэж, энэ тухай мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд мэдэгдэнэ.

13.3.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд үйл ажиллагаагаа зогсоохоор шийдвэрлэсэн бол энэ тухайгаа харьяалах бүртгэх байгууллагад даруй мэдэгдэж, гэрчилгээг хураалгана.

13.4.Энэ хуулийн 13.3-т заасны дагуу мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд үйл ажиллагаагаа зогсоох талаар гаргасан шийдвэрээ зээлийн гэрээ байгуулсан үйлчлүүлэгч бүрд мэдэгдэж, төлбөр тооцоог дуусгах үүрэгтэй.

14 дүгээр зүйл.Гэрчилгээг дахин авах өргөдөл гаргах

14.1.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд гэрчилгээг гэсэн, эсхүл үрэгдүүлсэн бол энэ тухай харьяалах бүртгэх байгууллагад даруй мэдэгдэж, гэрчилгээг дахин авах өргөдөл гаргана.

14.2.Энэ хуулийн 14.1-д заасан тохиолдолд харьяалах бүртгэх байгууллага ажлын гурван өдрийн дотор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд гэрчилгээг дахин олгоно.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ЗЭЭЛИЙН, БАРЬЦААНЫ БОЛОН
БАТЛАН ДААЛТЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ**

**15 дугаар зүйл.Зээлийн, барьцааны болон батлан
даалтын гэрээ байгуулах**

15.1.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд энэ хуулийн 17.4.1-д заасан зээлийн, барьцааны, батлан даалтын гэрээний ерөнхий загварыг үйл ажиллагаандаа хэрэглэнэ.

15.2.Зээлийн гэрээг бичгээр байгуулах бөгөөд түүнд дараах нөхцөлийг тусгасан байна:

15.2.1.мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн нэр, салбар, хаяг болон зээлдэгчийн нэр, хаяг;

15.2.2.гэрээ байгуулсан он, сар, өдөр;

15.2.3.зээлийн хэмжээ;

15.2.4.зээлийн хүүгийн хэмжээ, түүнийг бодох, тооцох аргачлал;

15.2.5.зээлийн эргэн төлөлтийн хуваарь;

15.2.6.дансны дугаар;

15.2.7.барьцаа, батлан даалт байх эсэх;

15.2.8.хугацаанаас өмнө эргэн төлөлт хийх нөхцөл;

15.2.9.нэмэгдүүлсэн хүү байх эсэх;

15.2.10.шаардлагатай бусад нөхцөл.

15.3.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд зээлийн гэрээ байгуулахдаа энэ хуулийн 15.2-т заасан нөхцөл бүрийг зээлдэгчид тайлбарлаж өгнө.

15.4.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд зээлийн гэрээтэй холбоотойгоор барьцааны, батлан даалтын гэрээ байгуулах тохиолдолд барьцаалуулагч, батлан даагчтай бичгээр гэрээ байгуулж зээлийн гэрээнд хавсаргана. Барьцааны болон батлан даалтын гэрээнд дараах нөхцөлийг тусгасан байна:

15.4.1.мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн нэр, салбар, хаяг болон зээлдэгчийн, барьцаалуулагчийн, батлан даагчийн нэр, хаяг;



- 15.4.2.гэрээ байгуулсан он, сар, өдөр;
- 15.4.3.барьцааны, батлан даалтын гэрээний хугацаа;
- 15.4.4.зээлийн хэмжээ;
- 15.4.5.барьцаалуулагчийн, батлан даагчийн хүлээсэн үүрэг;
- 15.4.6.барьцаа хөрөнгө, түүний үнэлгээ;
- 15.4.7.шаардлагатай бусад нөхцөл.

15.5.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд барьцааны, батлан даалтын гэрээ байгуулахдаа энэ хуулийн 15.4-т заасан нөхцөл бүрийг барьцаалуулагч, батлан даагчид тайлбарлаж өгнө.

15.6.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд зээлийн, барьцааны, батлан даалтын гэрээ болон бусад шаардлагатай баримт бичгийг зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэл хангагдсанаас хойш 3 жилийн хугацаанд хадгална.

15.7.Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд бүртгэлийн дэвтэр болон энэ хуулийн 5.1.7-д заасан цахим бүртгэлд зээлийн, барьцааны, батлан даалтын гэрээг барьцаа хөрөнгийн гэрэл зургийн хамт бүртгэнэ.

15.8.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэн зээлийн, барьцааны, батлан даалтын гэрээг гэрээ байгуулсан, өөрчлөлт оруулсан тухай бүрд бүртгэлийн дэвтэрт бүртгэнэ.

15.9.Энэ хуулийн 15.7, 15.8-д заасан бүртгэлийн дэвтрийн загвар, бүртгэлийн дэвтэр хөтлөх журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална.

15.10.Зээлийн, барьцааны болон батлан даалтын гэрээ байгуулахад аливаа шимтгэл, хураамж, эсхүл нэмэлт төлбөр авахыг мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хориглоно.

16 дугаар зүйл.Барьцаа хөрөнгө

16.1.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд барьцаа хөрөнгийг зээлдэгчтэй харилцан тохиролцож, бодитой үнэлнэ.

16.2.Цагдаагийн байгууллага гэмт хэрэг, зөрчлийн улмаас алдагдсан эд зүйлсийн талаарх мэдээллийг агуулсан цахим мэдээллийн сантай байх бөгөөд мэдээллийн санг ажиллуулахтай холбогдсон журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

16.3.Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд энэ хуулийн 16.2-т заасан цахим мэдээллийн санд бүртгэгдсэн эд зүйлсийг барьцаанд авахыг хориглоно.



16.4.Барьцаалан зээлдүүлэх газар энэ хуулийн 16.3-т заасан сэжиг бүхий эд зүйлсийн талаар цагдаагийн байгууллагад даруй мэдэгдэх үүрэгтэй.

16.5.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй зээлдэгчид барьцааны эрх хэрэгжүүлэх мэдэгдлийг хүргүүлэх бөгөөд барьцааны шаардлагыг хангах эцсийн боломжит хугацаа нь барьцааны эрх хэрэгжүүлэх мэдэгдлийг барьцаалуулагчид хүргүүлснээс, эсхүл гэрээнд заасны дагуу мэдэгдсэнээс хойш 14 хоног байна.

16.6.Иргэний хуулийн 159.2-т заасны дагуу барьцаалуулагч шаардсан бол барьцааны зүйлийг худалдахын өмнө түүний үнэлгээг шинжээчээр тогтоолгож болох бөгөөд холбогдох зардлыг барьцаалуулагч хариуцна.

16.7.Зээлдэгч энэ хуулийн 16.5-д заасан хугацаанд барьцааны шаардлагыг хангаагүй бол мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд барьцааны зүйлийг Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд⁴ заасан журмын дагуу худалдан борлуулж, уг орлогоос барьцааны шаардлагыг хангаж, үлдсэн хэсгийг барьцаалуулагчид олгоно.

ТАВДУГААР БҮЛЭГ МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ШААРДЛАГА, ХЯЗГААРЛАЛТ

17 дугаар зүйл. Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөл

17.1. Энэ хуульд заасан мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох, зохицуулах, холбогдох төрийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны дэргэд орон тооны бус Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/-ийг байгуулна.

17.2. Зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, ажиллах журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална.

17.3. Зөвлөлийн бүрэлдэхүүнд Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн захиргааны байгууллага, цагдаагийн төв байгууллага, Монголын үндэсний

⁴Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

худалдаа аж үйлдвэрийн танхим, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчид болон салбарын эрдэмтэн, судлаачдын төлөөллийг оролцуулна.

17.4.Зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

17.4.1.мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үйл ажиллагаанд хэрэглэх зээлийн, барьцааны, батлан даалтын гэрээний ерөнхий загварыг батлах;

17.4.2.мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох;

17.4.3.мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлалыг батлах;

17.4.4.хуульд заасан бусад.

17.5.Зөвлөлийн гаргасан шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хорооны олон нийтэд мэдээлэл хүргэх цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулна.

18 дугаар зүйл.Зээлийн хүү

18.1.Энэ хуулийн 17.4.2-т заасан зээлийн хүүгийн дээд хэмжээг барьцаат болон барьцаагүй зээлд ялгамжтай байдлаар тогтоож болно.

18.2.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс гэрээний үндсэн дээр зээлдэгчид олгосон мөнгөн хөрөнгийг ашигласны хариу төлбөр буюу үнийг хүү гэж тооцох бөгөөд зээлийн хүүг ашигласан хугацаагаар нь тооцно.

18.3.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд энэ хуулийн 17.4.2-т заасныг зөрчиж зээлийн гэрээ байгуулсан бол зээлийн хүүгийн дээд хэмжээнээс хэтэрсэн дүнгээр хүү авах эрхээ алдана.

18.4.Зээлдэгч энэ хуулийн 17.4.2-т заасан зээлийн хүүгийн дээд хэмжээнээс хэтрүүлэн хүү төлсөн бол илүү төлсөн дүнг үндсэн зээлийн төлбөрт тооцон суутгана. Ийнхүү үндсэн зээлийн төлбөрийг бүрэн суутгасны дараах үлдсэн хэсгийг зээлдэгчид эргүүлэн олгоно.

18.5.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээ үндсэн хүүгийн 20 хувиас хэтрэхгүй байна.



18.6.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээр бүртгүүлээгүй иргэн байнга, ашиг олох зорилгоор хүү тогтоосон зээлийн гэрээ байгуулж, зээл олгосон бол хүү авах эрхээ алдана.

18.7.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд зээлийн хүүг урьдчилан авахыг хориглоно.

19 дүгээр зүйл.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хориглох зүйл

19.1.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд дараах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

19.1.1.барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд бол мөнгөн зээлийн үйл ажиллагаанаас өөр үйл ажиллагаа эрхлэх;

19.1.2.барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд бол энэ хуулийн 5.1.6-д заасан ажлын байрны байршлыг бүртгэх байгууллагад бүртгүүлэлгүйгээр өөрчлөх;

19.1.3.барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд бол шөнийн 22:00 цагаас өглөөний 06:00 цаг хүртэл үйл ажиллагаа явуулах;

19.1.4.мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн тайлан тэнцэлд тусгаагүй мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг өөрийн үйл ажиллагаанд ашиглах;

19.1.5.иргэн, хуулийн этгээдэд хадгаламжийн болон түүнтэй адилтгах аливаа данс нээх;

19.1.6.энэ хуулийн 17.4.2-т заасан зээлийн хүүгийн дээд хэмжээнээс хэтэрсэн хүү тогтоох;

19.1.7.нэмэгдүүлсэн хүүг энэ хуулийн 18.5-д заасан хэмжээнээс хэтрүүлэн тогтоох;

19.1.8.анз хэрэглэх;

19.1.9.энэ хуулийн 5.1.3-т заасан банкны харилцах данснаас өөр дансанд мөнгөн зээл, түүний хүүг байршуулах;

19.1.10.энэ хуулийн 20.2-т заасан мэдээллийг дутуу, эсхүл буруу ташаа тусгасан зар сурталчилгаа хийх, мэдээлэл өгөх;

19.1.11.гэрчилгээгээ бусдад шилжүүлэх;
19.1.12.18 насанд хүрээгүй, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн хүнд үйлчлэх.

20 дугаар зүйл.Мөнгөн зээлийн үйл ажиллагааг сурталчлах

20.1.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд энэ хуулийн 20.2-т заасан мэдээллийг агуулсан зар сурталчилгааг байршуулж болно.

20.2.Зар сурталчилгаанд дараах мэдээллийг тусгана:

20.2.1.мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн нэр;
20.2.2.мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувийн дугаар;
20.2.3.мөнгөн зээлийн хүүгийн болон нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээ;
20.2.4.хугацаанаас өмнө эргэн төлөлт хийх талаарх нөхцөл;
20.2.5.харилцах утасны дугаар, байршил.

21 дүгээр зүйл.Хэрэглэгчийг хамгаалах дотоод журам

21.1.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд хэрэглэгчийг хамгаалах зорилгоор холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн дотоод журам тогтоож, үйл ажиллагаандаа мөрдүүлнэ.

21.2.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд энэ хуулийн 5.1.6-д заасан ажлын байрандаа хуулийн этгээдийн нэр бүхий хаяг, зээлийн хүүгийн болон нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээ, зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлал болон гэрчилгээг ил харагдахуйц байдлаар байршуулна.

22 дугаар зүйл.Зээлдэгчид учирсан хохирлыг нөхөн төлөх хариуцлага

22.1.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд санаатай, эсхүл болгоомжгүй үйлдлээр зээлдэгчид хохирол учруулсан бол хохирлыг бүрэн барагдуулна.

22.2.Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд барьцаалуулагчтай харилцан тохиролцож барьцаа хөрөнгийг эд хөрөнгийн даатгалд даатгуулж болно.

**ЗУРГАДУГААР БҮЛЭГ
МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ТАВИХ ХЯНАЛТ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

23 дугаар зүйл. Мөнгөн зээлийн үйл ажиллагаанд тавих хяналт

23.1. Мөнгөн зээлийн үйл ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавина.

23.2. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтыг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн⁵ 24.2-т заасан хянан шалгагч хийнэ.

23.3. Аймаг, нийслэлийн Засаг даргын хүсэлт, эсхүл иргэн, хуулийн этгээдийн гомдлын дагуу Санхүүгийн зохицуулах хорооны даргын томилсон хянан шалгагч хяналт шалгалт хийж болно.

23.4. Аймагт хянан шалгагчийн үүрэг хавсран гүйцэтгэх этгээдийг Санхүүгийн зохицуулах хорооны дарга Засаг даргатай зөвшилцөн томилох бөгөөд хянан шалгагчийн үүрэг хавсран гүйцэтгэх этгээд улсын байцаагчийн эрхтэй байна.

23.5. Хянан шалгагч хяналт шалгалт хийж дууссаны дараа харьяалах бүртгэх байгууллагад хяналт шалгалтын тайланг хүргүүлнэ.

23.6. Харьяалах бүртгэх байгууллага хяналт шалгалтын дүнгээс хамаарч гарсан алдаа, зөрчлийг арилгах талаар хугацаатай үүрэг даалгаврыг мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд өгч, биелэлтийг хангуулна.

23.7. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд холбогдох хуульд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.

23.8. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд дараах мэдээллийг тусгасан, хагас, бүтэн жилийн тайланг гаргаж, дараа сарын 20-ны өдрийн дотор харьяалах бүртгэх байгууллагад хүргүүлнэ:

23.8.1. олгосон зээлийн, эргэн төлөлтийн болон үлдэгдлийн хэмжээ;

⁵Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2005 оны 46 дугаарт нийтлэгдсэн.

23.8.2.зээл авсан зээлдэгчийн тоо;

23.8.3.барьцаалсан эд хөрөнгийн төрөл, тоо, нийт үнэлгээ;

23.8.4.мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон шаардлагатай бусад мэдээлэл.

23.9.Энэ хуулийн 23.8-д заасан тайланг Санхүүгийн зохицуулах хорооны баталсан маягт, зааврын дагуу гаргана.

24 дүгээр зүйл.Мөнгөн зээлийн үйл ажиллагааг түдгэлзүүлэх

24.1.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд энэ хуулийн 23.6-д заасан хугацаанд алдаа, зөрчлийг арилгаагүй бол харьяалах бүртгэх байгууллага тухайн этгээдийн үйл ажиллагааг 1 хүртэлх жилийн хугацаагаар түдгэлзүүлнэ.

25 дугаар зүйл.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэлийг хүчингүй болгох

25.1.Харьяалах бүртгэх байгууллага дараах тохиолдолд мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэлийг хүчингүй болгоно:

25.1.1.хуурамч баримт бичиг ашиглан бүртгүүлсэн нь тогтоогдсон;

25.1.2.энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангахгүй болсон;

25.1.3.үйл ажиллагаагаа зургаан сараас дээш хугацаагаар тасралтгүй явуулаагүй;

25.1.4.энэ хуулийн 19.1-д заасан хориглосон үйл ажиллагааг хоёр ба түүнээс дээш удаа явуулсан;

25.1.5.энэ хуулийн 24.1-д заасны дагуу үйл ажиллагааг түдгэлзүүлэх шийдвэрийг зөрчсөн, эсхүл алдаа, зөрчлийг арилгаагүй бол;

25.1.6.тухайн этгээдийн оршин байгаа газрыг тодорхойлох боломжгүй болсон бөгөөд харьяалах бүртгэх байгууллага хаягийг тодруулахаар нийтэд зарласнаас хойш 30 хоногийн хугацаа өнгөрсөн;

25.1.7.энэ хуулийн 13.3-т заасны дагуу гэрчилгээгээ хураалгасан бол.

25.2.Харьяалах бүртгэх байгууллага энэ хуулийн 25.1-д заасан шийдвэр гаргахаас өмнө сонсох ажиллагааг явуулна.

25.3.Дараах тохиолдолд сонсох ажиллагааг явуулахгүй байж болно:

25.3.1.мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд сонсох ажиллагаа явуулах шаардлагагүй гэдгээ илэрхийлсэн;

25.3.2.Захиргааны ерөнхий хуулийн⁶ 28.1-д заасан үндэслэл байгаа бол.

25.4.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэлийг энэ хуулийн 25.1-д заасны дагуу хүчингүй болгосноос хойш 5 жилийн дотор тухайн этгээдийг бүртгэлд бүртгэхгүй.

25.5.Харьяалах бүртгэх байгууллага энэ хуулийн 24.1, 25.1-д заасан шийдвэрийн хувь хүн, байгууллагын нууцтай холбоотой мэдээллээс бусад мэдээллийг тухайн шийдвэр гарсны дараах өдөр олон нийтэд мэдээлэл хүргэх цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулна.

26 дугаар зүйл.Маргаан шийдвэрлэх

26.1.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн болон үйлчлүүлэгчийн хооронд маргаан гарсан тохиолдолд талууд шүүхэд хандаж болно.

ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД

27 дугаар зүйл.Иргэдийг мэдээллээр хангах

27.1.Санхүүгийн зохицуулах хороо мөнгөн зээлийн үйл ажиллагаатай холбогдсон мэдээллээр иргэдийг хангах, холбогдох хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна.

28 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

28.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд⁷ заасан хариуцлага хүлээлгэнэ.

28.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд⁸ заасан хариуцлага хүлээлгэнэ.

⁶Захиргааны ерөнхий хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

⁷Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

⁸Зөрчлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

29 дүгээр зүйл. Дагаж мөрдөх журмын зохицуулалт

29.1. Талууд өөрөөр тохиролцоогүй бол энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө байгуулагдсан барьцаалан зээлдүүлэх газар, иргэнээс олгосон зээлийн гэрээнд энэ хууль хамаарахгүй.

29.2. Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан үйл ажиллагаа явуулж байгаа барьцаалан зээлдүүлэх газар энэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш 1 жилийн дотор харьяалах бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

30 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

30.1. Энэ хуулийг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Зүйл 29-ийн хүчин мөрдөх журмын зохицуулалт

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 03 сарын 01-н өдөр / 1170/2023

Зүйл 30-ийн хүчин мөрдөх журмын зохицуулалт
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Зүйл 30-ийн хүчин мөрдөх журмын зохицуулалт
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

6 сарын 2023 он / Зүйл 30-ийн хүчин мөрдөх журмын зохицуулалт

Зүйл 29-ийн хүчин мөрдөх журмын зохицуулалт
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
Зүйл 30-ийн хүчин мөрдөх журмын зохицуулалт
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
Зүйл 30-ийн хүчин мөрдөх журмын зохицуулалт
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

7 сарын 2023 он / Зүйл 30-ийн хүчин мөрдөх журмын зохицуулалт
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

8 сарын 2023 он / Зүйл 30-ийн хүчин мөрдөх журмын зохицуулалт
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
Зүйл 30-ийн хүчин мөрдөх журмын зохицуулалт
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
Зүйл 30-ийн хүчин мөрдөх журмын зохицуулалт
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА



66. 66 . هختمدرا هختمپهپتر ا بنر ريعن لأم 66 - 6 . فو خنئسپ هختمرا بن ريعهئسكن . زهوه زجرم . وخنتمپهپتر ا لأم لئتمتر بن ريعهئسكن يكلهپ ا لأم ههممر يكلهپ ا ز ريعهئسكو بلصهئ نئصصم و مئنئرب لآمن لآمنر فو يكلهپ زجررا تارنر رئنئسكو . يكلهپ ا لأم يبيرون ا فو وخنتمپهپتر ا ..

70. 70 . يدمزم لآلهپ لأم بللير بءعپئتر ا لآلهپه بكنمر مرم هختمرا م بللير بءعپئتر فو لآلهپه يكئسكو . خنئسئن . هختمرا لئكمرا لئمم . لآكئير و لآسئو ن بلسرور لأم لآركئسيقو زملل ا وكمپير ا ..

76 كئنئن لأملا .. هختمرا فو هختمرههپرا لآمنن بكنمر فو بيوهئسكو لآكئنئسيقو

6. 76 . هختمرا فو هختمرههپرا لآمنن بكنمر يدمزم لآلهپ لأم بللير بءعپئتر ا لآلهپه . بلسرور ا يدمزم لآلهپ لأم بللير بءعپئتر و لأم ا همن بكمپيركئتر ا زو لآ رنكئير ا ..

706 كئنئن لأملا .. يدمزم لآلهپ لأم بللير بءعپئتر ا لآلهپه بكنمر مرم هختمرا فو لآمنكئسيقو لآمنئسيقو

706 . 6 . يدمزم لآلهپ لأم بللير بءعپئتر ا لآلهپه بكنمر لأم ريعن لأم 66 - 6 . فو خنئسپ هختمرا مرم يكلهپ بن ريعهئسكو لآمن بءعپئتر مرم هختمرههپرا بلسرور ن بلسن لأم يكلهپ فو لآمنكئسيقو لآمنئسيقو بلكمر يكلهپ لآلهپ لأم رنكئير ا فو رنكئير ا ..

70 . 70 . هختمرا وخنتمپهپتر ا يدمزم لآلهپ لأم بللير بءعپئتر ا لآلهپه بكنمر مرم هختمرا مرم يكلهپ بن ريعهئسكو لآمن بءعپئتر مرم هختمرههپرا بلسرور ن بلسن لأم يكلهپ فو لآمنكئسيقو لآمنئسيقو بلكمر يكلهپ لآلهپ لأم رنكئير ا فو رنكئير ا ..

70 . 70 . يدمزم لآلهپ لأم بللير بءعپئتر ا لآلهپه بكنمر بلكمر بءعپئتر ا لآمن همر لآمنئسئق وبن بلصهئبءير هختمرا فو لأم همن لآمن همر هختمرا وخنتمپهپتر ا فو مئسن يكلهكف . لآكئير لآ رنكئير لآ رنكئير ..

0 . 70 . بنر ريعن لأم 70 - 70 . فو خنئسپ و بئئئقو يدمزم لآلهپ لأم بللير بءعپئتر ا لآلهپه بكنمر بلكمر بءعپئتر ا لآمن همر لآمنئسئق وبن ا فو رنكئير بءعپئتر همر هختمرا لآ رنكئير ا وخنتمپهپتر بلكمر بءعپئتر همن فو يكلهكف . بلصهئقو لآمنئسئق ا لآمن بئئسئسكو بلرول ا مرم ..



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 11 дүгээр
сарын 04-ний өдөр

Улаанбаатар
хот

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан үйл ажиллагаа явуулж байгаа барьцаалан зээлдүүлэх газрын гүйцэтгэх удирдлага, менежер нь уг хууль хүчин төгөлдөр болсноос хойш 1 жилийн дотор мөнгөн зээлийн үйл ажиллагааны журмын талаарх сургалтад үнэ төлбөргүй хамрагдана.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

УИХ-ЫН
СЭВЭГ

УИХ-ЫН СЭВЭГ 2022 ОНЫ 11 САРЫН 04 - ӨДӨН

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

6. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан үйл ажиллагаа явуулж байгаа барьцаалан зээлдүүлэх газрын гүйцэтгэх удирдлага, менежер нь уг хууль хүчин төгөлдөр болсноос хойш 1 жилийн дотор мөнгөн зээлийн үйл ажиллагааны журмын талаарх сургалтад үнэ төлбөргүй хамрагдана.

7. Энэ хуулийг Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

УИХ-ЫН
СЭВЭГ 2022 ОНЫ 11 САРЫН 04 - ӨДӨН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 11 дүгээр
сарын 04-ний өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний хуулийн 452 дугаар зүйлийн 452.2 дахь хэсгийн “эрх бүхий” гэсний дараа “этгээд, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Иргэний хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/282 дугаар зүйлийн 282.1 дэх хэсэг:

“282.1.Нэг удаагийн шинжтэй, эсхүл ашиг олох зорилгогүй зээлийн гэрээгээр талууд хэлэлцэн тохиролцож хүү тогтоож болно.”

2/286 дугаар зүйл:

“286 дугаар зүйл.Барьцаалан зээлдүүлэх журмаар болон иргэнээс байнга, ашиг олох зорилгоор зээл олгох

286.1.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох мөнгөн зээлийн үйл ажиллагааг хуулиар зохицуулна.

286.2.Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаанд зөвхөн хөдлөх хөрөнгө барьцаална.”

3 дугаар зүйл.Иргэний хуулийн 283 дугаар зүйлийн 283.3, 283.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



Зөвшөөрч хэргийг үргэлжлүүлэх

Хүндэтгэсэн хэргийг үргэлжлүүлэх

2020 оны 66 дугаар хууль болон 2020 - оны 66 дугаар хууль

Хууль болон 2020 оны 66 дугаар хууль болон 2020 - оны 66 дугаар хууль

6 дугаар хууль болон 2020 оны 66 дугаар хууль болон 2020 - оны 66 дугаар хууль
Хууль болон 2020 оны 66 дугаар хууль болон 2020 - оны 66 дугаар хууль

7 дугаар хууль болон 2020 оны 66 дугаар хууль болон 2020 - оны 66 дугаар хууль

8 дугаар хууль болон 2020 оны 66 дугаар хууль болон 2020 - оны 66 дугаар хууль

9 дугаар хууль болон 2020 оны 66 дугаар хууль болон 2020 - оны 66 дугаар хууль
Хууль болон 2020 оны 66 дугаар хууль болон 2020 - оны 66 дугаар хууль

10 дугаар хууль болон 2020 оны 66 дугаар хууль болон 2020 - оны 66 дугаар хууль

11 дугаар хууль болон 2020 оны 66 дугаар хууль болон 2020 - оны 66 дугаар хууль

12 дугаар хууль болон 2020 оны 66 дугаар хууль болон 2020 - оны 66 дугаар хууль

13 дугаар хууль болон 2020 оны 66 дугаар хууль болон 2020 - оны 66 дугаар хууль

14 дугаар хууль болон 2020 оны 66 дугаар хууль болон 2020 - оны 66 дугаар хууль
Хууль болон 2020 оны 66 дугаар хууль болон 2020 - оны 66 дугаар хууль

15 дугаар хууль болон 2020 оны 66 дугаар хууль болон 2020 - оны 66 дугаар хууль
Хууль болон 2020 оны 66 дугаар хууль болон 2020 - оны 66 дугаар хууль

Хууль болон 2020 оны 66 дугаар хууль болон 2020 - оны 66 дугаар хууль

Хууль болон 2020 оны 66 дугаар хууль болон 2020 - оны 66 дугаар хууль



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 11 дүгээр
сарын 04-ний өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.Талууд өөрөөр тохиролцоогүй бол 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр баталсан Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар зохицуулсан харилцаа нь уг хууль хүчин төгөлдөр болохоос өмнө байгуулагдсан барьцаалан зээлдүүлэх газар, иргэнээс олгох зээлд хамаарахгүй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ
ᠶ᠋ᠢᠷᠭᠡᠨᠢᠶ᠋ᠨ ᠬᠤᠷᠤᠯᠠᠨ
ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠷᠭᠡᠨᠢᠶ᠋ᠨ ᠬᠤᠷᠤᠯᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠷᠭᠡᠨᠢᠶ᠋ᠨ ᠬᠤᠷᠤᠯᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠷᠭᠡᠨᠢᠶ᠋ᠨ ᠬᠤᠷᠤᠯᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠷᠭᠡᠨᠢᠶ᠋ᠨ ᠬᠤᠷᠤᠯᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠷᠭᠡᠨᠢᠶ᠋ᠨ ᠬᠤᠷᠤᠯᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 11 дүгээр
сарын 04-ний өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд 132³ дугаар зүйл нэмсүгэй:

“132³ дугаар зүйл.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн гэрээтэй холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх

132³.1.Шүүгч мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн гэрээтэй холбогдолтой хэргийг хянан шийдвэрлэхдээ зохигчид эвлэрүүлэн зуучлалын журмаар эвлэрэх хугацаа зааж, нэхэмжлэлийг эвлэрүүлэн зуучлагчид шилжүүлэх арга хэмжээг урьдчилан авахаар захирамж гаргаж болно.

132³.2.Зохигчид эвлэрвэл шүүгч эвлэрлийн гэрээг баталгаажуулсан захирамж гарган хэргийг хэрэгсэхгүй болгох бөгөөд талууд, зохигч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, тухайн асуудлаар анхан шатны шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхгүй.

132³.3.Энэ хуулийн 132³.1-д заасан эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтад хүрээгүй бол эвлэрүүлэн зуучлагч нэхэмжлэлийг шүүхэд шилжүүлнэ.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 11 дүгээр
сарын 04-ний өдөр

Улаанбаатар
хот

МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.11 дэх заалт нэмсүгэй:

“4.1.11. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд заасан мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд заасан мөнгөн зээлийн үйл ажиллагааг эрхлэх этгээд.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд заасан мөнгөн зээлийн үйл ажиллагааг эрхлэх этгээд.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 11 дүгээр
сарын 04-ний өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай
11.34 дүгээр зүйл нэмсүгэй:

“11.34.Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль зөрчих

1.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь:

1.1.мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн
тайлан тэнцэлд тусгаагүй мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг өөрийн үйл
ажиллагаанд ашигласан;

1.2.зээлийн хүүгийн дээд хэмжээнээс хэтэрсэн хүү
тогтоосон;

1.3.нэмэгдүүлсэн хүүг хэтрүүлэн тогтоосон;

1.4.анз хэрэглэсэн;

1.5.мөнгөн зээлийн үйл ажиллагаанд зориулсан банкны
харилцах данснаас өөр дансанд мөнгөн зээл, түүний хүүг байршуулсан;

1.6.мөнгөн зээлийн үйл ажиллагааны зар сурталчилгааг
дутуу, эсхүл буруу ташаа мэдээлэл агуулсан байдлаар хийсэн;

1.7.гэрчилгээгээ бусдад шилжүүлсэн;

1.8.зээлийн гэрээ байгуулсны шимтгэл, хураамж, эсхүл
нэмэлт төлбөр авсан;

1.9.зээлийн хүүг урьдчилан авсан бол учруулсан хохирол,
нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний
төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний
төгрөгөөр торгоно.

2.Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл
ажиллагаа эрхлэх этгээд нь:

2.1.мөнгөн зээлийн үйл ажиллагаанаас өөр үйл ажиллагаа
эрхэлсэн;



2.2. ажлын байрны байршлыг бүртгэх байгууллагад бүртгүүлэлгүйгээр өөрчилсөн;

2.3. барьцааны эрх хэрэгжүүлэх мэдэгдлийг хүргээгүй, эсхүл барьцааны шаардлагыг хангах эцсийн боломжит хугацааг хангаагүй;

2.4. барьцааны зүйлийг худалдан борлуулсан орлогоос үлдсэн хэсгийг барьцаалуулагчид олгоогүй;

2.5. үйл ажиллагаагаа зогсоох талаар гаргасан шийдвэрээ зээлийн гэрээ байгуулсан үйлчлүүлэгч бүрд мэдэгдээгүй, төлбөр тооцоог дуусгаагүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Иргэн, хуулийн этгээд нь бүртгүүлэхгүйгээр мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхэлсэн, эсхүл бүртгүүлэхгүйгээр нэрэндээ “зээлийн үйлчилгээ”, “барьцаалан зээлдүүлэх газар” гэсэн тэмдэглэгээ, эсхүл түүнтэй төсөөтэй тэмдэглэгээ хэрэглэсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4. Иргэн, хуулийн этгээд нь бүртгүүлэхгүйгээр мөнгөн зээлийн үйл ажиллагааны талаар зар сурталчилгаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

УВСНАЙЦ АЖИРАА ГАРГАХ

Ургалд тохирсон ажлыг

2021 он, 6-р сар 05 - 06 - ныг

Төрийн мэдээлэл

6. Үйлдвэр, ус, цахилгаан, хичээлийн байр, үйлдвэр, ус, цахилгаан, хичээлийн байр

6. 6. Өөрийн үйлдвэр, ус, цахилгаан, хичээлийн байр, үйлдвэр, ус, цахилгаан, хичээлийн байр

6. 6. Өөрийн үйлдвэр, ус, цахилгаан, хичээлийн байр, үйлдвэр, ус, цахилгаан, хичээлийн байр

6. 6. Өөрийн үйлдвэр, ус, цахилгаан, хичээлийн байр, үйлдвэр, ус, цахилгаан, хичээлийн байр

6. 6. Өөрийн үйлдвэр, ус, цахилгаан, хичээлийн байр, үйлдвэр, ус, цахилгаан, хичээлийн байр

6. 6. Өөрийн үйлдвэр, ус, цахилгаан, хичээлийн байр, үйлдвэр, ус, цахилгаан, хичээлийн байр

6. 6. Өөрийн үйлдвэр, ус, цахилгаан, хичээлийн байр, үйлдвэр, ус, цахилгаан, хичээлийн байр

6. 6. Өөрийн үйлдвэр, ус, цахилгаан, хичээлийн байр, үйлдвэр, ус, цахилгаан, хичээлийн байр

6. 6. Өөрийн үйлдвэр, ус, цахилгаан, хичээлийн байр, үйлдвэр, ус, цахилгаан, хичээлийн байр

6. 6. Өөрийн үйлдвэр, ус, цахилгаан, хичээлийн байр, үйлдвэр, ус, цахилгаан, хичээлийн байр

6. 6. Өөрийн үйлдвэр, ус, цахилгаан, хичээлийн байр, үйлдвэр, ус, цахилгаан, хичээлийн байр

6. 6. Өөрийн үйлдвэр, ус, цахилгаан, хичээлийн байр, үйлдвэр, ус, цахилгаан, хичээлийн байр

6. 6. Өөрийн үйлдвэр, ус, цахилгаан, хичээлийн байр, үйлдвэр, ус, цахилгаан, хичээлийн байр

6. 6. Өөрийн үйлдвэр, ус, цахилгаан, хичээлийн байр, үйлдвэр, ус, цахилгаан, хичээлийн байр

6. 6. Өөрийн үйлдвэр, ус, цахилгаан, хичээлийн байр, үйлдвэр, ус, цахилгаан, хичээлийн байр

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 11 дүгээр
сарын 04-ний өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.18 дахь заалтын “11.33,” гэсний дараа “11.34,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠒᠐᠒᠒

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠒᠐᠒᠒ ᠒᠐᠒᠒ ᠒᠐᠒᠒
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠒᠐᠒᠒ ᠒᠐᠒᠒ ᠒᠐᠒᠒
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠒᠐᠒᠒ ᠒᠐᠒᠒ ᠒᠐᠒᠒

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠒᠐᠒᠒ ᠒᠐᠒᠒ ᠒᠐᠒᠒
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠒᠐᠒᠒ ᠒᠐᠒᠒ ᠒᠐᠒᠒

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠒᠐᠒᠒ ᠒᠐᠒᠒ ᠒᠐᠒᠒
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠒᠐᠒᠒ ᠒᠐᠒᠒ ᠒᠐᠒᠒



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр

Улаанбаатар хот

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН БАРЬЦААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.2 дахь хэсэг нэмсүгэй:

“6.2. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 12.1-д заасан этгээдээс олгосон зээлийн гэрээг бүртгэхгүй.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

ЮСЭНГ СЭМЖ МР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЫН ГАРГАЖ ИРЭХ 2022 ОНЫ 05 - 06 КӨНӨН ДЭНГЭР 10101

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЫН ГАРГАЖ ИРЭХ 2022 ОНЫ 05 - 06 КӨНӨН ДЭНГЭР 10101

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЫН ГАРГАЖ ИРЭХ 2022 ОНЫ 05 - 06 КӨНӨН ДЭНГЭР 10101

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЫН ГАРГАЖ ИРЭХ 2022 ОНЫ 05 - 06 КӨНӨН ДЭНГЭР 10101

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЫН ГАРГАЖ ИРЭХ 2022 ОНЫ 05 - 06 КӨНӨН ДЭНГЭР 10101

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЫН ГАРГАЖ ИРЭХ 2022 ОНЫ 05 - 06 КӨНӨН ДЭНГЭР 10101

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЫН ГАРГАЖ ИРЭХ 2022 ОНЫ 05 - 06 КӨНӨН ДЭНГЭР 10101



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 11 дүгээр
сарын 04-ний өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 18¹ дүгээр зүйл нэмсүгэй:

“18¹ дүгээр зүйл. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

18^{1.1}. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох болон иргэнээс байнга, ашиг олох зорилгоор олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн этгээдэд гэрчилгээ олгоход 100 000-250 000 төгрөгийн хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠤᠯᠤᠰ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠤᠯᠤᠰ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠤᠯᠤᠰ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠤᠯᠤᠰ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠤᠯᠤᠰ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠤᠯᠤᠰ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠤᠯᠤᠰ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠤᠯᠤᠰ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 11 дүгээр
сарын 04-ний өдөр

Улаанбаатар
хот

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 6.1.13 дахь заалт:

“6.1.13.иргэдэд санхүүгийн мэдлэг олгох ажлыг зохион байгуулах.”

2/6 дугаар зүйлийн 6.2.9 дэх заалт:

“6.2.9.Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд заасан.”

2 дугаар зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийн “зүйлд” гэснийг “зүйл, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Төрийн мэдээлэл

Мэргэжлийн гүйцэтгэлийн үйлчилгээний төв

Төрийн мэдээлэл 66 өдөр 00 - 00 өдөр

Төрийн мэдээлэл үйлчилгээний төвөөс болон төрийн мэдээлэл үйлчилгээний төвөөс
Төрийн мэдээлэл үйлчилгээний төвөөс болон төрийн мэдээлэл үйлчилгээний төвөөс

6. Төрийн мэдээлэл үйлчилгээний төвөөс болон төрийн мэдээлэл үйлчилгээний төвөөс
Төрийн мэдээлэл үйлчилгээний төвөөс болон төрийн мэдээлэл үйлчилгээний төвөөс :

6 | 6. Төрийн мэдээлэл үйлчилгээний төвөөс болон төрийн мэдээлэл үйлчилгээний төвөөс :

6 | 6. Төрийн мэдээлэл үйлчилгээний төвөөс болон төрийн мэдээлэл үйлчилгээний төвөөс :

6 | 6. Төрийн мэдээлэл үйлчилгээний төвөөс болон төрийн мэдээлэл үйлчилгээний төвөөс :

6 | 6. Төрийн мэдээлэл үйлчилгээний төвөөс болон төрийн мэдээлэл үйлчилгээний төвөөс :

7. Төрийн мэдээлэл үйлчилгээний төвөөс болон төрийн мэдээлэл үйлчилгээний төвөөс
Төрийн мэдээлэл үйлчилгээний төвөөс болон төрийн мэдээлэл үйлчилгээний төвөөс :

8. Төрийн мэдээлэл үйлчилгээний төвөөс болон төрийн мэдээлэл үйлчилгээний төвөөс
Төрийн мэдээлэл үйлчилгээний төвөөс болон төрийн мэдээлэл үйлчилгээний төвөөс :

Төрийн мэдээлэл үйлчилгээний төвөөс болон төрийн мэдээлэл үйлчилгээний төвөөс

Төрийн мэдээлэл үйлчилгээний төвөөс болон төрийн мэдээлэл үйлчилгээний төвөөс



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 12 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар 73

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэл”-ийн зэрэг зиндаа ТӨ-III-ийн тусгай албан тушаалын “Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч” гэсний дараа “, Монгол Улсын Ерөнхий прокурор” гэж нэмсүгэй.

2.“Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэл”-ийн зэрэг зиндаа ТӨ-IV-ийн тусгай албан тушаалын “, Монгол Улсын Ерөнхий прокурор” гэснийг хассугай.

3.Энэ тогтоолыг 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 12 дугаар сарын 08-ны өдөр

Дугаар 76

Улаанбаатар хот

Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хилийн боомтуудаар ачаа, тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалгахаар Монгол Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор байгуулсан Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг 2022 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс зургаан сараар сунгасугай.

2.Энэ тогтоолыг 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 10 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 204

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийн 40.2.9 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 241 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрсэн Төмөрпүрэвийн Жаргалсайханыг Говь-Алтай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 10 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 205

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийн 40.2.9 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 242 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрсэн Данзангийн Сарантуяаг Говь-Алтай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 11 дүгээр
сарын 03-ны өдөр

Дугаар 208

Улаанбаатар
хот

Албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Цэргийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлт гаргасан Довчинсүрэнгийн Ганзоригийг Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 11 дүгээр
сарын 03-ны өдөр

Дугаар 209

Улаанбаатар
хот

Албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 13 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Зэвсэгт хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Сүнрэвийн Ганбямбыг Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 11 дүгээр
сарын 03-ны өдөр

Дугаар 210

Улаанбаатар
хот

Албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Зэвсэгт хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.14 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Сүнрэвийн Ганбямбыг Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын нэгдүгээр орлогч даргын албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 11 дүгээр
сарын 04-ний өдөр

Дугаар 211

Улаанбаатар
хот

Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 307 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1.Төрбатын Шинэбаярыг Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

2.Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилогдсонтой холбогдуулан Төрбатын Шинэбаярыг Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 6 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 247

Улаанбаатар
хот

Үндэсний хорооны ажиллах журам, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 14.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хорооны ажиллах журам”-ыг 1 дүгээр хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг баталсан “Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай” Засгийн газрын 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 27 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтыг энэ тогтоолын 2 дугаар хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.

3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хорооны ажиллах журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Зөвлөлийн бүрэлдэхүүн, журам батлах тухай” Засгийн газрын 2003 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 52 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Х.НЯМБААТАР



Засгийн газрын 2022 оны 247 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хороо (цаашид “Үндэсний хороо” гэх)-ны үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Үндэсний хороо нь Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий байгууллагын төлөөллөөс бүрдсэн үндэсний хэмжээний орон тооны бус зохион байгуулалтын нэгж байна.

1.3.Үндэсний хороо нь үйл ажиллагаандаа Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журмыг баримтална.

Хоёр.Үндэсний хорооны бүрэлдэхүүн зохион байгуулалт

2.1.Үндэсний хороо нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

2.2.Үндэсний хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

2.3.Үндэсний хорооны ээлжит хуралдааныг хагас жил тутам хийнэ. Үндэсний хорооны нийт гишүүдийн олонх оролцоноор хуралдааныг хүчинтэйд тооцно. Үндэсний хорооны ээлжит бус хуралдааныг даргын санаачилгаар, эсхүл Үндэсний хорооны гишүүдийн олонхын саналаар хуралдуулж болно.

2.4.Үндэсний хорооны даргын эзгүйд даргын эрх олгосноор Үндэсний хорооны аль нэг гишүүн түүний үүргийг гүйцэтгэнэ.

2.5.Үндэсний хорооны хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд асуудлыг хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

2.6. Үндэсний хороо нь чиг үүргийнхээ хүрээнд хуралдаанаас тогтоол, зөвлөмж гаргах бөгөөд тогтоол, зөвлөмжид Үндэсний хорооны дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

2.7. Үндэсний хорооны хуралдааны тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтөлж, түүнд Үндэсний хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

Гурав. Үндэсний хорооны чиг үүрэг

3.1. Үндэсний хороо Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 14.5 дахь хэсэгт заасан чиг үүргээс гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих үйл ажиллагааны жил бүрийн төлөвлөгөөг хуралдаанаар хэлэлцэн баталж, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах;

3.1.2. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт болон энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох судалгааны ажлыг мэргэжлийн байгууллага болон эрдэмтэн судлаачдын бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж, гарсан дүгнэлт, саналыг холбогдох байгууллагад хүргүүлэх;

3.1.3. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, холбогдох байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай мэдээллийг гаргуулах;

3.1.4. төлөвлөгөөний хэрэгжилтийн салбар дундын уялдаа холбоог зохицуулах;

3.1.5. төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүн, тайланг улсын хэмжээнд нэгтгэн дүгнэж, дүнг жил бүр Засгийн газарт танилцуулах;

3.1.6. энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд орчин үеийн дэвшилтэт техник, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх ажлыг судлах, зохион байгуулах;

3.1.7. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөл, энэ төрлийн гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулахад чиглэсэн соён гэгээрүүлэх нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, мэдээлэл, сурталчилгааг зохион байгуулах.



Дөрөв.Үндэсний хорооны дарга, гишүүний бүрэн эрх

4.1.Үндэсний хорооны дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.1.1.Үндэсний хорооны ээлжит болон ээлжит бус хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тогтоож, хуралдааныг товлох, даргалах;

4.1.2.Үндэсний хороог дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;

4.1.3.Үндэсний хорооны гишүүдэд үүрэг, даалгавар өгч, биелэлтэд хяналт тавих;

4.1.4.Үндэсний хорооны үйл ажиллагааны тайланг Засгийн газрын хуралдаанд танилцуулах.

4.2.Үндэсний хорооны гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.2.1.Үндэсний хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг санаачлах, хэлэлцүүлэх, хуралдаанд өөрийн биеэр оролцох;

4.2.2.Үндэсний хорооны шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хариуцсан салбар, чиглэлийн дагуу хяналт тавих, тайлагнах;

4.2.3.Үндэсний хорооны даргын өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах, хариуцсан салбар, чиглэлийн дагуу Үндэсний хороонд холбогдох мэдээ, тайлан, статистик тоо баримтыг гаргаж өгөх;

4.2.4.Үндэсний хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд санал өгөх, төлөвлөгөө, тайлантай танилцах, Үндэсний хорооноос хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл авах;

4.2.5.Үндэсний хорооны ажлын албатай үйл ажиллагаагаа уялдуулах, мэдээлэл солилцох зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг өөрийн байгууллагын холбогдох албан хаагчаар хариуцуулан гүйцэтгүүлэх.

4.3.Үндэсний хорооны нарийн бичгийн дарга нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга байх бөгөөд Үндэсний хорооны гишүүний чиг үүргийг хэрэгжүүлнэ.



4.4. Үндэсний хорооны гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцох боломжгүй тохиолдолд хуралдаанаар хэлэлцэх асуудлын талаарх саналаа урьдчилан бичгээр хүргүүлнэ.

Тав. Үндэсний хорооны ажлын алба

5.1. Үндэсний хороо нь ажлын алба (цаашид “Ажлын алба” гэх)-тай байх бөгөөд Ажлын албаны үүргийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба гүйцэтгэнэ.

5.2. Ажлын алба нь Үндэсний хорооны өдөр тутмын ажлыг хариуцан гүйцэтгэх бөгөөд Үндэсний хорооны нарийн бичгийн дарга Ажлын албыг удирдана.

5.3. Ажлын алба дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.3.1. Үндэсний хорооны жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хорооны хуралдаанаар батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

5.3.2. Үндэсний хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг боловсруулж, Үндэсний хорооны даргаар батлуулах;

5.3.3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх талаар болон холбогдох хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр, Үндэсний хорооны шийдвэрийг холбогдох албан тушаалтан, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын хэрэгжүүлж байгаа байдалд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;

5.3.4. Үндэсний хорооны үйл ажиллагаанд шаардагдах тайлан, мэдээ, статистик, тоо баримт, лавлагааг холбогдох байгууллагаас гаргуулах, танилцуулах;

5.3.5. Үндэсний хорооны хуралдааныг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах, Үндэсний хорооны шийдвэрийг албажуулах;

5.3.6. Үндэсний хорооны хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

5.3.7. Үндэсний хорооны үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, сурталчлах арга хэмжээг зохион байгуулах.

---o0o---



Засгийн газрын 2022 оны 247 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

Засгийн газрын 2017 оны 27 дугаар
тогтоолын 5 дугаар хавсралт

**МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ХУУЛЬ БУС
ЭРГЭЛТТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

- Дарга: -Хууль зүй, дотоод хэргийн сайд
- Гишүүд: -Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга (зөвшилцсөнөөр);
-Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд;
-Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд;
-Соёлын дэд сайд;
-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд;
-Эрүүл мэндийн дэд сайд;
-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд;
-Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд;
-Гаалийн ерөнхий газрын дарга;
-Цагдаагийн ерөнхий газрын дарга;
-Тагнуулын ерөнхий газрын дарга;
-Хил хамгаалах ерөнхий газрын дарга;
-Гадаадын иргэн, харьяатын газрын дарга;
-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга;
-Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын дарга;
-Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга;
-Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга;
-Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал;
-Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал;
-Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал.
- Нарийн бичгийн дарга: -Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга.

---о0о---



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 6 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 253

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 144.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй орон тоо тутамд ногдох төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 111 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

А.АРИУНЗАЯА

Засгийн газрын 2022 оны 253 дугаар
тогтоолын хавсралт

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АЖИЛЛУУЛААГҮЙ ОРОН ТОО ТУТАМД НОГДОХ ТӨЛБӨРИЙГ ХӨНГӨЛӨХ, ЧӨЛӨӨЛӨХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3-т заасан төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөхтэй холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Энэ журмын 2.1-д заасан төлбөрөөс хөнгөлүүлэх, чөлөөлүүлэх аж ахуйн нэгж, байгууллага нь дор дурдсан этгээдэд мөн журмын 3.1-д заасны дагуу дэмжлэг үзүүлсэн байна:

1.2.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1-д заасан хөгжлийн бэрхшээлтэй хүн;

1.2.2.Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.2-т заасан хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ гэртээ асарч байгаа асаргааны тэтгэмж авагч.

Хоёр.Төлбөрийг төвлөрүүлэх

2.1.Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3-т заасан төлбөр (цаашид “төлбөр” гэх)-ийг сар бүрийн 25-ны өдрийн дотор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлөх ба уг төлбөрийг урьдчилан төлж болно.

2.2.Энэ журмын 2.1-д заасан төлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэх чиг үүргийг аймаг, дүүргийн хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллага хэрэгжүүлнэ.

2.3.Аж ахуйн нэгж, байгууллага жил бүрийн 1 дүгээр сард багтаан нийт ажлын байрны болон хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулах ажлын байрны мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлж, тухайн жилд төлбөр төлөх хуваарийг харьяалах аймаг, дүүргийн хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллагатай тохиролцон баталгаажуулна. Төлбөр төлөх хуваарийг баталгаажуулахад тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн холбогдох тайлангаар баталгаажсан нийт ажилтны тоо, үүнээс хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулбал зохих болон ажиллуулж байгаа орон тоо, төлбөрийн нийт хэмжээ зэргийг харгалзан үзнэ.

2.4.Аж ахуйн нэгж, байгууллага нь нийт ажилтны тоо, орон тооны бүтцэд өөрчлөлт орсон тохиолдолд тухай бүр харьяа аймаг, дүүргийн хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллагад мэдэгдэх бөгөөд мөн тохиолдолд энэ журмын 2.3-т заасан төлбөр төлөх хуваарьт өөрчлөлт оруулж болно.

Гурав.Төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх

3.1.Хөдөлмөрийн тухай хуулийн 144.4-т заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүний болон хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ гэртээ асарч байгаа хүний үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг гэрээгээр байнга худалдан авах зэргээр тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн ажил олгогчийг дараах дүнгээр төлбөрөөс хөнгөлнө:

3.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүний болон хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ гэртээ асарч байгаа хүний үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг 6 сараас доошгүй хугацаатай гэрээ байгуулж худалдан авсан бол худалдан авсан бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнийн дүнгээр;



3.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүн болон хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ гэртээ асарч байгаа хүн хөдөлмөр эрхлэхэд шаардагдах ажлын багаж, тоног төхөөрөмж худалдан авахад нь дэмжлэг үзүүлсэн бол уг үзүүлсэн дэмжлэгийн үнийн дүнгээр.

3.2.Аж ахуйн нэгж, байгууллагын энэ журмын 3.1.1, 3.1.2-т заасны дагуу үзүүлсэн дэмжлэгийн үнийн дүн мөн журмын 2.3-т заасан хуваарийн дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлөх төлбөрөөс илүү гарсан тохиолдолд төлбөрөөс чөлөөлнө.

3.3.Аж ахуйн нэгж, байгууллага энэ журмын 3.1, 3.2-т заасны дагуу төлбөрөөс хөнгөлүүлэх, эсхүл чөлөөлүүлэх тухай албан хүсэлтээ харьяа аймаг, дүүргийн хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллагад хандан цахим, эсхүл цаасан хэлбэрээр гаргах бөгөөд хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана:

3.3.1.энэ журмын 3.1-д заасан дэмжлэг үзүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ гэртээ асарч байгаа хүний асаргааны тэтгэмж авдаг талаарх мэдээлэл;

3.3.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний болон хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ гэртээ асарч байгаа хүний үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг худалдан авах хүчин төгөлдөр гэрээ, худалдан авсан бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлбөрийг төлсөн санхүүгийн баримт;

3.3.3.хөгжлийн бэрхшээлтэй хүн болон хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ гэртээ асарч байгаа хүн хөдөлмөр эрхлэхэд шаардагдах ажлын багаж, тоног төхөөрөмж худалдан авахад нь дэмжлэг үзүүлсэн тухайг нотлох худалдах, худалдан авах гэрээ, төлбөр төлсөн санхүүгийн баримт зэрэг холбогдох баримт бичиг.

3.4.Энэ журмын 3.1-д заасан дэмжлэг үзүүлэх бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, ажлын багаж, тоног төхөөрөмжийн үнэ нь зах зээлийн дундаж үнээс илүүгүй байх бөгөөд аж ахуйн нэгж, байгууллагын үзүүлсэн дэмжлэгийн дүн татварын хууль тогтоомжид заасан төлбөрийн баримтаар баталгаажсан байна.

3.5.Төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх шийдвэрийг энэ журмын 2.3-т заасан төлбөр төлөх хуваарь, мөн журмын 3.3-т заасан баримт бичиг, 3.4-т заасан төлбөрийн баримт, 3.8-д заасан мэдээллийг тус тус үндэслэн аймаг, дүүргийн хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллага тухай бүр гаргана.

3.6. Аж ахуйн нэгж, байгууллага энэ журмын 2.1-д заасны дагуу төлбөрийг урьдчилан төлсний дараа хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд авсан, мөн энэ журмын 3.1-д заасан дэмжлэг үзүүлсэн тохиолдолд аймаг, дүүргийн хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллага холбогдох тооцоог хийж, урьдчилж төлсөн илүү төлбөрийг буцаан олгоно.

3.7. Аж ахуйн нэгж, байгууллага болон аймаг, дүүргийн хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллага санхүүгийн жилийн эцэст тухайн аж ахуйн нэгж, байгууллагын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлсөн төлбөр болон төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн дүнг эцэслэн нийлж, тооцоог дуусгавар болгоно.

3.8. Энэ журмын 2.1-д заасан аж ахуйн нэгж, байгууллагын нийт ажилтны тоо, үүнээс хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулбал зохих болон ажиллуулж байгаа орон тоо, төлбөрийн хэмжээ, хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээ зэрэг холбогдох мэдээллийг хөдөлмөр, татвар, нийгмийн даатгал, бүртгэлийн асуудал хариуцсан байгууллагууд харилцан солилцож, мэдээллийн систем үүсгэж ажиллана. Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мэдээллийн системийг удирдлагаар ханган ажиллана.

Дөрөв.Төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх үйл ажиллагаанд хяналт тавих, мэдээлэх

4.1. Хууль тогтоомжоор хориглосноос бусад тохиолдолд аж ахуйн нэгж, байгууллагын төлбөрийг хөнгөлсөн, чөлөөлсөн тухай мэдээлэл олон нийтэд нээлттэй, ил тод байна.

4.2. Төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын болон төлбөрөөс хөнгөлсөн, чөлөөлсөн дүнгийн талаарх мэдээлэл, аж ахуйн нэгж, байгууллагаас дэмжлэг авсан хөгжлийн бэрхшээлтэй хүний болон хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ гэртээ асарч байгаа хүний тоо, гарсан үр дүнгийн талаарх мэдээлэл, тайланг аймаг, дүүргийн хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллага жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор гаргаж хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх бөгөөд хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мэдээлэл, тайланг нэгтгэж, жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр тайлагнаж ажиллана.

4.3. Төлбөрийг төвлөрүүлэх, хөнгөлөх, чөлөөлөх үйл ажиллагаанд тавих хяналтыг хуулиар олгосон эрхийн хүрээнд мэргэжлийн хяналтын байгууллага, хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч хэрэгжүүлнэ.



4.4. Журмын хэрэгжилтэд хөдөлмөрийн харилцааны асуудлаар мэргэшсэн төрийн бус байгууллага хууль тогтоомжийн дагуу олон нийтийн хяналт тавьж болно.

4.5. Энэ журмыг зөрчсөн буруутай албан тушаалтан, хуулийн этгээд, хүнд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 6 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 257

Улаанбаатар
хот

Дүрэм батлах тухай

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 15.1.1, 15.1.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны дүрэм”-ийг 1 дүгээр хавсралт, “Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдааны дүрэм”-ийг 2 дугаар хавсралт, “Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдааны дүрэм”-ийг 3 дугаар хавсралт, “Үндэсний их баяр наадмын үндэсний сурын харвааны дүрэм”-ийг 4 дүгээр хавсралт, “Үндэсний их баяр наадмын үндэсний шагайн харвааны дүрэм”-ийг 5 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоолын 1-д заасан дүрмийг хэрэгжүүлж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны дарга С.Амарсайхан, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Дүрэм батлах тухай” Засгийн газрын 2003 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 164 дүгээр, “Дүрэмд өөрчлөлт оруулах тухай” 2004 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 151 дүгээр, “Дүрэм шинэчлэн батлах тухай” 2005 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 119 дүгээр, “Үндэсний их баяр наадмын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2009 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 169 дүгээр, “Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2012 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 112 дугаар, “Дүрэм шинэчлэн батлах тухай” 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 178 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД

С.АМАРСАЙХАН

Засгийн газрын 2022 оны 257 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРООНЫ ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ дүрмээр Үндэсний их баяр наадмыг хууль тогтоомж, уламжлалт ёс заншил, өв соёл, орчин үеийн технологид тулгуурлан улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны үйл ажиллагааг зохицуулна.

1.2.Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороо (цаашид “Хороо” гэх) нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний их баяр наадмын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай, Биеийн тамир спортын тухай хууль бусад хууль тогтоомж, энэ дүрэм, холбогдох стандартыг мөрдөж ажиллана.

1.3.Хороо нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэх бөгөөд Төрийн санд харилцах данстай байна.

Хоёр.Хорооны удирдлага, зохион байгуулалт

2.1.Хороо нь орон тооны бус байх бөгөөд дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

2.2.Хорооны Ажлын албаны үүргийг Нийслэлийн Засаг даргын тамгын газар гүйцэтгэнэ.

2.3.Хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд хуралдаанд нийт гишүүдийн олонх оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцно.

2.4.Хорооны дарга нь хуралдааны дэгийг тогтоож, хуралдааныг удирдах бөгөөд түүний эзгүйд дэд дарга бүрэн эрхийг нь хэрэгжүүлнэ.

2.5.Хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг олонхын саналаар шийдвэрлэж тогтоол гаргаж, тогтоолд Хорооны дарга болон нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

2.6.Хуралдааны явцын тэмдэглэл хөтөлж, Хорооны нарийн бичгийн дарга, тэмдэглэл хөтөлсөн албан тушаалтан гарын үсэг зурна.



2.7.Хороо нь Салбар хороог аль нэг гишүүнээр ахлуулан байгуулж ажиллуулах бөгөөд дараах салбар хороотой байна:

2.7.1.Үндэсний бөхийн салбар хороо;

2.7.2.Хурдан морины салбар хороо;

2.7.3.Сурын харвааны салбар хороо;

2.7.4.Шагайн харвааны салбар хороо;

2.7.5.Урлаг, соёлын салбар хороо;

2.7.6.Төрийн ёслол, хүндэтгэлийн салбар хороо;

2.7.7.Хэв журмын салбар хороо;

2.7.8.Тохижилт, засвар, худалдаа, үйлчилгээний салбар хороо;

2.7.9.Хэвлэл, мэдээллийн салбар хороо.

2.8.Салбар хороо нь Хорооноос өгсөн үүрэг, даалгавар, батлагдсан төлөвлөгөө, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

2.9.Салбар хороо нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

Гурав.Хорооны бүрэн эрх

3.1.Хороо нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

3.1.1.Үндэсний их баяр наадмыг улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг хариуцан баяр наадмын нээлт, хаалт, үндэсний бөхийн барилдаан, үндэсний хурдан морины уралдаан, үндэсний сурын болон шагайн харваа, төрийн ёслол, хүндэтгэл, соёлын арга хэмжээг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын дагуу зохион байгуулах;

3.1.2.Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, Засгийн газрын өмнө ажлаа хариуцан тайлагнах;

3.1.3.Үндэсний их баяр наадмын тухай хуулийг хэрэгжүүлэх талаар Засгийн газраас гарах шийдвэрийн төсөл боловсруулах;



3.1.4. Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой зарим үйл ажиллагаа, арга хэмжээг цаг үеийн нөхцөл байдалтай үйлдүүлэн зохицуулах үйл ажиллагааны журам батлах;

3.1.5. салбар хорооны бүрэлдэхүүнийг батлах;

3.1.6. хорооны болон салбар хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, үйл ажиллагааг нь удирдан чиглүүлж, тайланг хэлэлцэх;

3.1.7. Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардагдах төсвийн төслийг хуульд заасан хугацаанд боловсруулан батлуулж, зориулалтын дагуу зарцуулах, шаардлагатай бол төсвийн тодорхой хэсгийг салбар хороодод хуваарилж, зарцуулалтад нь хяналт тавих;

3.1.8. салбар болон дэд хорооноос баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх талаар зохион байгуулсан ажил, санхүүгийн тайланг баяр наадам дууссанаас хойш ажлын 7 өдөрт багтаан авч нэгтгэн үнэлэлт, дүгнэлт өгөх;

3.1.9. аймаг, сумын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх нийтлэг журмын хэрэгжилтэд хяналт тавих;

3.1.10. Үндэсний их баяр наадамд оролцож байгаа бөх, уяач, харваач, уралдаанч хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон холбогдох бусад этгээдээс гаргасан гомдол, саналыг өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх;

3.1.11. баяр наадмын бэлгэдэл бүхий тэмдэг, цолны болон шагналын үнэмлэх, урилга, тасалбар, зөвшөөрлийн загварыг батлах.

3.2. Хороо нь дараах асуудлаар холбогдох төрийн байгууллагад санал гаргах эрхтэй:

3.2.1. Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх хөтөлбөрийн төсөл боловсруулж, санал авах;

3.2.2. салбар хороодын төсөвт өөрчлөлт оруулах;

3.2.3. Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд идэвх зүтгэл, санаачилгатай ажилласан хүмүүст мөнгөн шагнал олгох, бусад хэлбэрээр урамшуулах, төр, засгийн шагналаар шагнуулах тухай саналаа холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;



3.2.4.Хороо болон салбар, дэд хорооноос өгсөн үүрэг даалгаврыг хангалтгүй биелүүлсэн гишүүн, албан тушаалтанд хариуцлага тооцуулах талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд санал хүргүүлэх.

Дөрөв.Хариуцлага

4.1.Хороо нь ёс зүй, сахилга хариуцлагын дүрмийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

---o0o---

Засгийн газрын 2022 оны 257 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ҮНДЭСНИЙ БӨХИЙН БАРИЛДААНЫ ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Үндэсний их баяр наадам (цаашид “Баяр наадам” гэх)-ын үндэсний бөхийн барилдааныг зохион байгуулахад Үндэсний их баяр наадмын тухай хууль болон энэ дүрмийг мөрдөнө.

1.2.Баяр наадмын үндэсний бөхийн барилдааныг Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос байгуулсан үндэсний бөхийн салбар хороо (цаашид “Салбар хороо” гэх) зохион байгуулна.

Хоёр.Улс, аймаг, сумын баяр наадамд барилдах бөхийг бүртгэх, эрэмбэлэх

2.1.Салбар хороо, Монголын үндэсний бөхийн холбоо, аймаг, сумын салбар хороо болон тухайн орон нутгийн бөхийн салбар холбооноос томилсон гарын даа нар баяр наадамд барилдах бөхийг нээлттэйгээр бүртгэнэ.

2.2.Улсын баяр наадмын бөхийн барилдааны бүртгэлийг барилдаан эхлэхээс дөрөв хоногийн өмнө тогтоосон цагт эхлүүлж, барилдаан эхлэхээс хоёр хоногийн өмнө буюу 7 дугаар сарын 9-ний өдрийн 19.00 цагт дуусгана.

2.3.Аймгийн баяр наадмын бөхийн барилдааны бүртгэлийг барилдаан эхлэхээс хоёр хоногийн өмнө тогтоосон цагт эхлүүлж, барилдаан эхлэхээс нэг хоногийн өмнө дуусгана.

2.4.Сумын баяр наадмын бөхийн барилдааны бүртгэлийг барилдаан эхлэхээс 1 хоногийн өмнө тогтоосон цагт эхлүүлж, тухайн өдрийн 20.00 цагт дуусгана.

2.5.Улс, аймгийн баяр наадмын бөхийн барилдаанд барилдах бөх нь ослын даатгалд даатгуулсан, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9.2, 9.5-д заасны дагуу 16 насанд хүрсэн байх бөгөөд иргэний үнэмлэх, цолтой бөх нь цолны үнэмлэх зэрэг баримт бичигтэй өөрийн биеэр ирж бүртгүүлнэ.

2.6.Гамшиг, ослын үед улс, аймаг, сумын баяр наадмын бөхийн барилдааны бүртгэлийг цахим хэлбэрээр зохион байгуулж болно.

2.7.Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9.7-д заасны дагуу улс, аймаг, сумын баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд барилдах бөхийг үндэс угсаа, төрсөн газар, оршин суугаа засаг захиргааны нэгж, цол, чимгээр нь ялгаварлахгүйгээр нээлттэйгээр ил тод бүртгэж, барилдуулна.

2.8.Энэ дүрмийн 2.2, 2.3, 2.4-т заасан хугацаанаас хойш бөхийг бүртгэхгүй бөгөөд бүртгүүлсэн бөхийг цол болон амжилтаар нь эрэмбэлсэн жагсаалтыг Монголын үндэсний бөхийн холбооны цахим хуудаст байршуулна.

2.9.Улсын баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд гоц мөргөх тооны бөх бүртгэхгүй.

2.10.Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9.8-д заасны дагуу Монголын үндэсний бөхийн холбоо бөхийг цол, амжилтаар нь дараах журмаар эрэмбэлнэ:

2.10.1.ижил цолтой бөхчүүдээс тухайн цолны болзлоо олон биелүүлснийг, энэ нөхцөл ижил байвал доод давааг олон давсныг эхэнд нь эрэмбэлэх бөгөөд энэ журмаар начин цолны даваа хүртэл тооцоход амжилт нь ижил байвал хэн түрүүлж одоогийн цолоо хүртсэн хугацаагаар, энэ нөхцөл мөн ижил байвал доод цолыг хүртсэн хугацааг тус тус харгалзаж;

2.10.2.нэг өдөр адил даваа болон бусад шалгуураар ижил цол авсан бөхчүүдийг өмнөх цолоо түрүүлж авсан буюу өмнөх цолны эрэмбээр;



2.10.3.энэ дүрмийн 2.10.1, 2.10.2-т заасан нөхцөл ижил буюу өмнө нь цолгүй байсан бол тулгаж, барилдуулах жагсаалтад бичигдсэн дарааллаар;

2.10.4.энэ дүрмийн 2.10.1, 2.10.2, 2.10.3-т заасан журмаар эрэмбэ тогтоох боломжгүй бол шодож;

2.10.5.улсын аварга цолтны эрэмбийг улсад хоёр удаа ес даван түрүүлсэн улсын аварга, улсад нэг удаа ес даван түрүүлж, мөн нэг удаа ес даван үзүүлсэн улсын аварга, улсад нэг удаа арав даван түрүүлсэн улсын аварга гэсэн дарааллаар;

2.10.6.улсын аварга цолны болзол ижил бол энэ дүрмийн 2.10.1-д заасан журмын дагуу.

**Гурав.Улс, аймаг, сумын баяр наадмын бөхийн
барилдаанд барилдах бөхийг тулгаж
барилдуулах, амлах**

3.1.Бөхийг улс, аймаг, сумын баяр наадмын үндэсний бөхийн барилдааны нэг, хоёр, дөрвийн даваанд цолны болон амжилтын эрэмбээр тулгаж, бусад даваанд энэ дүрмийн 2.8-д заасан цолны эрэмбээр ам авхуулж барилдуулна.

3.2.Ижил цолтой бөхчүүд энэ дүрмийн 2.10-т заасан журмаар тогтоосон эрэмбээр ам авна.

3.3.Улсын баяр наадамд аймаг, цэрэг, сумын цолтой бөх энэ дүрмийн 2.8-д заасан цолны эрэмбээр ам авна.

3.4.Сумын цолтой бөх аймгийн баяр наадамд энэ дүрмийн 2.8-д заасан цолны эрэмбээр ам авна.

3.5.Баяр наадмын үндэсний бөхийн барилдааны өмнөх давааны барилдаан дуусаж, тухайн бөхийн нэрийг ам авхуулахаар зарласнаас хойш ам авах хугацаа 5 минутаас илүүгүй байна.

3.6.Энэ дүрмийн 3.5-д заасан хугацаанд ам аваагүй бол цолны эрэмбээр дараагийн бөх ам авна.

Дөрөв.Бөхийн барилдаан

4.1.Баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд талбай дээр хоёр бөх барилдахаар өрснөөр барилдаан эхлэх цагийг тооцно.

4.2.Бөхийн цээжин хэсэг давамгай буюу бүтэн биеэрээ дээр байх үед уг бөхийг давсанд тооцно.

4.3.Барилдаж буй бөхчүүд ойролцоо унавал хэн урьтаж толгой, тохой, өвдөг зэрэг биеийн аль нэг хэсгээр газарт түрүүлж хүрсэн бөхийг унасанд тооцно.

4.4.Барилдааны явцад барьц тавиулах шаардлага гарвал засуулууд өөрийн бөхийн элэг бүс, гараас барих буюу тэврэн “тавилц” хэмээн тодоор хэлж, барилдааныг зогсоох бөгөөд барилдааныг цааш үргэлжлүүлэхдээ барьц тавилцах үеийн барьцаар бариулж, байрлалаар золгуулна.

4.5.Энэ дүрмийн 4.4-т зааснаар барьц тавилцсан хоёр бөхийн санал нийлсэн тохиолдолд заавал анхны барьц, байрлалыг хангуулахгүй байж болно.

4.6.Бөхийг дараах тохиолдолд дахин барилдуулна:

4.6.1.хаялцах үед давж байгаа бөхийн элэг бүс алдуурах, тасрах;

4.6.2.учраа бөхөө ямар нэгэн саад болох зүйл рүү түрж барьцанд хүрэх, улмаар мэх хийх, эсхүл тээглүүлж унагах;

4.6.3.хайнцах;

4.6.4.гутлын хүлэг, боолт, оймсны түрийнээс барьж унагах;

4.6.5.гутлын өлмий дээр гишгэж унагах;

4.6.6.засуул барилдааныг түр зогсоох үед, эсхүл учраагаа өмсгөлөө засаж байхад болон барилдаан удааширсан үед барьц бариулж байхад мэх хийж унагах.

4.7.Барилдааны явцад унаж байгаа бөх хаяж байгаа бөхийн элэг бүсийг татаж тайлсан бол энэ дүрмийн 4.6.1-д заасан нөхцөл хамаарахгүй.

4.8.Барилдаан өрнөж байхад барилдаанаа зогсоох, учраа бөхийнхөө ирийг дарах зорилгоор өрөлтөө орхин өндийх, эргэн явахад нь мэх хийж унагавал дахин барилдуулахгүй.

4.9.Улсын баяр наадмын үндэсний бөхийн барилдааны хоёр бөхийн барилдаан үргэлжлэх үндсэн хугацааг дараах байдлаар тогтооно:

4.9.1.нэгээс дөрвийн даваа тус бүр 15 минут;



4.9.2.таваас арвын даваа тус бүр 20 минут.

4.10.Аймаг, сумын баяр наадмын үндэсний бөхийн барилдааны хоёр бөхийн барилдаан үргэлжлэх үндсэн хугацаа нэгээс дөрвийн даваанд 15 минут, аймгийн баяр наадмын үндэсний бөхийн барилдааны хоёр бөхийн барилдаан үргэлжлэх үндсэн хугацаа таваас долоогийн даваанд 20 минут, сумын баяр наадмын үндэсний бөхийн барилдааны хоёр бөхийн барилдааны үргэлжлэх үндсэн хугацаа тав, зургаагийн даваанд 20 минут тус тус байна.

4.11.Баяр наадмын үндэсний бөхийн барилдааны үндсэн хугацаа дуусахад хаялцаагүй бөхчүүдийн барилдааныг зогсоож, хөлийн цэц шодож, дараах барьцыг хоёр бөхөөр ээлжлэн бариулж барилдуулах бөгөөд учраа бөхчүүд санал нийлсэн тохиолдолд дараах барьцын дарааллыг баримтлахгүйгээр аль нэгийг сонгон барилдуулж болно:

- 4.11.1.сэнжигдэн элэг бүсдэх;
- 4.11.2.дан шуудагдах;
- 4.11.3.давхар шуудагдах.

4.12.Баяр наадмын үндэсний бөхийн барилдааны барилдах үндсэн хугацаа дуусахад дан болон давхар шуудагны барьцтай барилдуулах, санаачилга харах хугацааг дараах байдлаар тогтооно:

4.12.1.дан болон давхар шуудагны барьцтай барилдах хугацаа даваа тус бүрд 30 минут;

4.12.2.дан болон давхар шуудагны барьцтай санаачилга харан барилдуулах хугацаа даваа тус бүрд 10 минут.

4.13.Тухайн дүйз барилдаан эхэлснээс хойш 10 минут өнгөрөхөд талбайд гарч ирээгүй бөхийг унасанд, учраа бөхийг давсанд тооцно.

4.14.Нэг даваанд бөхийн эмчилгээ хийлгэх хугацаа нийт 3 минутаас хэтрэхгүй байх бөгөөд хэтэрсэн тохиолдолд учраа бөхийг давсанд тооцно.

4.15.Учраа бөхөд энэ дүрмийн 5.3, 5.4-т заасныг зөрчиж гэмтэл учруулсны улмаас 4.14-т зааснаас илүү хугацаагаар эмчлүүлэх шаардлагатай болсон бол гэмтэл учруулсан бөхийг барилдаанаас хасаж, эмчилгээ хийлгэж байгаа бөхийг давсанд тооцно.

4.16.Хоёр бөх барилдан хаялцсаны дараа хэн унаснаас үл хамааран бага цолтой бөх нь илүү цолтой бөхөд ирж, тахим өгч, авалцана.

4.17.Хөлийн цэц маргаантай барилдааны шүүлтэд албан ёсны эрхтэй шууд дамжуулж байгаа телевизийн дуу-дүрсний бичлэгийг ашиглаж болно.

4.18.Хөлийн цэцийн олонхын саналаар гаргасан шийдвэр эцсийн шийдвэр байх бөгөөд унасан бөх барилдааны талбайг чөлөөлнө.

Тав.Бөхийн эрх, үүрэг

5.1.Баяр наадамд барилдах бөх дараах эрхтэй:

5.1.1.энэ дүрэмд заасны дагуу цол, амжилтынхаа эрэмбээр ам авах;

5.1.2.барилдааны үед гарсан аливаа асуудал, маргааныг засуул, хөлийн цэцэд тавьж шийдвэрлүүлэх;

5.1.3.Дархан аварга цолтой бөх зодог тайлах хүсэлт гаргавал тавын даваа эхлэхийн өмнө түүний цолыг дуудан Есөн хөлт цагаан тугийг тойруулж, зодог тайлах ёслол үйлдүүлж, хүндэтгэл үзүүлж болно.

5.2.Баяр наадамд барилдах бөх дараах үүрэгтэй:

5.2.1.энэ дүрмийг судлан мэдэж, сахин биелүүлэх;

5.2.2.Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 13.1-д заасан стандартад нийцүүлэн хийсэн малгай, зодог, шуудаг, гутал, хүлэг боолт хэрэглэх;

5.2.3.бөхийн барилдаан эхлэхэд цол, амжилтын эрэмбээр жагсан талбайд гарч, үзэгч олноо хүндэтгэн харилцах, барилдааны үед засуул, хөлийн цэцээс дүрмийн дагуу тавьсан шаардлагыг биелүүлэх;

5.2.4.бөхийн барилдааны үед засуул, хөлийн цэцийн дүрмийн дагуу шаардлагыг биелүүлэх, барилдааны талбайд даруу төлөв, ёс жудагтай байх;

5.2.5.бөхийн барилдааны шуурхай байдлыг ханган, дайчин шалмаг барилдах;

5.2.6.энэ дүрмийн 5.1.3-т заасан зодог тайлсан бөх дахин баяр наадамд барилдахгүй байх.

5.3.Баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд барилдах бөх дараах хориотой, эсхүл буруу барьц барихгүй:

5.3.1.шуудагнаас цавчиж удаан барих;
5.3.2.элэг бүснээс, эсхүл нэг сэнжигний ар, өврөөс хоёр гараар удаан зуурах;

5.3.3.зодогны ар, өврийн сэнжигийг нийлүүлэн атгах;
5.3.4.гутлын түрий, оймс, хүлэгнээс барих;
5.3.5.зодогны ханцуйны амсрыг эргүүлэн дарж барих.

5.4.Баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд барилдах бөх дараах гэмтээх барьц барих болон хөдөлгөөн хийхгүй:

5.4.1.цохиж халах, даллан цохих, шуугаар халах;
5.4.2.хоолой шахах;
5.4.3.зориуд мөргөх;
5.4.4.ямар нэг байдлаар алгадах, цохих;
5.4.5.өшиглөх, тийрэх;
5.4.6.унасан бөхийн дээрээс өвдөглөх, тохойлдох, нидрэх, биеийн жингээр дарж жинлэх;

5.4.7.өвдөглөж барьц тавиулах;
5.4.8.хоёр гарыг давхар хөших;
5.4.9.сарвуу буюу шуунаас нэг гараар барьж, нөгөө гараар элэг бүснээс барьж тохой хөших;

5.4.10.бусад хэлбэрээр үений эсрэг хөших;
5.4.11.өлмий дээр гишгэж унагах.

Зургаа.Жаяг дэгийн баг

6.1.Ерөнхий цэц, хөлийн цэц, гарын даа, засуул, тайлбарлагч, эмч, хаяавч, холбогч, зохион байгуулагч зэрэг бүрэлдэхүүнтэй жаяг дэгийн багийг Салбар хорооноос томилох бөгөөд уг жаяг дэгийн багийг Ерөнхий цэц удирдана.

6.2.Энэ дүрмийн 6.1-д заасан хаяавч, холбогч нь зөвхөн улсын баяр наадамд ажиллана.

6.3.Монголын үндэсний бөхийн холбоо Хөлийн цэцээр Үндэсний их баяр наадмын тухай хууль болон Монголын үндэсний бөхийн барилдааны дүрмийн бүрэн мэдлэгтэй, цэгц шударга, хурц хараа, шалмаг хөдөлгөөнтэй бөх, бөхийн зүтгэлтнээс сонгон санал болгосноор Салбар хороо томилж, гэрээ байгуулан ажиллуулна.



6.4.Хөлийн цэц дараах эрхтэй:

6.4.1.бөхийн өмсгөлийн шаардлагыг хангуулах;

6.4.2.энэ дүрмийн 5.3, 5.4-т заасныг зөрчсөн бөх, дүрэмд заасан үүргийг зөрчсөн гарын даа, хаяавч, засуул, тайлбарлагч, эмчид энэ дүрмийн дагуу хариуцлага хүлээлгэх;

6.4.3.ам авах бөх дүрэмд заасан хугацаанд ам авахаар ирээгүй, эсхүл бэлэн биш бол түүнийг 5 минут хүлээж, хугацаа дуусмагц дараагийн бөхөөр ам авхуулах зөвшөөрлийг Ерөнхий цэц Ахлах гарын даад олгох;

6.4.4.хөлийн цэцийн шийдвэр гараагүй байхад малгайгаа авч өмсөх, туг тойрох, эсхүл шийдвэр гарсан үед тахимаа өгөөгүй тохиолдолд учраа бөхөд тахим авалгүйгээр туг тойрохыг зөвшөөрч, тухайн бөхийн бай шагналыг хасах.

6.5.Хөлийн цэц дараах үүрэгтэй:

6.5.1.энэ дүрмийг чанд сахин биелүүлэх;

6.5.2.үүргээ биелүүлэх, дүрмээ зөрчихгүй байхыг бөх, гарын даа, засуул, тайлбарлагч, эмчээс шаардах;

6.5.3.будилаантай барилдааныг хөлийн цэцийн бүрэлдэхүүнээр шуурхай хэлэлцэн шийдвэрлэж, гарсан шийдвэрийг тухай бүр тайлбарлагчид хэлж, олон түмэнд мэдээлэх;

6.5.4.бөхчүүдийг тогтоосон хугацаанд ам авхуулах;

6.5.5.барилдааны үед гарсан зөрчил, түүнийг шийдвэрлэсэн байдал, цаашид шийдвэрлүүлэх асуудлын талаарх саналаа Салбар хороонд албан ёсоор гаргах;

6.5.6.бөхийн барилдааны үндсэн хугацаа болон дан, давхар шуудагны барьцтай барилдах хугацаа дууссаны дараа барилдааны санаачилга харах 10 минутад хоёр бөхийн идэвх санаачилга, барьц барих, хорьж барих, илт хамгаалах зэрэг үйлдлийг харгалзан үзэж идэвх санаачилгагүй барилдсан бөхөд хоёр удаа сануулж, улмаар барилдаанаас хасаж, учраа бөхийг давсанд тооцох эсэхийг бүх цэцүүд зөвлөлдөн олонхын саналаар шийдвэрлэх;

6.5.7.Ерөнхий цэц жаяг дэгийн багийн бүрэлдэхүүн дэх эмчийг удирдан ажиллах бөгөөд эмч нь шаардлагатай үед эмнэлгийн тусламжийг шуурхай үзүүлэх, эрүүл мэндийн хувьд барилдах боломжгүй болсон бөхөд магадалгаа олгох, барилдааны талбай, байрны эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангуулах.

6.6.Салбар хороо Ерөнхий цэцийн саналыг үндэслэн үүргээ хангалтгүй биелүүлсэн цэцэд ажлын хөлсийг олгохгүй бөгөөд дараах тохиолдолд цаашид цэцээр ажиллуулахгүй:

6.6.1.аливаа асуудлыг шийдвэрлэхдээ байгууллага, хувийн болон нутаг усны явцуу үзэл гаргах;

6.6.2.асуудлыг шуурхай шийдвэрлэхгүй бөхчүүдийг маргалдуулах, үзэгчдийг чилээх.

6.7.Үндэсний их баяр наадмын бөхийн барилдааныг үндэсний бөхийн мэргэжлийн тайлбарлагч наадамчид, үзэгчдэд тайлбарлана.

6.8.Тайлбарлагч дараах эрхтэй:

6.8.1.барилдааны явцад бөх, засуул, үзэгч бөхийн барилдааны дүрэм, ёс жудгийг зөрчсөн тохиолдолд түүнийг засуулах зорилгоор анхааруулах;

6.8.2.зарлаж мэдээлэх зүйл нь албан ёсны бөгөөд хэл найруулгын хувьд зөв байх, тухайн барилдаантай холбоотой хөтөлбөр, лавлагааг шаардах.

6.9.Тайлбарлагч дараах үүрэгтэй:

6.9.1.энэ дүрмийг судалж, бүрэн мэдлэгтэй болох, сахин биелүүлэх;

6.9.2.радио, телевизийн нэвтрүүлэгчид тавигддаг мэргэжлийн шаардлагыг хангасан байх;

6.9.3.бөхийн нэр алдар, харьяалал, цол, чимэг, амжилт, барилдааны ур чадвар, онцлог, тухайн барилдааны явцад хоёр бөхийн харилцан хийж байгаа мэхийн нэр, хувилбар, даац, үлдэц зэргийг үзэгч, сонсогч олонд үнэн зөв, уран яруу, ойлгомжтой тайлбарлах;

6.9.4.байгууллага, хувь хүнээс ирүүлсэн зарлал, мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлийг үндэслэн зарлах, мэдээлэх;

6.9.5.монгол бөхийн талаарх мэдлэг, нэвтрүүлэгчийн ур чадвараа байнга дээшлүүлэх;

6.9.6.барилдааны явцад холбогдох хууль, дүрэм, журам болон монгол бөхийн ёс жудгийн талаар үзэгч, сонсогчдод товч тодорхой тайлбарлан таниулж байх;

6.9.7. тухайн барилдааны үеэр тайлбарлан таниулах баримт сэлтийг уншин судалж, бэлдсэн байх.

6.10. Тайлбарлагч нь энэ дүрмийн холбогдох заалтыг зөрчсөн тохиолдолд гарын даа, Ерөнхий цэц түүнд сануулах, тухайн барилдааныг тайлбарлуулахаас татгалзах, ажлын хөлсийг хасах зэрэг хариуцлага хүлээлгэх бөгөөд Салбар хороо дараах тохиолдолд баяр наадмын бөх тайлбарлагчаар ажиллуулахгүй:

6.10.1. барилдсан хоёр бөхийн хэн давсан нь тодорхойгүй, маргаан шийдвэрлэгдээгүй байхад давсан, унасныг зарлах;

6.10.2. барилдаж буй бөхчүүдэд хандан мэх заах, зөвлөх, тэднийг хувь хүний хувьд доромжилсон, зохисгүй үг, хэллэгээр тодорхойлох;

6.10.3. бөхийн барилдааны маргаанд оролцох;

6.10.4. барилдааны үед улс төр, бизнесийн сурталчилгаа болон барилдаанд хамааралгүй бусад зүйлийг дур мэдэн ярих, мэдээлэх, зарлах;

6.10.5. зохих зөвшөөрөл, эрхгүй хүнд чанга яригчийг шилжүүлэх.

6.11. Засуул нь Үндэсний их баяр наадмаар бөхийн барилдаанд бөхийг засаж, цолыг дуудна.

6.12. Засуул дараах эрхтэй:

6.12.1. Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд засуулаар ажиллах, цол дуудах;

6.12.2. бөхийн өмсгөл стандартад нийцэж байгаа эсэхийг шалгах, засуулах, шаардлагатай тохиолдолд хөлийн цэцэд мэдүүлж шийдвэрлүүлэх;

6.12.3. дүрмийн шаардлагыг биелүүлээгүй болон өмсгөл нь шаардлага хангаагүй бөхийг засахаас татгалзах;

6.12.4. үүргээ биелүүлээгүй, дүрэм зөрчсөн бөхийн барилдааныг зогсоож, тухайн бөхийг барилдаанаас хасах саналыг хөлийн цэцэд тавьж шийдвэрлүүлэх.



6.13.Засуул дараах үүрэгтэй:

6.13.1.энэ дүрмийг судлан мэдэж, дүрмийн шаардлагад нийцүүлэн шударга ажиллах;

6.13.2.бөхийн цолыг энэ дүрмийн дагуу зөв дуудах;

6.13.3.бөхийн мэх, барилдааны ур чадварыг судлан мэдэж, засаж байгаа бөхдөө барилдааны арга мэхийг зааж зөвлөх;

6.13.4.барилдааны явцад анхааралтай байж, зөв шийдвэр гаргах, маргаан гарвал бөхөө төлөөлж хөлийн цэцэд үнэн зөвөөр мэдүүлэх.

6.14.Энэ дүрмийн холбогдох заалтыг зөрчсөн тохиолдолд засуулд Ерөнхий цэц сануулах, тухайн барилдаанд ажиллахгүй байх, ажлын хөлсийг хасах шийтгэл хүлээлгэж, үүргээ удаа дараа, эсхүл дараах байдлаар ноцтой зөрчвөл Салбар хороо засуулчаар ажиллуулахгүй:

6.14.1.барилдааны явцад бөх тэнцвэр алдах, эсхүл унах үед хүч нэмэн дэмжсэн байдлаар бөхөө түлхэх, алгадах, түших;

6.14.2.хувийн харилцаа, нутаг усны явцуу үзэл, шударга бус хандлага гаргах;

6.14.3.маргаантай барилдааны шийдвэр гараагүй байхад бөхийн малгайг өмсүүлэх;

6.14.4.дүрэм зөрчсөн бөхтэй эвлэрэнгүй хандах;

6.14.5.бөхөд дүрмийн бус шаардлага тавих, бөх болон жаяг дэгийн багийн гишүүд, наадамчидтай зүй бус харьцах;

6.14.6.өөрийн засаагүй бөхийн барилдааны маргаанд хөндлөнгөөс оролцох.

6.15.Баяр наадамд Гарын даа ажиллах бөгөөд ахлагчтай байна. Гарын даагийн ахлагч нь хаяавч, холбогчийг удирдан ажиллана.

6.16.Гарын даа дараах эрхтэй:

6.16.1.барилдаан товлосон цагаас өмнө бүртгүүлсэн бөхчүүдийн ирцийг хянах;



6.16.2.бөхийн ам авсан байдалд хяналт тавьж, хэрэгжилтийг хангах;

6.16.3.шаардлагатай үед бөхийн цолны үнэмлэхийг үзэж шалгах, зөрчилтэй бол зохих журмын дагуу шийдвэрлүүлэх.

6.17.Гарын даа дараах үүрэгтэй:

6.17.1.энэ дүрмийг судлан мэдэж, сахин биелүүлэх;

6.17.2.барилдаан товлосон хугацаанаас өмнө ирж, бүртгэлийн дагуу оноолт хийх;

6.17.3.оноолт хийх, ам авхуулахдаа бөхчүүдийн цол, амжилтын эрэмбийг хатуу баримтлах;

6.17.4.Гарын даагийн ахлагч ам авч байгаа бөхөд ам бөхчүүдийн нэр, цолыг тод хэлж танилцуулах;

6.17.5.Ерөнхий цэцийн өгсөн албан ёсны зөвшөөрлийг үндэслэн ам авах хугацаанд ирээгүй бөхийг хүлээхгүйгээр дараагийн бөхөөр ам авхуулж, амлах дарааллаас хоцорч ирсэн бөхийг тухайн үед нь ам авхуулах;

6.17.6.бөхийн оноолт, ам авсан байдлыг бөхийн тайлбарлагч нарт шуурхай хүргэх;

6.17.7.барилдааны дараа зохих баримт бичгийг эмхлэн бүрдүүлж, Салбар хороонд өгөх.

6.18.Энэ дүрмийн холбогдох заалтыг зөрчсөн тохиолдолд Гарын даа, хаяавчид Ерөнхий цэц сануулах, тухайн барилдаанд ажиллахгүй байх, ажлын хөлсийг хасах шийтгэл хүлээлгэж, үүргээ удаа дараа, эсхүл дараах байдлаар ноцтой зөрчвөл Салбар хороо Гарын даагаар ажиллуулахгүй:

6.18.1.бөхийн цол, эрэмбийг санаатай зөрчиж оноолт хийсэн;

6.18.2.ам авахаар нэр сонсож буй бөхөд ам бөхчүүдийн нэрийг бүрэн сонсгохгүй, санаатай нуун дарагдуулах, ам авч байгаа бөхөд зөвлөх нэрээр хэн нэгнийг амлуулахаар албадах, ятгах, бөхийн барилдааны маргаанд оролцох, давсан унасан бөхийг буруу тэмдэглэх, давсан бөхийн нэрийг санаатай нуун дарагдуулсан.

Долоо.Бөхөд цол, чимэг олгох

7.1.Улсын баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд таваас дээш давж шөвгөрсөн бөхчүүдэд Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан цолыг олгоно.

7.2.Улсын баяр наадамд шөвгөрсөн, үзүүрлэсэн, түрүүлсэн улсын цолтой бөхөд дараах чимгийг дэс дарааллаар олгоно:

7.2.1.тав давсан бөхөд өсөх идэр, улам нэмэх, хурц шаламгай, уран мэхт, өрнөн дэлгэрэх, улам өрнөх, цог нэмэх, идэр шаламгай, хурдан гарамгай;

7.2.2.зургаа давсан бөхөд үнэн зоригт, цогт гарамгай, үлэмж дэлгэрэх, үнэн итгэлт, саруул шаламгай, өнөд амгалант, чин хүчит, идэвхит итгэлт, бат ерөөлт;

7.2.3.долоо давсан бөхөд саруул сайжрах, хууринан шуугигч, өлзий бадрах, үлэмж хичээнгүй, онц бярдагч, бат нягт, чин зоригт, бахдам гарамгай, хичээнгүй нягт;

7.2.4.найм давсан бөхөд үлэмж бадрах, бууршгүй хүчит, тод сонин, баатар зоригт, бат өлзийт, тонж гарамгай, нэн дуурсгалт, харилтгүй жавхлант, хэтэрхий хурц, өнөд түвшин;

7.2.5.ес давсан бөхөд баяр наадмын манлай, түмнээс төгөлдөр, улс даяар гайхамшигт, тод сонин үзэсгэлэнт, олныг баясуулагч, бүхнээ дуурсгалт, үнэхээр бишрэлт, өнөд баясгалант, уламжлан дуурсах;

7.2.6.арав давсан бөхөд хотлоорыг баясуулагч, харилтгүй үзэсгэлэнт, үлэмж хэтэрхий, тонж гарамгай жавхлант, аугаа хүчит, бүхнээ сонсголт.

7.3.Аймгийн баяр наадамд шөвгөрсөн, үзүүрлэсэн, түрүүлсэн аймаг, цэргийн цолтой бөхөд дараах чимгийг олгоно:

7.3.1.тав давсан бөхөд өсөх, өрнөх, өлзийт, нэмэх, зоригт, шаламгай;

7.3.2.зургаа давсан бөхөд цогт, хичээнгүй, хүчит, идэвхит, гарамгай, сайжрах, нягт, баясгалант;

7.3.3.долоо давсан, эсхүл долоо даван түрүүлсэн бөхөд хурц, бадрангуй, хичээлт, итгэлт, ерөөлт, харилтгүй, дуурсгалт, сонсголт, бишрэлт, жавхлант.

7.4.Сумын баяр наадамд үзүүрлэсэн, түрүүлсэн бөхөд чимэг олгохгүй.

Найм.Хүүхдийн барилдаан

8.1.Улсын баяр наадмаар 16 хүртэлх насны хүүхдийн барилдааныг зохион байгуулж болно.

8.2.Хүүхдийн барилдааныг энэ дүрмийг баримтлан зохион байгуулах бөгөөд түрүүлсэн хүүхдэд улсын шонхор, үзүүрлэсэн хүүхдэд улсын шандас цол олгоно.

8.3.Аймгийн баяр наадмаар 16 хүртэлх насны хүүхдийн барилдааныг зохион байгуулж болох бөгөөд түрүүлсэн хүүхдэд аймгийн шонхор, үзүүрлэсэн хүүхдэд аймгийн шандас цол олгоно.

8.4.Сумын баяр наадмаар 16 хүртэлх насны хүүхдийн барилдааныг зохион байгуулж болох бөгөөд түрүүлсэн хүүхдэд сумын шонхор, үзүүрлэсэн хүүхдэд сумын шандас цол олгоно.

8.5.Баяр наадмын хүүхдийн барилдааны бүртгэлийг бөхийн барилдаан эхлэхээс дөрөв хоногийн өмнө тогтоосон цагт эхлүүлж, барилдаан эхлэхээс хоёр хоногийн өмнө дуусгана.

Ес.Бөхөд хүлээлгэх хариуцлага

9.1.Хөлийн цэц тахим өгөлцөх, авалцах үедээ бие биенээ цохисон, нударсан тохиолдолд учраа бөхтэйгөө гар бариагүй, эсхүл дүрмийн дагуу дахин тахим өгөлцөж, авалцаагүй, үзэгчдэд хандаж мэхийн уучлал гуйгаагүй тохиолдолд тухайн бөхийн давааны бай шагналыг хасна.

9.2.Хөлийн цэц дараах тохиолдолд бөхийг барилдаанаас хасаж, учраа бөхийг давсанд тооцсон шийдвэр гаргана:

9.2.1.энэ дүрмийн 5.3, 5.4-т заасан хориотой буюу гэмтээх барьц барьсан нь учраа бөхдөө гэмтэл учруулаагүй бол уг бөхөд сануулга өгөх бөгөөд сануулснаас хойш хоёр дахь удаагаа зөрчих, нэг дор хоёр зөрчлийг зэрэг гаргасан;

9.2.2.ам авсан бөх амаа солих, өөрөөсөө хойно эрэмбэтэй бөхийг өмнө ам авахыг зөвшөөрөх болон албадах, эсхүл амлан авах бөхийг нэр заан бусад бөхөд тулгасан;

9.2.3.хөлийн цэц, засуулаас дүрмийн дагуу тавьсан шаардлага, гаргасан шийдвэрийг биелүүлэхгүй байх, эсэргүүцэж маргах, олон нийтийн өмнө ёс жудаггүй зан авир гаргасан;

9.2.4.бөхийн өмсгөлийн стандартын шаардлагыг зөрчих, эсхүл элэг бүсээ хэт чанга, хэт сул болон гүйж саарах, алдуурч сулрахаар уясныг засуулах шаардлагыг биелүүлэхгүй байсан;

9.2.5.энэ дүрмийн 4.9, 4.10, 4.12-т заасан хугацаанд санаачилгагүй барилдсан хоёр бөхийн барилдааны нийт хугацаа дуусахад хөлийн цэцүүд хэлэлцээд, санаачилга харах 10 минутад идэвх санаачилга болон барьц барих, хорьж барих, илт хамгаалах зэрэг хөдөлгөөний үйлдлийг харгалзан идэвх санаачилгагүй барилдсан бөхөд хоёр удаа сануулж, улмаар барилдаанаас хасаж, учраа бөхийг давсанд тооцно.

9.3.Салбар хороо доор дурдсан тохиолдолд дараах шийдвэрийг гаргаж, тухайн бөхөд хариуцлага хүлээлгэнэ:

9.3.1.хөлийн цэцийн шийдвэр гараагүй байхад засуулын гараас малгайгаа авах, туг тойрох зэргээр дүрмийн бус үйлдэл хийсэн бөхийн учраа бөхийг давсанд тооцож, зөрчил гаргасан бөхийн давааны бай шагналыг хасах шийдвэрийг хөлийн цэцийн саналыг үндэслэн гаргах;

9.3.2.хөлийн цэц болон засуулаас тавьсан шаардлагыг биелүүлэхгүй удаа дараа хориотой болон буруу, гэмтээх барьц барих, эсхүл гэмтээх хөдөлгөөн хийх үйлдэл гаргасан бөхийг барилдаанаас хасах;

9.3.3.наадамчин олон, баяр наадмыг үл хүндэтгэх, төрийн ёслол, зан уламжлалыг зөрчсөн үйлдэл хийсэн, учраа бөхөө санаатай гэмтээх тохиолдолд тухайн бөхийн барилдах эрхийг хоёр жил хүртэлх хугацаагаар хасах;

9.3.4.хүч үзэн барилдалгүй бууж өгсөн, буулгасан тохиолдолд хөлийн цэцийн саналыг үндэслэн хоёр бөхийн тухайн барилдааны бай шагналыг олгохгүй бөгөөд баяр наадамд барилдах эрхийг нэг удаа түдгэлзүүлэх;

9.3.5.допинг хэрэглэсэн нь олон улсын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээгээр тогтоогдсон бол тухайн бөхийн баяр наадамд давсан давааг хүчингүй болгож, шинээр олгосон цолыг хураах, цол, чимэг авах даваанд уг бөхөд унасан бөхийг тухайн даваанд давснаар тооцож, зохих цол, чимгийг олгуулах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх;



9.3.6.олон улсын эрх бүхий байгууллагаас гаргасан допингийн жагсаалтад орсон хориотой эм, бэлдмэл, бодис хэрэглэсэн нь итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээгээр тогтоогдсон тохиолдолд Үндэсний их баяр наадмын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмын дагуу хариуцлага оногдуулах.

Арав.Бусад зүйл

10.1.Бөхийн барилдаантай холбогдон гарсан маргааныг Хөлийн цэцийн шийдвэрийг үндэслэн Салбар хороо шийдвэрлэнэ. Салбар хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл Хороонд хандан эцэслэн шийдвэрлүүлнэ.

10.2.Дүрэм зөрчсөн, үүргээ биелүүлээгүй бөх, засуул, цэц, гарын даа, тайлбарлагчид хариуцлага хүлээлгэх эсэх асуудлыг Салбар хороо барилдаан дууссанаас хойш 21 хоногийн дотор хуралдаж шийдвэрлэнэ.

10.3.Баяр наадмаар ажилласан жаяг дэгийн багийн гишүүдэд ажлын хөлс, барилдсан бөхчүүдэд бай шагналыг холбогдох журмын дагуу олгоно.

---оОо---

Засгийн газрын 2022 оны 257 дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ҮНДЭСНИЙ ХУРДАН МОРИНЫ УРАЛДААНЫ ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Үндэсний их баяр наадмын үндэсний хурдан морины уралдаан (цаашид “хурдан морины уралдаан” гэх)-ыг зохион байгуулахад Үндэсний их баяр наадмын тухай хууль, холбогдох хууль тогтоомж болон энэ дүрмийг дагаж мөрдөнө.

1.2.Энэ дүрэм нь зөвхөн Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдааныг зохион байгуулахад хамаарна.

1.3.Энэ дүрмээр зохицуулаагүй бусад асуудлыг Үндэсний их баяр наадмын тухай хууль болон холбогдох дүрэм, журмаар зохицуулна.

Хоёр.Хурдан морины уралдааны салбар хороо

2.1.Хурдан морины уралдааныг Хурдан морины уралдааны салбар хороо (цаашид “Салбар хороо” гэх) хариуцан зохион байгуулна.

2.2.Салбар хорооны бүрэлдэхүүнийг Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороо (цаашид “Хороо” гэх) батална.

2.3.Салбар хороо хурдан морины нас бүрийн уралдааныг хариуцсан даамал, дэд даамал, цуваа бүртгэлийн ахлагч, цуваа бүртгэгч, шүдлэгч, манлайлагч, морь бариач, цоллогч, хүний эмч, хүүхдийн эрхийн ажилтан, малын эмч бүхий баг (цаашид “шүүгчид” гэх) болон шаардлагатай бусад хянах хэсгийг томилно.

2.4.Тухайн насанд уралдах морь, уралдаанч хүүхэд (цаашид “уралдаанч хүүхэд” гэх)-ийг бүртгэх, дугаар олгох Бүртгэлийн дэд хороог Хороо байгуулна.

2.5.Тухайн насны хурдан морины уралдааныг хариуцсан даамал нь гараа, бариаг зохион байгуулах, түрүүлсэн, айрагдсан морьдыг цоллуулах, уяач, уралдаанч хүүхэд, морины бай шагналыг олгох, уралдаантай холбоотой гарсан санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, хариу өгөх, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан гаргах ажлыг хариуцна.

2.6.Салбар хорооны автомашин өөрийн таних тэмдэгтэй байна.

2.7.Салбар хороо уралдаан зохион байгуулахаас өмнө дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

2.7.1.Баяр наадам эхлэхээс 10 хоногийн өмнө морины бэлчээр, худаг ус, морь шүдлэх цэг, уралдах замыг (замын дагуух бартаа, гуу жалга гэх мэт) үзэж засаж сайжруулах, цэвэрлэх болон холбогдох бусад арга хэмжээг авах, морь барианы газар хэрэглэх эрчим хүч, холбооны эх үүсвэрийг зохицуулах, Салбар хорооны гишүүд, шүүгчдийн ажиллах нөхцөлийг хангах;

2.7.2.Хурдан морины гарааны зурхайг хурдан морины нас бүрийн ангиллаар тогтоох;

2.7.3.Уралдаанч хүүхдийг ослын даатгалд хамруулсан эсэх, тусгай зориулалтын хамгаалалтын малгай, цээживч, өвдөг, тохойны хамгаалалт, эмээлтэй бол хүүхдийн гуталд таарсан хамгаалалт бүхий дөрөөтэй эсэхийг хянаж, уралдааны аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах;

2.8.Энэ дүрмийн 2.7.3-т заасныг хангасан эсэхэд Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 10.3-т заасны дагуу хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянана.

Гурав.Уяачид тавих шаардлага

3.1.Уяач нь Үндэсний их баяр наадмын тухай хууль болон энэ дүрэмд заасан эрхийг эдэлж, доорх үүргийг ёсчлон биелүүлнэ:

3.1.1.хууль тогтоомж, энэ дүрмийг сахин биелүүлэх;

3.1.2.хурдан морийг 8 болон түүнээс дээш настай, морь унаж, давхиулж сурсан, бие эрүүл хүүхдээр унуулах;

3.1.3.уралдаанч хүүхдийг ослын даатгалд заавал хамруулсан байх;

3.1.4.хурдан морины эмээл, энэ дүрмийн 2.7.3-т заасан хамгаалах хэрэгслийг тухайн морь, хүүхдийн биед тохируулж, аюулгүй байдлыг хангасан байх;

3.1.5.уралдаанч хүүхдэд морины зурхайд хүрч, зөвхөн даамлын дохиогоор морио эргүүлэх, морийг замын дундаас оруулахгүй, уралдааны замыг товчлохгүй, гүйцэж ирсэн моринд саад учруулахгүй, бусад хүүхэдтэй хүндэтгэлтэй харьцах талаар заавар, зөвлөгөө өгч ойлгуулсан байх;

3.1.6.уралдааны үед морины эзэн, уяач, уралдаанч хүүхэд холбооны техник хэрэгсэл ашиглан уралдааныг удирдахгүй байх, хүний биеийг гэмтээх эд зүйл авч яваа эсэхийг шалгах, тийм зүйл өгч явуулахгүй байх;

3.1.7.уралдаанч хүүхэд тухайн морийг унаж уралдахаас татгалзвал албадахгүй байх, морь унуулах зөвшөөрлийг уралдаанч хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагчаас авсан байх;

3.1.8.уралдаанч хүүхдийн төрсний гэрчилгээ болон эрүүл мэндийн даатгалын гэрчилгээг бүрдүүлсэн байх;

3.1.9.уралдааны үед мориноос унаж бэртэж гэмтсэн уралдаанч хүүхдийн талаар эрүүл мэндийн болон хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагад заавал мэдэгдэж, дэмжлэг туслалцаа үзүүлсэн байх;



3.1.10.мориноос унаж бэртэж гэмтсэн уралдаанч хүүхдэд анхны тусламж үзүүлэх, шаардлагатай эм, тариа, бусад зүйлээр хангах, учирсан хохирлыг нөхөн төлөх, авсан арга хэмжээний талаар баяр наадмын салбар хороо, түүний эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх.

Дөрөв.Хурдан морь уралдуулах зай

4.1.Хурдан морийг насны ангиллаар нь дараах зайд уралдуулна:

- 4.1.1.Азарга - 22-24 км;
- 4.1.2.Их нас - 24-26 км;
- 4.1.3.Соёолон - 22-24 км;
- 4.1.4.Хязаалан - 15-17 км;
- 4.1.5.Шүдлэн - 12-14 км;
- 4.1.6.Даага - 10-12 км.

4.2.Салбар хороо нь тухайн жилийн цаг агаарын байдал, малын тарга хүчийг харгалзан спортын холбоо, Мал эмнэлгийн ерөнхий газраас гаргасан саналыг үндэслэн уралдааны зайг өөрчлөн тогтоож болно.

4.3.Улсын баяр наадмын хурдан морины уралдааныг дараах өдрүүдэд зохион байгуулна:

- 4.3.1.Хязаалан, шүдлэн нас - 7 дугаар сарын 10-ны өдөр;
- 4.3.2.Азарга, их нас - 7 дугаар сарын 11-ний өдөр;
- 4.3.3.Соёолон, даага - 7 дугаар сарын 12-ны өдөр.

4.4.Аймаг, сумын баяр наадмын хурдан морины уралдааныг зохион байгуулах өдрийг аймаг, сумын баяр наадмыг зохион байгуулах хороо тогтооно.

Тав.Хурдан морийг шүдлэх, сэвээг хэмжих, сэвээний дээд хэмжээ

5.1.Уралдааныг азарга, их нас, соёолон, хязаалан, шүдлэн, даага гэсэн 6 насны ангиллаар зохион байгуулна.

5.2.Уралдахаар шүдлэгээ, хэмжилтийн хэсэгт ирсэн морийг шүдэлж, түүний дараа сэвээний өндрийг хэмжинэ.

5.3.Баяр наадмын хурдан морины уралдаанд уралдах морины сэвээний өндөр нь нас тус бүрд дараах хэмжээтэй байна:

5.3.1.Азарга, соёолон - 140 см;

5.3.2.Их нас -141 см;

5.3.3.Хязаалан - 137 см;

5.3.4.Шүдлэн - 132 см;

5.3.5.Даага - 127 см.

5.4.Сэрвээний өндөр хэмжих Ажлын хэсгийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн холбооны саналыг үндэслэн Салбар хорооны дарга томилно.

5.5.Сэрвээний өндрийг автомат төхөөрөмж (лазер хэмжигч)-өөр хэмжих бөгөөд төхөөрөмжийг Стандарт, хэмжил зүйн газраар баталгаажуулсан байна.

5.6.Сэрвээний өндөр хэмжих ажиллагаа, уралдаанд бүртгүүлсэн морь, уяач, уралдаанч хүүхэдтэй холбоотой мэдээллийг дэлгэцээр болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд нээлттэй харуулна.

Зургаа.Уралдах морьдыг бүртгэх, дугаар олгох

6.1.Хурдан морины уралдаанд энэ дүрмийн шаардлагыг хангасан уралдаанч хүүхэд, уяачийг оролцуулна.

6.2.Уралдаанч хүүхэд, уралдах морийг Салбар хорооноос тогтоосон хугацаанд, заасан газарт дараах баримт бичгийг үндэслэн бүртгэж, дугаар олгоно:

6.2.1.хурдан морь унахыг зөвшөөрсөн тухай уралдаанч хүүхэд, түүний эцэг, эх, асран хамгаалагчийн тодорхойлолт;

6.2.2.уралдаанч хүүхдийн төрсний гэрчилгээ болон хүүхдийг ослын даатгалд даатгуулсан тухай бичиг баримт;

6.2.3.уралдах морины нас, угшлын талаарх үнэн зөв тодорхойлолт.

6.3.Бичиг баримтыг бүрдүүлээгүй буюу уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг бүрэн хангаагүй тохиолдолд тухайн уяачийн морийг уралдаанд оролцуулахгүй.

6.4.Уяач Салбар хорооноос олгосон дугаарыг уралдаанч хүүхдийн биед хойд, урд талаас нь харагдахуйц бэхэлсэн байна.

6.5.Бүртгэх цагаас хоцорсон уралдаанч хүүхэд, уралдах морийг бүртгэхгүй, уралдаанд оролцуулахгүй.

Долоо.Уралдааны гарааны үеийн зохион байгуулалт

7.1.Манлайлагч уралдах морьд цуглармагц төрийн далбааг мандуулан, бүх морьдыг дагуулан нэгдсэн журмаар гарааны зүг хөдөлнө.

7.2.Их насны мориноос бусад насны морийг бэлтгэсэн талбайд шүдлэх бөгөөд тухайн насны морины шүдлэгээнд тэнцээгүй морийг тусгай хашаанд оруулж, уралдаанч хүүхдэд олгосон дугаарыг хураан авч уралдаанд оролцуулахгүй.

7.3.Морьдыг гарааны зурхайд хүргэж эргүүлэхийг тухайн насны морины уралдааны даамал, дэд даамал, тусгайлан бэлтгэсэн хүмүүс хамтран гүйцэтгэнэ.

7.4.Уралдааныг гарааны зурхайгаас даамлын дохиогоор эхлүүлнэ.

7.5.Гарааны зурхайд хүрээгүй байхад морь эргүүлэх, замын дундаас морь оруулахыг хориглоно.

7.6.Гарааны зурхайд хүрч, даамлын дохиогоор эргээгүй болон замын дундаас оруулсан морийг барианд барихгүй, байр эзлүүлэхгүй.

Найм.Уралдааны үеийн зохион байгуулалт

8.1.Уралдааны үед тухайн насны хурдан морины уралдааныг хариуцсан даамал төрийн далбааг мандуулан, эхний мориноос 100 метрээс холгүй зайд өмнө нь явж замчилна.

8.2.Хүн, мал эмнэлгийн тусламжийн хэсэг уралдааны замд өртөөчлөн байрлаж, мориноос унасан хүүхэд, уралдааны замд гэмтсэн моринд шаардлагатай тусламж, үйлчилгээг яаралтай үзүүлнэ.

8.3.Уралдах морийг гарааны зурхайд урьдчилан аваачих, замаас оруулах, хөөх, саад хийх, уралдаж байгаа морьдыг тосон цулбуурдаж хөтлөхийг хориглох бөгөөд эдгээр зөрчил гаргасан тохиолдолд дүрс бичлэг, баримт нотолгоо зэргийг үндэслэн тухайн морийг уралдаанаас хасна.

8.4.Хурдан морины уралдааныг Салбар хорооноос олгосон зөвшөөрөл бүхий тээврийн хэрэгсэл дагана.

8.5.Уралдааныг дагах авто машины тоог 8 хүртэл байхаар зөвхөн Салбар хорооны дарга тогтооно.

8.6.Хэвлэл мэдээллийн ажилтан Салбар хорооны зөвшөөрөлтэйгээр уралдаанд саад болохгүйгээр, аюулгүй байдлыг хангаж, 30 метрээс доошгүй зайнаас уралдааныг дагаж нэвтрүүлэг, бичлэг хийж болно. Уралдааны морьдтой хэт ойртохгүй, Салбар хорооны болон эмнэлгийн болон бусад автомашинд саад болохгүй байна.

Ес.Барианы үеийн зохион байгуулалт

9.1.Барианы зурхайг цагаан шугамаар тэмдэглэсэн байна.

9.2.Уралдаж ирсэн эхний таван морийг морь бариач барих бөгөөд бусад морийг дүрс, дуу бичлэгийн техник хэрэгсэл ашиглан барианы зурхайд орсон дараалал, хүүхдийн дугаараар нь байр эзлүүлнэ.

9.3.Барианд орсон морьдыг дөрвөөс доошгүй дуудагчийн цуваа болон зурхайн баруун, зүүн талаас бичсэн дүрс бичлэгийг харгалзан бүртгэлийн цувааг гаргах бөгөөд маргааныг тухайн насны уралдааны даамал, Салбар хороо шийдвэрлэнэ.

9.4.Хүүхэдгүй уралдаж ирсэн морийг таван байраар ухрааж барина. Жолоог нь дэл, сойлго, эмээлд нь уяж бэхлэх зэрэг зориуд хүүхэдгүй уралдуулсан морийг хасна.

9.5.Морьд барианд нэгэн зэрэг орсон бол барианы зурхайд түрүүлж хошуу нь давсан морийг, морьдын хошуу нэгэн зэрэг давсан тохиолдолд зөв талын морийг барих бөгөөд үүнийг дуудагчийн цуваа болон дүрс бичлэгийн техник хэрэгсэл ашиглан тогтооно.

Арав.Морь цоллох, бай шагнал олгох журам

10.1.Баяр наадамд түрүүлсэн, айрагдсан морьдыг эзэн, уяач, уралдаанч хүүхдийн нэрээр цоллон алдаршуулж, бай шагналыг наадамчдын өмнө олгоно.

10.2.Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 10.10-т заасны дагуу зургаагаас аравдугаар байр эзэлсэн бүх насны морийг хурдан морины салбар хороо орон даяар нийтэд зарлана.

10.3.Улсын баяр наадмын хурдан морины уралдааны нас тус бүрийн уралдаанд уралдсан нийт морьдын 30 хүртэл хувийг барьж, бай шагналыг 7 дугаар сарын 11, 12, 13-ны өдөр Салбар хорооны байранд олгоно.



10.4.Түрүүлсэн, айрагдсан хурдан моринд олгох мөнгөн шагналын 20-оос доошгүй хувь нь уралдаанч хүүхдэд ногдоно.

Арван нэг.Хурдан морины уралдааны мэдээ, тайлан

11.1.Тухайн насны хурдан морины уралдааныг хариуцсан даамал уралдаанд оролцсон морьд, уралдаанч хүүхдийн тоо, түрүүлсэн, айрагдсан, барианд орсон морьдын бүртгэл, олгосон бай шагнал, эмнэлгийн тусламж үзүүлсэн хурдан морьд, уралдаанч хүүхдийн талаар болон дараа жилийн уралдаанд анхаарах асуудлын тухай тодорхой санал, дүгнэлт бүхий тайланг Салбар хороонд ирүүлнэ.

11.2.Салбар хороо тайланг нэгтгэж баяр наадмын “Хурдан морины уралдаан зохион байгуулсан тухай” нэгдсэн тайлан гаргаж, зардлын зарцуулалтыг хавсарган Хороонд хүргүүлнэ.

Арван хоёр.Бусад зүйл

12.1.Хурдан морины уралдаантай холбогдон гарсан маргааныг Салбар хороо шийдвэрлэнэ.

12.2.Салбар хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл Хороонд, Хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд тус тус гомдол гаргаж болно.

12.3.Хууль тогтоомж, энэ дүрмийг зөрчсөн буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---

Засгийн газрын 2022 оны 257 дугаар
тогтоолын 4 дүгээр хавсралт

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ҮНДЭСНИЙ СУРЫН ХАРВААНЫ ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Үндэсний их баяр наадмын үндэсний сурын харваа (цаашид “Сурын харваа” гэх)-г зохион байгуулахад Үндэсний их баяр наадмын тухай хууль болон энэ дүрмийг мөрдөнө.

1.2.Баяр наадмын сурын харвааны энэ дүрэмд заагаагүй харилцааг Үндэсний их сурын цуваа харвааны дүрэмд зааснаар зохицуулна.

Хоёр.Сурын харвааны салбар хороо

2.1.Үндэсний их баяр наадмын үндэсний сурын харвааг Сурын харвааны салбар хороо (цаашид “Салбар хороо” гэх) хариуцан зохион байгуулна.

2.2.Салбар хорооны бүрэлдэхүүнийг Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороо (цаашид “Хороо” гэх) батална.

2.3.Сурын харвааны шүүлтийг Монголын үндэсний харваачдын холбооны шүүгчдийн зөвлөл гүйцэтгэнэ.

Гурав.Харваачдыг бүртгэх

3.1.Баяр наадмын сурын харваанд оролцох харваачид нь аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцсаны үндсэн дээр тогтоосон өдөр, хугацаанд харьяа холбоо, багаар бүртгүүлнэ.

3.2.Бүртгэлээс хоцорсон харваачийг харваанд оролцуулахгүй.

Дөрөв.Сурын харваанд хориглох зүйл

4.1.Сурын харвааны үед дараах зүйлсийг хориглоно:

4.1.1.Үндэсний сурынхаас өөр төрлийн харвааны хэрэгслээр харваанд оролцох;

4.1.2.эрхийвчлэхээс өөр арга барилаар харваа үйлдэх.

4.2.Салбар хороо нь баяр наадмын сурын харваанд эхний 8 байр эзэлсэн харваачаас сэргээшийн шинжилгээнд сорьц авах ажлыг Хорооноос баталсан журмын дагуу Допингийн үндэсний төвтэй хамтран зохион байгуулна.

Тав.Харвааны дүнг гаргах

5.1.Харваачдыг хана болон хасаа суранд оносон онооны нийлбэрээр цуваагаар байр эзлүүлнэ.

5.2.Ижил оноотой харваачдыг товх харвуулж шалгаруулна.

5.3.Түрүүлсэн болон байр эзэлсэн харваачдад Үндэсний их баяр наадмын тухай хуульд заасан цол олгоно.



5.4.Түрүүлсэн харваачийн онооны 50 хувиас дээш оноотой харваачдад бай шагнал хүртээнэ.

5.5.Сурын харваатай холбогдон гарсан маргааныг Салбар хороо шийдвэрлэнэ.

5.6.Салбар хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл Хороонд, Хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд тус тус гомдол гаргаж болно.

Зургаа.Өсвөрийн харваа

6.1.Үндэсний их баяр наадмаар өсвөрийн сурын харвааг зохион байгуулж болно.

Долоо.Хариуцлага

7.1.Энэ дүрмийг зөрчсөн салбар хорооны гишүүд, шүүгч, харваачдад Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---

Засгийн газрын 2022 оны 257 дугаар
тогтоолын 5 дугаар хавсралт

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ҮНДЭСНИЙ ШАГАЙН ХАРВААНЫ ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Үндэсний их баяр наадмын үндэсний шагайн харваа (цаашид “Шагайн харваа” гэх)-г зохион байгуулахад энэ дүрмийг мөрдөнө.

1.2.Энэ дүрмийн зорилго нь Үндэсний их баяр наадмаар шагайн харвааны уламжлалыг хадгалан явуулах, “ЮНЕСКО”-д бүртгэгдсэн Үндэсний өв соёлыг сурталчлахад оршино.

1.3.Баяр наадмын шагайн харвааг Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос байгуулсан Шагайн харвааны салбар хороо зохион байгуулна.



Хоёр.Шагайн харвааны үндсэн дүрэм

2.1.Шагайн харвааг ахмадын болон насанд хүрэгчдийн тус бүр 8 харваачтай багийн төрлөөр зохион байгуулна.

2.2.Шагайн харвааг Монголын шагайн харвааны холбоо (цаашид “Холбоо” гэх)-ны дүрмийн дагуу баг тус бүрийн 15 хасааг зурхайд өрж, 2 өрөг харвах бөгөөд хоёр баг өөр өөрийн модон дээр тус бүр нэг өрөг харвана.

2.3.Хоёр өргийн эцэст нөгөө багаасаа хасаа татсан буюу хасаагаа хоёр дахин түрүүлж онож дуусгасан баг хожих бөгөөд хоёр баг хасаагаа ээлжлэн түрүүлж дуусгавал дундын дүүжин тавина. Дүүжин нь 2 мм-ээс зузаангүй, цагаан, төмөр зоос байна.

2.4.Харваачдын сум тавих ээлжийг үе гэх бөгөөд баг тус бүрээс хоёр харваач салаавчлан сууж харвана.

2.5.Харвааны өмнө багуудыг сугалаагаар 4-6 баг бүхий хэсэгт хувааж, бүсчлэх буюу тойрч тоглуулах журмаар явуулна.

2.6.Багуудын тоглолтын хуваарийг зөвхөн сугалаагаар гаргана.

2.7.Шагай харвах үед архи, тамхи хэрэглэхийг хориглоно.

Гурав.Харвааны эдлэл, хэрэглэл

3.1.Баг, харваач тус бүр шагайн харвааны мод, тохой, хасаа, хашлага, тулгуур-сандаг, сумтай байна. Мод нь зурхай, аравч, суурь (сэнтэй) гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

3.2.Шагайн харвааны эдлэл, хэрэглэл нь Холбооны дүрэмд заасан стандартын дагуу, харвах зай нь 472.5 см байна.

Дөрөв.Харваачдад цол олгох

4.1.Баяр наадмын харваанд байр эзэлсэн багийн харваачид Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 12.4-12.7-д заасан цолыг олгоно.

Тав.Бусад зүйл

5.1.Энэ журмаар зохицуулаагүй харилцааг Холбооны дүрмээр зохицуулна.



5.2.Шагайн харваатай холбогдон гарсан маргааныг Салбар хороо шийдвэрлэнэ.

5.3.Салбар хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл Хороонд, Хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд тус тус гомдол гаргаж болно .

5.4.Хууль тогтоомж, энэ дүрмийг зөрчсөн буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---ооо---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 6 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 260

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Монгол Улсыг олон улсад сурталчлан таниулахад онцгой амжилт гаргасан иргэн, баг, хамтлагт Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит мөнгөн шагнал олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төсвийн төсөлд тусгаж байхыг Соёлын сайд Ч.Номин, Сангийн сайд Б.Жавхлан нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

СОЁЛЫН САЙД

Ч.НОМИН



Засгийн газрын 2022 оны 260 дугаар
тогтоолын хавсралт

**МОНГОЛ УЛСЫГ ОЛОН УЛСАД СУРТАЛЧЛАН ТАНИУЛАХАД
ОНЦГОЙ АМЖИЛТ ГАРГАСАН ИРГЭН, БАГ, ХАМТЛАГТ
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН НЭРЭМЖИТ
МӨНГӨН ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Монгол Улсыг олон улсад сурталчлан таниулахад онцгой амжилт гаргасан иргэн, баг, хамтлагийг Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит мөнгөн шагнал (цаашид “Шагнал” гэх)-д нэр дэвшүүлэх, шалгаруулах, шагнал олгохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Шагналыг энэ журмын 2.1-д заасан онцгой амжилт гаргасан 1 иргэн, 1 баг, хамтлагт олгоно.

Хоёр.Шагналд нэр дэвшүүлэх

2.1.Өөрийн үйл ажиллагаа, хүчин чармайлтаараа Монгол Улсыг олон улсын хэмжээнд сурталчлан таниулахад онцгой амжилт гаргасан, Монгол үндэстний үнэт зүйл, Монгол бахархлыг бий болгоход үнэтэй хувь нэмэр оруулсан Монгол Улсын иргэн, баг, хамтлагийг төрийн болон төрийн бус холбогдох мэргэжлийн байгууллага хамтран шагналд нэр дэвшүүлнэ.

2.2.Нэр дэвшүүлэх эрх бүхий этгээд нь нэр дэвшигч иргэн, баг, хамтлагийн талаар дараах баримт бичгийг бүрдүүлэн соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ:

2.2.1.шагналд нэр дэвшүүлсэн үндэслэл бүхий албан бичиг;

2.2.2.шагналд нэр дэвшүүлсэн байгууллагын хурлын тэмдэглэл;

2.2.3.нэр дэвшигч нь өөрийн үйл ажиллагаа, хүч чармайлтаар Монгол Улсыг олон улсын хэмжээнд сурталчлан таниулж, Монгол үндэстний үнэт зүйл, Монгол бахархлыг бий болгоход үнэтэй хувь нэмэр оруулсан талаар тодорхойлолт, гэрчлэх холбогдох бусад баримт;

2.2.4.иргэн, баг, хамтлагийн талаарх дэлгэрэнгүй танилцуулга (иргэний хувьд овог, нэр, регистрийн дугаар, 4х6 хэмжээний 2 хувь цээж зураг (сүүлийн 6 сарын дотор авхуулсан байх), баг, хамтлагийн хувьд байгуулсан шийдвэр, бүртгэлийн гэрчилгээний хуулбар, гишүүдийн



мэдээлэл (иргэний хувьд), үйл ажиллагааны салбар болон чиглэл, алдар цол, гавьяа, шагнал зэрэг бүхий л мэдээлэл);

2.2.5. мөнгөн шагнал шилжүүлэх банкны нэр, дансны дугаар;

2.2.6. шаардлагатай нэмэлт бусад мэдээлэл.

Гурав. Шалгаруулалтыг зохион байгуулах

3.1. Нэр дэвшигч шалгаруулах зорилгоор холбогдох салбарын төлөөллийг оролцуулсан Ажлын хэсгийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр байгуулж, удирдамжийг батална.

3.2. Ажлын хэсэг нь удирдамжийн дагуу шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулж, санал, дүгнэлтээ соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна.

3.3. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд Ажлын хэсэг холбогдох эрх бүхий бусад байгууллагаас тодруулга, лавлагаа, нэмэлт баримт гаргуулан авч болно.

3.4. Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санал, дүгнэлтийг холбогдох баримт материалын хамт хянан үзэж, үндэслэлтэй бол саналаа Засгийн газрын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлнэ.

Дөрөв. Шагнал олгох

4.1. Шагналын хэмжээ иргэнд 200.0 (хоёр зуун) сая төгрөг, баг, хамтлагт 500.0 (таван зуун) сая төгрөг байна.

4.2. Шагналыг Засгийн газрын шийдвэрт үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар олгоно.

4.3. Шагнал олгох арга хэмжээг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулж, Монгол Улсын Ерөнхий сайд гардуулна.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 7 дугаар
сарын 5-ны өдөр

Дугаар 265

Улаанбаатар
хот

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 22¹ дүгээр зүйлийн 22¹.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тухайн жилийн батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг холбогдох байгууллагуудад үүрэг болгосугай.

3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөл (Х.Нямбаатар)-д даалгасугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 143 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Х.НЯМБААТАР

Засгийн газрын 2022 оны 265 дугаар
тогтоолын хавсралт

МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ХӨТӨЛБӨР

(Үндэсний хэмжээнд хэрэгжих)

Удиртгал

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх нь улс орны санхүүгийн салбарын тогтвортой байдал, эдийн засгийн хөгжилд сөргөөр нөлөөлж, улмаар олон улсын санхүүгийн системд аюул заналхийлэл учруулах өндөр эрсдэлтэй байдаг. Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлого нь санхүүгийн салбарын

хямрал үүсгэх, татварын орлогыг бууруулах, төр засгийн бодлогыг сулруулах, санхүүгийн байгууллагуудын нэр хүндэд халдах зэрэг нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг өдөөж, санхүүгийн системийн тогтворгүй байдлыг үүсгэдэг.

Иймд дэлхийн улс орнууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт тогтоогч байгууллага болох Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас гаргасан техник хэрэгжилтийн 40 Зөвлөмж болон үр дүнтэй байдлын 11 Шууд хэрэгжилтийн шалгуурыг хангаж ажиллах замаар эрсдэлээс урьдчилан сэргийлж, санхүүгийн системийн аюулгүй байдлыг хамгаалан, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх тогтолцоогоо бэхжүүлэн ажилладаг.

ФАТФ-ын 40 Зөвлөмжид анх мөнгө угаах гэмт хэргийг авч үздэг байсан бөгөөд 2004 онд терроризмыг санхүүжүүлэх 2012 онд үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх зохицуулалтыг тус тус оруулсан. Мөн 2013 онд ФАТФ-ын үнэлгээний аргачлалыг шинэчилж, Зөвлөмжийн үр дүнтэй байдлыг үнэлэх 11 Шууд хэрэгжилтийн шалгуурыг тодорхойлсон. Улмаар ФАТФ-ын 40 Зөвлөмжид тогтмол өөрчлөлт оруулан сайжруулж байна.

Шинэчлэгдсэн стандартад улс орнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэл, түүнтэй тэмцэх бодлого, зохицуулалтын шаардлагуудыг тусгаснаас гадна мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйлдлийг гэмт хэрэгт тооцох, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, хяналт шалгалтын тогтолцоог бий болгож, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэхийг улс орнуудаас шаарддаг. Цаашлаад дотоод, гадаад болон олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлж, хүн, хуулийн этгээдийн ил тод байдлыг дэмжих шалгууруудыг тусгасан байдаг. Эдгээр шаардлагуудыг хэрэгжүүлснээр аливаа улс орны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо бэхжиж, гэмт этгээдүүд тухайн улс орны санхүүгийн системийг урвуулан ашиглах эмзэг, сул байдлыг арилган, улмаар дэлхийн эдийн засагт аюул заналхийлэл учруулахаас сэргийлсэн тогтвортой, аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлдэг.

ФАТФ, түүний бүс нутаг хариуцсан бүлгээс улс орнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд харилцан үнэлгээ хийж, 40 Зөвлөмжийн техник хэрэгжилт, 11 шууд хэрэгжилтийн шалгуурыг тусгай аргачлалын дагуу үнэлдэг. Улмаар ФАТФ-ын олон улсын стандарт шаардлагыг хангаж ажиллаагүй тохиолдолд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт буюу “Саарал жагсаалт”-д, мөн өндөр эрсдэлтэй хамтран ажилладаггүй орнуудын жагсаалт буюу “Хар жагсаалт”-д оруулах арга хэмжээг авдаг.

Монгол Улсын хувьд ФАТФ-ын Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт 2004 оны 6 дугаар сард гишүүнээр элсэн орж, 2006 оны 7 дугаар сарын 08-ны өдөр анхны Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг баталснаар энэ чиглэлийн тогтолцоог бэхжүүлэх суурийг бүрдүүлсэн. Улмаар Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд 2007, 2017 онуудад Харилцан үнэлгээг хийсэн байна. Эдгээр үнэлгээний үр дүнтэй холбогдуулан Монгол Улс ФАТФ-ын стандартад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх тогтолцоогоо нийцүүлэхээр нэлээдгүй арга хэмжээг авч хэрэгжүүлсэн боловч 2011 онд ФАТФ-ын “Саарал жагсаалт”, 2013 онд “Бараан саарал жагсаалт”, 2019 онд “Саарал жагсаалт”-д тус тус орсон. Улмаар ФАТФ-аас өгсөн үүрэг даалгавруудыг хэрэгжүүлсний дүнд 2014, 2020 онуудад эдгээр жагсаалтаас гарч байжээ.

Монгол Улс цаашид мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоогоо хангалттай түвшинд сайжруулж, ФАТФ-ын стандартын шаардлагуудыг хангаж ажиллах замаар болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эмзэг сул байдлыг арилгах шаардлагатай.

Иймд Монгол Улс нь ФАТФ-ын Зөвлөмж 1, 2-т заасны дагуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийг үнэлж, түүний үр дүнд суурилан хөтөлбөрийг нэн тэргүүнд баталж, үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээ авах нь чухал юм.

Хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо бэхжиж, эдгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаа амжилттай хэрэгжиж, улс орны эдийн засгийн хөгжил, санхүүгийн салбарын тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлнэ. Улмаар Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс 2017 онд хийсэн Харилцан үнэлгээний тайланд дурдсан дутагдлыг арилгах нөхцөл бүрдэхээс гадна дараагийн шатны харилцан үнэлгээний үр дүн амжилттай байх, олон улсын байгууллагын хориг жагсаалтад орохгүй байх үндэс суурь болох юм.

Нэг.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэслэл шаардлага: Монгол Улсын харилцан үнэлгээний тайлан

ФАТФ, түүний бүс нутаг хариуцсан бүлгээс улс орнуудад Харилцан үнэлгээ хийж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ФАТФ-ын стандарт, зөвлөмжийн биелэлтийг тодорхой давтамжтайгаар үнэлдэг. Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх


тогтолцоог Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс хамгийн анх хуучин аргачлалын дагуу 2007 онд үнэлж байсан бол хоёр дахь шатны үнэлгээг шинэчлэгдсэн аргачлалын дагуу 2017 онд хийж, Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог дутагдалтай гэж дүгнэж, ФАТФ-ын Өргөтгөсөн /эрчимтэй/ хяналтад оруулж, Монгол Улсад яаралтай арга хэмжээ авах 15 сарын хугацаа өгсөн.

Иймд 2017 оны дээрх харилцан үнэлгээний үр дүнг сайжруулах зорилгоор Монгол Улсаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тухай бүр ФАТФ-ын Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт тайлагнаж, 2019 оны Явцын тайлангаар нийт 15 Зөвлөмжийн үнэлгээг ахиулсан. Улмаар Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс ФАТФ-ын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн дутагдлыг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг өндрөөр үнэлж, Монгол Улсыг Өргөтгөсөн /эрчимтэй/ хяналтаас ФАТФ-ын Өргөтгөсөн хяналтад шилжүүлсэн бөгөөд жил бүр Явцын тайлан хүргүүлэх үүргийг хүлээсэн.

Зураг 1. Монгол Улсын 2017 оны ФАТФ-ын 40 Зөвлөмжийн үнэлгээ



Зураг 2. Монгол Улсын 2019 оны ФАТФ-ын 40 Зөвлөмжийн үнэлгээ



(ББ-Бүрэн биелүүлсэн, ДБ-Дийлэнхийг биелүүлсэн, ХБ-Хэсэгчлэн биелүүлсэн, Б-Биелүүлээгүй)

Энэ хүрээнд Монгол Улсын зүгээс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны хууль, эрх зүй, зохицуулалтын орчинг бэхжүүлсэн талаарх Явцын тайланг Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт цаг тухайд нь хүргүүлж, 2020 онд нийт 3 Зөвлөмжийн үнэлгээ, 2021 онд 1 Зөвлөмжийн үнэлгээг тус тус сайжруулсан. Одоогийн байдлаар Монгол Улс ФАТФ-ын 40 Зөвлөмжийн 38-ын үнэлгээ нь “Бүрэн биелүүлсэн” эсхүл “Дийлэнхийг биелүүлсэн” үнэлгээтэй бөгөөд 2 Зөвлөмж нь “Хэсэгчлэн биелүүлсэн” үнэлгээтэй байна.

Зураг 3. Монгол Улсын 2020 оны ФАТФ-ын 40 Зөвлөмжийн үнэлгээ



Зураг 4. Монгол Улсын 2021 оны ФАТФ-ын 40 Зөвлөмжийн үнэлгээ



* (ББ-Бүрэн биелүүлсэн, ДБ-Дийлэнхийг биелүүлсэн, ХБ-Хэсэгчлэн биелүүлсэн, Б-Биелүүлээгүй)

Монгол Улсын 2017 оны Харилцан үнэлгээний тайланд ФАТФ-ын үр дүнтэй байдлын 11 Шууд хэрэгжилтийн хувьд нийт 7 Шууд хэрэгжилт дээр ахиц дэвшил гаргаж, үлдсэн 4 Шууд хэрэгжилтийн хүрээнд зарим дутагдалтай байна гэж үнэлсэн. Үүнтэй холбогдуулан, Монгол Улс үнэлгээг сайжруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч, олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажилласан боловч ФАТФ-аас 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт буюу “Саарал” жагсаалтад оруулсан. Иймд ФАТФ-аас үлдсэн 4 Шууд хэрэгжилтийн хүрээнд нийт 6 үүрэг даалгаврыг агуулсан ажлын төлөвлөгөөг боловсруулж, Монгол Улсад тус төлөвлөгөөний хэрэгжилтийг 18 сарын хугацаанд хангахыг үүрэг болгосон.

Улмаар уг үйл ажиллагааны төлөвлөгөөг 12 сарын хугацаанд амжилттай биелүүлэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлснийг Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс газар дээрх хяналт шалгалтаар баталгаажуулсан бөгөөд 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр ФАТФ-аас Монгол Улсыг Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгийн хяналт буюу ФАТФ-ын Саарал жагсаалтаас гарсныг албан ёсоор зарласан. Мөн Монгол Улсыг Европын Холбооны хар жагсаалт гэж нэрлэгддэг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай, өндөр эрсдэлтэй гуравдагч улс орнуудын жагсаалтаас 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр хассан.

ФАТФ, түүний бүс нутаг хариуцсан бүлгээс гишүүн улс орнуудад хийх Харилцан үнэлгээ нь тухайн улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог өргөн цар хүрээгээр үнэлж, илэрсэн дутагдлыг залруулах үүрэг даалгавар өгөх, тогтоосон хугацаанд үүрэг даалгаврыг бүрэн гүйцэтгээгүй тохиолдолд ФАТФ-ын Хар, Саарал жагсаалтаас гадна эрчимтэй (өргөтгөсөн) хяналтад оруулах үндэслэл болж, улмаар улс орны нэр хүндэд сөргөөр нөлөөлөн, бусад улс орнуудын зүгээс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл бүхий улс орон гэж үзсэнээр олон улсад үйл ажиллагаа эрхлэх боломж хязгаарлагддаг.

Иймээс Монгол Улс стратегийн дутагдалтай орнуудын жагсаалт болон Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн өргөтгөсөн хяналтад дахин орохгүй байхын тулд Харилцан үнэлгээний үр дүнг сайжруулахад онцгой ач холбогдол өгч, ФАТФ-ын зөвлөмж, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар гаргасан олон улсын стандартыг дагаж мөрдөх, дотоодын хууль тогтоомжоо нийцүүлэх шаардлагатай байна.

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс хийх дараагийн харилцан үнэлгээ ФАТФ-ын 40 зөвлөмж, 11 шууд хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бүхэлд нь хамруулж, Монгол Улсын хувьд өмнөх үнэлгээнээс хойших хугацаанд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, бодит хэрэгжилт, гаргасан ахиц дэвшил, үр дүнгийн статистик, тоон мэдээлэл, баримт нотолгоонд суурилан хийнэ. Тийм учраас Харилцан үнэлгээний үр дүнгээр дутагдалтай гэж үнэлэгдсэн хэсэгт онцгойлон анхаарч, дутагдлыг залруулах арга хэмжээ авах, хэрэгжилтэд анхаарах, хэрэгжилтийн үр дүнг статистик, тоон мэдээлэлд үндэслэн гаргаснаар Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо бэхжиж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны үр дүнд ахиц гарч, улмаар манай улсад хийгдэх дараагийн Харилцан үнэлгээний үр дүнд ахиц гарах, олон улсад эерэгээр үнэлэгдэх үндэс суурь бий болно.

Иймд Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс хийх дараагийн харилцан үнэлгээнд онцгойлон ач холбогдол өгч бэлтгэх, Харилцан үнэлгээ болон Үндэсний эрсдэлийн үнэлгээгээр илэрсэн эрсдэл, эмзэг байдлыг бууруулах зорилго бүхий, ФАТФ-ын зөвлөмжид нийцсэн хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх замаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай.

Хоёр.Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээ

ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 зөвлөмжийн Зөвлөмж 1, 2-т улс орнуудыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхдээ нэн тэргүүнд өөрийн улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээ бодитоор үнэлж, улмаар эрсдэлийг бууруулах үндэсний хэмжээний бодлого, стратеги боловсруулж хэрэгжүүлэх замаар буюу эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэхтэй холбоотой шаардлагыг тусгасан байдаг.

Тиймээс 2016 онд ФАТФ-ын Зөвлөмж 1, 2-ын шаардлагыг хангах зорилгоор Санхүүгийн мэдээллийн албанаас анхны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, үнэлгээний тайланг боловсруулан гаргасан. Улмаар энэхүү үнэлгээний үр дүнд суурилан үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр” боловсруулсан бөгөөд уг хөтөлбөрийг Хууль зүй, дотоод хэргийн сайдаас Засгийн газарт танилцуулан, Засгийн газрын 2017 оны 143 дугаар тогтоолоор баталсан. Хөтөлбөрийг 2017-2019 онд хэрэгжүүлж, биелэлтийг 2020 онд Үндэсний зөвлөлд танилцуулсан болно.

Дээрх мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийх, үнэлгээний үр дүнд суурилан хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх явцад энэхүү ажил нь маш өргөн хүрээний, улсын хэмжээнд хийгдэх арга хэмжээ болох нь тодорхой болсон учраас зайлшгүй хуулиар зохицуулах шаардлага үүссэн. Улмаар 2018 онд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан, мөн хуулийн 18 дугаар зүйлд Санхүүгийн мэдээллийн албанаас “мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх, уг үнэлгээний үр дүнд суурилсан үндэсний стратеги боловсруулах, уг стратегийг Хамтын ажиллагааны зөвлөлөөр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах” талаар, мөн хуулийн 22¹ дүгээр зүйлд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний бодлого, хөтөлбөрийг боловсруулж, Засгийн газраар батлуулах, түүний хэрэгжилтийг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн эрх зүйн үндсийг анх удаа хуульчилсан байна.

Монгол Улсын хоёр дахь удаагийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг Дэлхийн банкны аргачлалын дагуу хийх, эрсдэлийн үнэлгээнд суурилсан эрсдэлийг бууруулах бодлого, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх ажлыг 2020 оны 2 дугаар сараас эхлэн хийж гүйцэтгэсэн.

Энэ хүрээнд Сангийн сайдын 2020 оны 20 дугаар тушаалаар Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийх ажлын хэсгийг, Сангийн сайдын 2020 оны 90 дүгээр тушаалаар зохицуулалттай салбар тус бүрийн мөнгө угаах,

терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх 11 дэд ажлын хэсгийг тус тус байгуулж ажилласан. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу Санхүүгийн мэдээллийн албанаас Үндэсний эрсдэлийн үнэлгээний ажлыг зохион байгуулалтаар хангаж ажилласан байна.

Дээрх дэд ажлын хэсгүүдэд Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудаас гадна бусад төрийн байгууллага болон төрийн бус байгууллагууд болон холбогдох бүхий л салбарын хувийн хэвшлийн нийт 52 байгууллагын¹ 128 төлөөлөгчид орж ажилласан бөгөөд Дэлхийн банкнаас нийт ажлын хэсгийн гишүүдэд болон дэд ажлын хэсэг тус бүрд эрсдэлийн үнэлгээ хийх цахим сургалтуудыг зохион байгуулсан.

Ажлын хэсгийн зүгээс долоо хоног бүр ажлын явцыг хэлэлцэх, цаашид хийгдэх ажлуудыг тодорхойлох уулзалтуудыг зохион байгуулсан. Эдгээр уулзалтуудын үр дүнд 2020 онд салбар тус бүрийн эрсдэлийн үнэлгээг хийх хэлэлцүүлгүүдийг зохион байгуулав. Улмаар ажлын хэсгээс салбар тус бүрийн эрсдэлийн үнэлгээний үр дүн, дүгнэлтүүдийг урьдчилсан байдлаар боловсруулсан бөгөөд ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтад бэлтгэх зорилгоор нэгдсэн хэлэлцүүлгийг нийт ажлын хэсгийн гишүүн байгууллагууд хамтран 2020 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулав.

Үндэсний эрсдэлийн үнэлгээний тайланг эцэслэн боловсруулах ажлын хүрээнд 2020 оны 10 дугаар сарын 26-30-ны өдрүүдэд нийт 5 өдөр 10 дэд ажлын хэсэг тус бүрийн хийсэн үнэлгээний талаарх хэлэлцүүлгийг Хууль зүй, дотоод хэргийн яам болон Авлигатай тэмцэх газар дээр амжилттай зохион байгуулав. Тус хэлэлцүүлэгт холбогдох яам, төрийн байгууллага, шүүх, прокурор, хууль сахиулах байгууллага, судлаач эрдэмтэд, мэргэжлийн холбоод, мэдээлэх үүрэгтэй этгээд болон хувийн хэвшлийн нийт 250 гаруй төлөөлөл оролцон нийт 10 модулийн тайланг хэлэлцэж, санал дэвшүүлж, сайжруулах талаар үзэл бодлоо илэрхийлсэн.

Үүнээс гадна мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээний үйл явц, үр дүнг дараах хурлуудаар танилцуулж, хэлэлцсэн. Үүнд:

¹Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Гадаад харилцааны яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба, Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Нийслэлийн прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Терроризмтой тэмцэх зөвлөл, Санхүүгийн зохицуулах хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Монголын хуульчдын холбоо, Монголын өмгөөлөгчдийн холбоо, Монголын нотариатчдын танхим, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт, банк, банкнаас бусад санхүүгийн байгууллага, санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид зэрэг мэдээлэх үүрэгтэй этгээдүүд.

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн 2021 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн ээлжит хурал;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Хамтын ажиллагааны зөвлөлийн 2021 оны 5 дугаар сарын 13-ны өдөр болон 7 дугаар сарын 9-ний өдрийн ээлжит хурал;
- Терроризмтой тэмцэх зөвлөлийн 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн хуралдаан.

Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийснээр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх нөөцийг оновчтой хуваарилах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах боломж нөхцөл бүрдэх ба нөгөө талаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны бодит үр дүнг нэмэгдүүлж, улмаар Харилцан үнэлгээний үр дүнг ахиулах, Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог чанаржуулах ач холбогдолтой.

Иймд Дэлхийн банкны аргачлалын дагуу хийж гүйцэтгэсэн Монгол Улсын хоёр дахь удаагийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний үр дүн нь Монгол Улсын Харилцан үнэлгээний үр дүнгийн нэгэн адил “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр”-ийн үндэс суурь болно.

Үндэсний эрсдэлийн үнэлгээний аргачлал, ерөнхий үр дүн:

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ФАТФ-ын стандарт, шаардлагын хүрээнд аливаа улс орны хөтөлбөр нь Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэдэг. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг тогтмол, шаардлагатай тохиолдолд нөхцөл байдалд уялдуулан шинэчлэх хэрэгтэй. Улмаар тус үнэлгээний үр дүнд илэрсэн эрсдэл, аюул заналхийлэл, эмзэг сул байдлыг арилгах чиглэлээр үндэсний хэмжээний хөтөлбөр, бодлого стратегийг тодорхойлох тухай шаардлагыг ФАТФ-ын техник хэрэгжилтийн Зөвлөмж 1, 2 болон үр дүнтэй байдлын Шууд хэрэгжилт 1-д заасан. ФАТФ-ын шаардлагын дагуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг улс орны түвшинд, салбарын түвшинд болон байгууллага, институцийн түвшинд авч хэрэгжүүлнэ. Үндэсний эрсдэлийн үнэлгээгээр илэрсэн эрсдэл, эмзэг сул талтай уялдуулан улс орны түвшинд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого, стратегийг тодорхойлно. Харин байгууллагын түвшинд дотоод хяналтын хөтөлбөр, бизнес төлөвлөгөөг боловсруулан гаргаж, нөөцийн зохистой хуваарилалт, үр дүнтэй эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх давуу талтай.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хоёр дахь удаагийн Үндэсний эрсдэлийн үнэлгээг 2020 онд Дэлхийн банкны аргачлалын дагуу хийх ажлын хүрээнд 2017-2020 оныг хамарсан тоон

болон чанарын мэдээллийг бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, журам, холбогдох байгууллагаас ирүүлсэн мэдээлэл, ярилцлага, судалгаа, хэлэлцүүлэг, олон улсын байгууллагаас гаргасан тайлан мэдээ болон нээлттэй эх сурвалжаас цуглуулсан өгөгдөл мэдээлэлд дүн шинжилгээ хийх замаар хийв.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээг өндөр эрсдэлтэй салбарт төвлөрүүлснээр хөтөлбөрийн зорилтуудыг үр дүнтэй хэрэгжүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах болон санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, нөөц бололцоог зохистой хуваарилах ач холбогдолтой. Ингэхдээ эрсдэл багатай гэж үнэлэгдсэн үйл ажиллагааг мөн харгалзаж үзэх бөгөөд бага эрсдэлтэй тохиолдолд ФАТФ-ын зөвлөмжийн дагуу хялбаршуулсан журмаар хэрэгжүүлэх боломжтой.

Үндэсний эрсдэлийн үнэлгээ нь мөнгө угаах аюул заналхийллийн үнэлгээ, мөнгө угаах эмзэг байдлын үнэлгээ, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл болон санхүүгийн хүртээмжтэй бүтээгдэхүүний эрсдэл гэх дөрвөн үндсэн хэсгээс бүрдэнэ. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд банк, үнэт цаас, даатгал зэрэг зохицуулалттай салбаруудын аюул заналхийлэл, эмзэг байдлыг харгалзан үзсэн. Үндэсний тэмцэх чадварын үнэлгээ нь хууль эрх зүйн орчин, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын чадавх, нөөц бололцоо, бие даасан байдлыг үнэлэхэд чиглэнэ. Монгол Улсын хоёр дахь удаагийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний үр дүнг ерөнхийлөн Зураг 5-д харуулав. Энэ эрсдэлийн үр дүнд үндэслэн Модуль тус бүрийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг холбогдох ажлын хэсгүүд хамтран боловсруулсан.

Зураг 5. Үндэсний эрсдэлийн үнэлгээ 2021 ерөнхий үр дүн



Гурав.Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийн тухай

“Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр” (цаашид “Хөтөлбөр” гэх)-ийг батлан, үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх нь Улсын Их Хурлын 2020 оны 52 тоот тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 оны хооронд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Улсын Их Хурлын 2021 оны 106 тоот тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”, Улсын Их Хурлын 2020 оны 23 тоот тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын Их Хурлын 2020 оны 24 тоот тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ач холбогдолтой.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болох “Алсын хараа-2050”-ын 4.3 дугаар зорилтод “Олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон олон тулгуурт, хүртээмжтэй санхүүгийн системийг хөгжүүлэх” хүрээнд “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо боловсронгуй болсон байх”-аар заасан.

Хөтөлбөрийн дагуу 2022-2030 онд 8 стратеги зорилгын хүрээнд зорилтуудыг хэрэгжүүлэхээр тусгасан болно. Эдгээр стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэх чиглэлээр авах арга хэмжээ, хийж гүйцэтгэх ажлуудыг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд үндсэн болон хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудын хамт нарийвчлан тусгах болно.

Хөтөлбөр нь эрсдэлд суурилсан бөгөөд Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүнд тодорхойлсон бага эрсдэлтэй салбаруудаас илүү өндөр эрсдэлтэй гэж үнэлсэн үйл ажиллагаанд төвлөрөн боловсруулсан болно.

Хөтөлбөр нь дараах бүтэцтэй. Үүнд:





Хөтөлбөрийг ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 Зөвлөмж, үр дүнтэй байдлын 11 Шууд хэрэгжилт,² Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүн болон олон улсын байгууллагуудаас өгсөн зөвлөмжийг үндэслэн боловсруулав. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ялангуяа хөтөлбөрөөр дэвшүүлсэн зорилтуудад хүрэхэд өндөр түвшний улс төрийн дэмжлэг, хангалттай нөөц бололцоо болон төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа чухал ач холбогдолтой.

Хөтөлбөрийн зорилго, зорилтууд

Хөтөлбөрийн Эрхэм зорилго:

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх тогтолцоог олон улсын стандарт, зөвлөмжид нийцүүлэн боловсронгуй болгоход энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Хөтөлбөрийн зорилгод хүрэхийн тулд дараах 8 зорилгуудыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Үүнд:

Хөтөлбөрийн зорилгууд	
Зорилго 1	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбогдох хувьсан өөрчлөгдөж буй эрсдэлийн ойлголтыг сайжруулах
Зорилго 2	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үүрэг, хариуцлага, эрсдэлийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх
Зорилго 3	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод болон гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх
Зорилго 4	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлд суурилсан бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлэх
Зорилго 5	Мэдээлэх үүрэгтэй этгээдэд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх замаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх
Зорилго 6	Терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлж болзошгүй үйлдлийг таних, мөнгө угаах үйлдлийг илрүүлэх ажиллагааг сайжруулах
Зорилго 7	Суурь гэмт хэрэг нь эрсдэлтэй гэж үнэлсэн мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах, шүүхээр шийдвэрлэх болон хөрөнгө хураахтай холбоотой ажиллагааны чанарыг сайжруулах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт сонор сэрэмжтэй хандах

²Хавсралт 1-ээс харна уу.

Зорилго 8	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зохистой бүтэц, зохион байгуулалт, чадавхыг бэхжүүлэх
-----------	---

Зорилго 1: Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбогдох хувьсан өөрчлөгдөж буй эрсдэлийн ойлголтыг сайжруулах

Ач холбогдол:

Монгол Улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлийн нөхцөл байдлыг тодорхойлох, эрсдэлийн ойлголтыг төр, хувийн хэвшлийн байгууллагуудад тасралтгүй нэмэгдүүлэх шаардлагатай. Энэ хүрээнд үндэсний, салбарын болон байгууллагын түвшний эрсдэлийг тогтмол бөгөөд нөхцөл байдалтай уялдуулан тухай бүрд үнэлэх нь цаашдын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх бодлого, стратегийг оновчтой тодорхойлох, үр дүнтэй хэрэгжүүлэх, болзошгүй эрсдэлийг бууруулахад ач холбогдолтой байна.

Холбогдох ФАТФ-ын техник хэрэгжилтийн Зөвлөмж ба үр дүнтэй байдлын Шууд хэрэгжилт
Зөвлөмж 1, 2, 15, 24, 25, 33, 34
Шууд хэрэгжилт 1-11

Зорилго 1-ийн зорилтууд

Зорилт 1.1.	Үндэсний эрсдэлийг тогтмол хянаж, мөнгө угаах, терроризм, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх аюул занал, салбарын эмзэг байдлын өөрчлөлтийг үнэлэх
Зорилт 1.2.	Тухайлсан салбар, чиглэл болон шинээр үүсэж буй стратегийн шинжтэй аюул занал, чиг хандлага, типологи, эрсдэлийн дохио /нөхцөл байдал/-г харгалзан бусад эрсдэлийг үнэлэх, шинэчлэх
Зорилт 1.3.	Салбарын болон мэдээлэх үүрэгтэй этгээдийн эрсдэлийг оновчтой тодорхойлж, хяналт шалгалтын үйл ажиллагааг уялдуулах
Зорилт 1.4.	Үндэсний болон салбарын эрсдэлийн үнэлгээг харгалзан мэдээлэх үүрэгтэй этгээд өөрийн үйл ажиллагааны түвшинд эрсдэлийн үнэлгээг тогтмол хийх, шинэчлэх
Зорилт 1.5.	Эрсдэлийн үнэлгээгээр бага эрсдэлтэй гэж тодорхойлсон үр дүнг тогтмол нягтлах, шинэчлэх
Зорилт 1.6.	Мөнгө угаах, терроризм болон зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны статистик мэдээлэл гаргах, нэгтгэх ажлыг ФАТФ-ын стандартад нийцүүлэх



Зорилго 2: Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үүрэг, хариуцлага, эрсдэлийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх

Ач холбогдол:

Уг зорилт нь ФАТФ-ын зөвлөмж бүрийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд болон шууд хэрэгжилтийн үнэлгээг дээшлүүлэхэд чиглэсэн болно.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн байгууллагуудаас гадна олон нийтийн оролцоо чухал. Мөн мэдээлэх үүрэгтэй этгээд төрийн байгууллагуудын нэгэн адилаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлийн талаарх мэдлэгтэй байх нь уг эрсдэлийг бууруулах арга хэмжээг үр дүнтэй авахад дэмжлэг үзүүлнэ.

Мэдээлэх үүрэгтэй этгээд Үндэсний эрсдэлийн үнэлгээ, салбарын, сэдэвчилсэн болон стратегийн эрсдэлийн үнэлгээний үр дүнгийн талаарх мэдлэг, мэдээлэлтэй болсноор байгууллагын түвшинд эрсдэлийн үнэлгээ хийхэд ач холбогдолтой. Мөн хууль тогтоомж, стандартад сүүлийн үед орсон өөрчлөлтүүдийн талаарх өөрсдийн мэдлэгийг тогтмол шинэчилж байх шаардлагатай. Цаашлаад Зөвлөмж 1, 8 болон 15-д заасны дагуу үй олноор зэвсэг дэлгэрүүлэх, ашгийн бус байгууллага, виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нарын үйл ажиллагаанд учирч болох холбогдох эрсдэлийг тодорхойлох, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх арга хэмжээг авах шаардлагатай.

Иймд энэхүү зорилгыг хэрэгжүүлэх нь мэдээлэх үүрэгтэй этгээдийн ойлголт, оролцоог идэвхжүүлэхээс гадна төрийн байгууллага болон бусад оролцогчдын мэдлэг, ойлголтыг тасралтгүй сайжруулахад ач холбогдолтой байна.

Холбогдох ФАТФ-ын техник хэрэгжилтийн Зөвлөмж ба үр дүнтэй байдлын Шууд хэрэгжилт
Зөвлөмж 1, 2, 6-7, 15, 33, 34
Шууд хэрэгжилт 1, 3-4, 10-11

Зорилго 2-ын зорилтууд	
Зорилт 2.1.	Үндэсний эрсдэлийн үнэлгээ, бусад эрсдэлийн үнэлгээний үр дүнг мэдээлэх үүрэгтэй этгээд болон холбогдох байгууллагуудад таниулах

Зорилт 2.2.	Мэдээлэх үүрэгтэй этгээдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үүрэг хариуцлагын талаарх мэдлэгийг дээшлүүлэх ажлыг тогтмол хэрэгжүүлэх
Зорилт 2.3.	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үүрэг хариуцлагын талаарх ойлголт, мэдлэг олгох
Зорилт 2.4.	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх

Зорилго 3: Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод болон гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх

Ач холбогдол:

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх гэмт хэрэг нь үндэстэн дамнаж, төрөл бүрийн салбарыг ашиглан нарийн зохион байгуулалттай үйлдэгддэг. Иймээс энэ чиглэлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд гадаад болон дотоод хамтын ажиллагаа, түншлэл нэн чухал.

Дотоод хамтын ажиллагааг сайжруулах замаар төр, хувийн хэвшлийн байгууллагууд харилцан мэдээлэл солилцож, уялдаа холбоотой хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх нь гэмт хэрэгтнүүд гадаад улс руу оргон зайлах, хууль бусаар олсон хөрөнгө, орлогоо өөр улсад шилжүүлэн байршуулах явдлыг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой. Харин гадаад хамтын ажиллагааг сайжруулснаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх олон улсын хүчин чармайлтад дэмжлэг үзүүлэх юм. Гадаад болон дотоод хамтын ажиллагааг бэхжүүлснээр цаашдын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх гэмт хэргийн эрсдэл багасах боломж бүрдэнэ.

Холбогдох ФАТФ-ын техник хэрэгжилтийн Зөвлөмж ба үр дүнтэй байдлын Шууд хэрэгжилт

Зөвлөмж 1, 2, 9, 15, 24-25, 32-33, 36-40

Шууд хэрэгжилт 1-11

Зорилго 3-ын зорилтууд

Зорилт 3.1.	Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөл, ажлын хэсгүүдийн хүрээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх аюул занал, эрсдэлийг бууруулах чиглэлээр бодлогын болон үйл ажиллагааны түвшинд хамтын ажиллагааг бэхжүүлэх
-------------	--



Зорилт 3.2.	Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих
Зорилт 3.3.	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого тодорхойлох, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх
Зорилт 3.4.	Мэдээлэл солилцох болон хууль сахиулах чиглэлээр гадаад хамтын ажиллагааг бэхжүүлэх
Зорилт 3.5.	Дотоод болон гадаад улсын эрх бүхий байгууллагатай түргэн шуурхай мэдээлэл солилцох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, хэрэгжилтийг хангах
Зорилт 3.6.	Олон улсын болон гадаад улсын хяналт шалгалтын эрх бүхий байгууллагатай хамтын ажиллагааг бий болгох, өргөжүүлэх
Зорилт 3.7.	Мөнгө угаах, түүний суурь гэмт хэргийг мөрдөн шалгах, хөрөнгө буцаах чиглэлээр эрх зүйн туслалцааг харилцан үзүүлэх ажиллагааг үр дүнтэй, түргэн шуурхай хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх

Зорилго 4: Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлд суурилсан бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлэх

Ач холбогдол:

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үр дүнтэй тогтолцоог бий болгох урьдач нөхцөл нь энэ талаарх эрсдэлийн ойлголтод үндэслэн эрсдэлд суурилсан, эрсдэлийг бууруулах бодлого, стратеги хэрэгжүүлэхэд оршино. Иймд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлд суурилсан бодлого, арга хэмжээг хөтөлбөрөөр дамжуулан төрийн байгууллагуудын хэмжээнд хяналт шалгалтын болон хууль сахиулах байгууллагуудын стратеги, бодлогод тусгах замаар, мөн мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийн хувьд байгууллагын түвшний бодлого, төлөвлөгөөнд тусгах замаар хэрэгжүүлнэ.

Холбогдох ФАТФ-ын техник хэрэгжилтийн Зөвлөмж ба үр дүнтэй байдлын Шууд хэрэгжилт

Зөвлөмж 1-4, 15, 24-33

Шууд хэрэгжилт 1-11

Зорилго 4-ийн зорилтууд

Зорилт 4.1.	Эрсдэлийн үнэлгээ, хөтөлбөрийн хэрэгжилт, бусад нөхцөл байдалд үндэслэн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг шинэчлэх
-------------	--

Зорилт 4.2.	Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн байгууллагын стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөнд эрсдэлийг бууруулах арга хэмжээг тусгаж хэрэгжүүлэх
Зорилт 4.3.	Мөнгө угаах болон өндөр эрсдэлтэй суурь гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх, холбогдох хөрөнгө хураахад чиглэсэн аргачлал, заавар, зөвлөмж гаргах, шинэчлэх
Зорилт 4.4.	Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүн болон мэдээлэх үүрэгтэй этгээдийн эрсдэлийн хувийн хэрэгт үндэслэн хяналт шалгалтын стратегийг шинэчлэх, гаргах
Зорилт 4.5.	Мэдээлэх үүрэгтэй этгээдийг хянан шалгахдаа эрсдэлд суурилсан дотоод хяналтын хөтөлбөр хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих
Зорилт 4.6.	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх

Зорилго 5: Мэдээлэх үүрэгтэй этгээдэд эрсдэлд суурилсан үр дүнтэй хяналт шалгалтыг хэрэгжүүлэх замаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх

Ач холбогдол:

Мэдээлэх үүрэгтэй этгээд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой тодорхой үүргийг хүлээдэг.

Хяналт шалгалтын эрх бүхий байгууллагууд болон өөрийгөө зохицуулах байгууллагууд мэдээлэх үүрэгтэй этгээдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг. Хянан шалгагч нар өндөр эрсдэлтэй салбар болон мэдээлэх үүрэгтэй этгээдэд чиглэсэн эрсдэлд суурилсан хяналт шалгалт явуулах замаар зөрчлөөс урьдчилан сэргийлэхээс гадна тэдгээрийн удирдлагуудад зохих шаардлагуудыг тавих замаар гэмт хэрэгтнүүдийг санхүүгийн системд нэвтрэх, үйл ажиллагаа эрхлэхээс сэргийлдэг. Аливаа зөрчилд хийсэн үйлдэлтэй нь дүйцсэн, давтан үйлдэхээс сэргийлэхүйц хариуцлага оногдуулдаг байх шаардлагатай.

Мэдээлэх үүрэгтэй этгээд харилцагчийг таньж мэдэх, эцсийн өмчлөлийг тогтоох, улс төрд нөлөө бүхий этгээд эсэхийг тодорхойлох, сэжигтэй гүйлгээний тайланг мэдээлэх болон бусад үүргээ биелүүлснээр гэмт этгээдүүд санхүүгийн болон санхүүгийн бус салбарыг хууль бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.

Холбогдох ФАТФ-ын техник хэрэгжилтийн Зөвлөмж ба үр дүнтэй байдлын Шууд хэрэгжилт

Зөвлөмж 1, 6-25, 26-28, 29, 34-35, 40

Шууд хэрэгжилт 3, 4, 5, 10, 11

Зорилго 5-ын зорилтууд

Зорилт 5.1.	Монгол Улсын Харилцан үнэлгээний тайлан, Явцын тайланд дурдсан техник хэрэгжилтийн дутагдлыг арилгах, ФАТФ-ын Зөвлөмжид орсон өөрчлөлтийг тусгах зорилгоор дотоодын хууль тогтоомжийг шинэчлэх
Зорилт 5.2.	Тохиромжтой этгээдийн шалгуурын үр дүнтэй байдлыг дээшлүүлэх зорилгоор хууль тогтоомжийг боловсронгуй болгох
Зорилт 5.3.	Урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнтэй байдлыг сайжруулах чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох
Зорилт 5.4.	Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын давтамж, чанарыг сайжруулах, зөрчилд тохирсон хариуцлагын арга хэмжээ авах
Зорилт 5.5.	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг бүртгэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг бэхжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах
Зорилт 5.6.	Мэдээлэх үүрэгтэй этгээдийн комплаенсийн ажилтнуудын чиг үүргээ хэрэгжүүлэх эрх мэдлийг нэмэгдүүлэх
Зорилт 5.7.	Эцсийн өмчлөгчийн мэдээллийн чанарыг сайжруулах, эцсийн өмчлөгчийг нягтлах зорилгоор холбогдох мэдээллийн санд хандах зохицуулалтыг боловсронгуй болгох, хэрэгжүүлэх (эцсийн өмчлөгчийн мэдээллийг нээлттэй мэдээлэлд хамруулах ажлыг төлөвлөгөөнд тусгах)
Зорилт 5.8.	Улс төрд нөлөө бүхий этгээд зэрэг өндөр эрсдэлтэй харилцагчийг нарийвчлан таньж мэдэх үйл ажиллагааны журам, заавар, гарын авлагыг шинэчилж, хэрэгжилтийг сайжруулах
Зорилт 5.9.	Мэдээлэх үүрэгтэй этгээдийн санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах үүргийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах
Зорилт 5.10.	Ашгийн бус байгууллагын салбарт эрсдэлд суурилсан хяналт шалгалт, зохицуулалтыг бий болгох, зөрчилд тохирсон, дахин үйлдэхээс урьдчилан сэргийлсэн хариуцлагын арга хэмжээг авах

Зорилт 5.11.	Харилцагчийг таньж мэдэх хялбаршуулсан арга хэмжээг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, тусгайлсан заавар, зөвлөмж гаргаж, хэрэгжилтийг хангуулах
--------------	--

Зорилго 6: Терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлж болзошгүй үйлдлийг таних, мөнгө угаах үйлдлийг илрүүлэх ажиллагааг сайжруулах

Ач холбогдол:

Мэдээлэх үүрэгтэй этгээдээс санхүүгийн мэдээллийг хүлээн авах, түүнд дүн шинжилгээ хийх, гарсан үр дүнг хууль сахиулах байгууллагуудтай солилцох чиглэлээр хамтран ажиллах тогтолцоог сайжруулан, энэ чиглэлээр хүний нөөцийн чадвар, чадамжийг нэмэгдүүлснээр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх гэмт хэргийг үр дүнтэй илрүүлэх, мөрдөн шалгахад дэмжлэг үзүүлэх ач холбогдолтой.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх хүрээнд хяналт шалгалт явуулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа хэдий ч гэмт этгээдүүд хөрөнгөө нуун далдлах болон бусад хууль бус зорилгоор эдгээр арга хэмжээнээс зайлсхийхийг эрмэлзэж байдаг. Энэ хүрээнд мэдээлэх үүрэгтэй этгээдээс чанартай сэжигтэй гүйлгээний тайлан, бэлэн мөнгөний гүйлгээний тайлан, гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлан болон бусад мэдээллийг Санхүүгийн мэдээллийн алба хүлээн авч, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр хууль сахиулах байгууллагуудад шилжүүлдэг. Уг үйл явцын чанар, эргэх холбоог сайжруулснаар холбогдох сэжигтэй гүйлгээ, үйлдлийг илрүүлж, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлж, үр дүнтэй арга хэмжээ авах боломж сайжрах юм.

Холбогдох ФАТФ-ын техник хэрэгжилтийн Зөвлөмж ба үр дүнтэй байдлын Шууд хэрэгжилт
Зөвлөмж 1, 2, 6-7, 20-21, 23, 29-35
Шууд хэрэгжилт 3-4, 6-9, 10-11

Зорилго 6-ийн зорилтууд

Зорилт 6.1.	Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлдэг тайлан, мэдээллийн тоо, чанар, үр дүнтэй байдлыг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
Зорилт 6.2.	Санхүүгийн мэдээллийн албанаас хууль сахиулах байгууллагад шилжүүлэх тайлан, мэдээллийн тоо, чанарыг Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүнтэй уялдуулан сайжруулах



Зорилт 6.3.	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх гэмт хэргийг илрүүлэх зорилгоор суурь гэмт хэрэг болон бусад гэмт хэрэгт санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг зэрэгцэн явуулах олон улсын стандартыг нэвтрүүлэх
Зорилт 6.4.	Хилээр мэдүүлээгүй /худал мэдүүлсэн бэлэн мөнгө болон шилжих төлбөрийн хэрэгслийг илрүүлэх үйл ажиллагааг сайжруулах/
Зорилт 6.5.	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх гэмт хэргийг илрүүлэхэд гааль, татварын алба болон хөндлөнгийн аудитуруудын оролцоог нэмэгдүүлэх

Зорилго 7: Суурь гэмт хэрэг нь эрсдэлтэй гэж үнэлсэн мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах, шүүхээр шийдвэрлэх болон хөрөнгө хураахтай холбоотой ажиллагааны чанарыг сайжруулах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт сонор сэрэмжтэй хандах

Ач холбогдол:

Гэмт хэрэгтнүүд хууль бусаар олсон хөрөнгө, орлогынхоо эх үүсвэрийг нуун далдлах замаар ял шийтгэлээс зайлсхийхийг эрмэлздэг. Мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн этгээдийг мөрдөн шалгах, хэргийг хянан шийдвэрлэх, шүүн шийдвэрлэх, цаашлаад хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах нь энэ төрлийн гэмт хэргийг үйлдэх, мөн гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогоос гэмт этгээд ашиг шим хүртэх үйл явцыг таслан зогсооно.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд хожим хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг ашиглах боломжтой нөхцөлд аливаа хариуцлагын арга хэмжээг хүлээх эсэхэд ач холбогдол төдийлөн өгдөггүй тул хулгайлагдсан хөрөнгийг албадан хурааснаар гэмт хэрэгтнүүдийг хууль бусаар олсон хөрөнгө, орлогоос үр шимийг хүртэх боломжийг хаах, энэ гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой.

Холбогдох ФАТФ-ын техник хэрэгжилтийн Зөвлөмж ба үр дүнтэй байдлын Шууд хэрэгжилт
Зөвлөмж 1-2, 3-6, 15, 29-33, 37-40
Шууд хэрэгжилт 1, 2, 6-9

Зорилго 7-ийн зорилтууд

Зорилт 7.1.	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх хариуцлагын тогтолцоог олон улсын конвенц, стандартад нийцүүлэх асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хэрэгжилтийг сайжруулах зэрэг арга хэмжээ авах
-------------	---



Зорилт 7.2.	Эрсдэлтэй гэж үнэлэгдсэн мөнгө угаах нарийн төвөгтэй арга хэлбэр (гуравдагч этгээдээр эсхүл дангаар мөнгө угаах) бүхий үйлдлийг мөрдөн шалгах, яллах, шүүхээр шийдвэрлэх ажиллагааг нэмэгдүүлэх, хариуцлага хүлээлгэх
Зорилт 7.3.	Гэмт хэргийн улмаас олсон шууд болон шууд бус ашиг, орлого (гадаад, эсхүл дотоод эх үүсвэрээс), түүнтэй адилтгах үнэ бүхий хөрөнгө хураахтай холбоотой ажиллагааг Үндэсний эрсдэлийн үнэлгээгээр тодорхойлсон эрсдэлтэй уялдуулан сайжруулах
Зорилт 7.4.	Битүүмжлэх, хураах болон гадаад улсаас буцаан авах, буцаан олгох хөрөнгө, орлогын удирдлагын менежментийг боловсронгуй болгох
Зорилт 7.5.	Хилээр мэдүүлээгүй, худал мэдүүлсэн бэлэн мөнгө болон шилжих төлбөрийн хэрэгслийг хураан авах, битүүмжлэх, шийдвэр гаргахтай холбоотой үйл ажиллагааны хэрэгжилтийг сайжруулах
Зорилт 7.6.	Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг гарсан тохиолдолд мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх чадавхыг бүрдүүлэх

Зорилго 8: Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зохистой бүтэц, зохион байгуулалт, чадавхыг бэхжүүлэх

Ач холбогдол:

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чадварлаг боловсон хүчин, чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр, мэдээллийн технологийн системийн нөөц бололцоо нэн чухал. Энэ чиглэлээр зохих сургалтад хамрагдсан, мэргэшсэн хүний нөөц нь эрсдэлийн үнэлгээ хийх, санхүүгийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зэрэг санхүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгах, шийдвэрлэхэд ач холбогдол бүхий дэмжлэг үзүүлэх юм.

Холбогдох ФАТФ-ын техник хэрэгжилтийн Зөвлөмж ба үр дүнтэй байдлын Шууд хэрэгжилт
Зөвлөмж 2, 26-32
Шууд хэрэгжилт 1-11

Зорилго 8-ын зорилтууд

Зорилт 8.1.	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг нэмэгдүүлэх, чадавхжуулах, дэд бүтэц, мэдээллийн технологи болон техник хэрэгслийн шинэчлэлтэй холбоотой санхүүжилтийг төсөвт тусгуулах арга хэмжээ авах
-------------	---



Зорилт 8.2.	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр шүүх эрх мэдлийн, хууль сахиулах, хянан шалгах байгууллага, мэдээлэх үүрэгтэй этгээдэд зориулсан сургалтын нэгдсэн агуулга бүхий хөтөлбөр, арга зүйг боловсруулж хэрэгжүүлэх
Зорилт 8.3.	Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллага, мэргэжлийн холбоод мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийх, тэмцэх асуудлыг хариуцсан боловсон хүчний чадавх, ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх

Дөрөв.Хөтөлбөрийн хугацаа, хүрэх үр дүн

Хөтөлбөрийг 2022-2030 онд хэрэгжүүлэх бөгөөд хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

4.1.Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог олон улсын техник хэрэгжилт, үр дүнтэй байдлын стандартад нийцүүлэн бэхжүүлэх замаар олон улсын зах зээлтэй холбогдсон, тогтвортой, хүртээмжтэй санхүүгийн системийг хөгжүүлнэ.

4.2.Монгол Улсын 2017 оны Харилцан үнэлгээний тайланд дурдсан дутагдлыг арилгах, дараагийн харилцан үнэлгээгээр хангалттай үнэлгээ авах замаар олон улсын байгууллагын хориг арга хэмжээний жагсаалтад орох эрсдэлийг бууруулна.

4.3.Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр дотоод, гадаад хамтын ажиллагаа өргөжиж, төр, хувийн хэвшил хоорондын ажлын уялдаа холбоо сайжирна.

4.4.Төр, хувийн хэвшил болон олон нийтийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлснээр энэ төрлийн гэмт хэрэгт өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.

4.5.Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ сайжирч, мэдээлэл солилцох, хянан шалгах, дүн шинжилгээ хийх ажлын үр дүнтэй байдлыг нэмэгдүүлнэ.

4.6.Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлснээр зохицуулагч байгууллагууд

нөөц бололцоогоо зохистой хуваарилах, эрсдэлтэй талбарт хяналт шалгалтын нөөцийг төвлөрүүлж ажиллана.

4.7. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд хариуцлага ногдуулах тогтолцоог сайжруулснаар мэдээлэх үүрэгтэй этгээдийн хууль тогтоомжийн дагуу хүлээсэн үүргийн биелэлтийг хангуулж, зөрчил, дутагдлыг дахин үйлдэхээс сэргийлнэ.

4.8. Мэдээлэх үүрэгтэй этгээд өөрсдийн үйл ажиллагааны онцлог тохирсон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлснээр Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх тайлан, мэдээллийн чанар, тоо нэмэгдэх, хууль сахиулах байгууллагуудад шилжүүлэх дүн шинжилгээний чанар сайжрах, улмаар энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх ажилд ахиц гарна.

4.9. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх мөрдөн шалгах, таслан зогсоох, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах, гэмт хэрэгтнүүдийн үйлдэлд тохирсон ял шийтгэл оногдуулах бодлогын арга хэмжээ, зохион байгуулалтыг чанаржуулах замаар гэмт хэргийн илрүүлэлт, хэргийн хяналт болон шүүхээр шийдвэрлэсэн хэргийн тоо, чанарыг нэмэгдүүлнэ.

Тав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, тайлагнал

Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах чиглэлээр удирдлага, зохион байгуулалт, тайлагналын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

5.1. Үндэсний зөвлөл³ нь хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, түүний биелэлтийг үнэлэх ажлыг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангана.

5.2. Үндэсний зөвлөл нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

5.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд үндэслэн Үндэсний зөвлөл болон Хамтын ажиллагааны зөвлөлийн⁴ гишүүн байгууллага тус бүр өөрсдийн хариуцсан ажлуудын хэрэгжилтийг хангах нарийвчилсан төлөвлөгөөг дотооддоо боловсруулж хэрэгжүүлнэ.

³Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 22¹.1 дэх заалтын дагуу Монгол Улсын Ерөнхий Сайдын захирамжаар байгуулагдсан.

⁴Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 22.1 дэх заалтын дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар байгуулагдсан.



5.4. Үндэсний зөвлөл болон Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан хариуцсан ажлуудын явц биелэлтийг улирал бүр тайлагнах бөгөөд биелэлтийн тайланг улирлын дараа сарын 20-ны өдрийн дотор Санхүүгийн мэдээллийн албанд албан бичгээр болон цахим хэлбэрээр ирүүлнэ.

5.5. Хамтын ажиллагааны зөвлөл нь хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний явц биелэлтийг хагас жилд нэг удаа хэлэлцэх бөгөөд шаардлагатай тохиолдолд хэрэгжилтийг хангахтай холбоотой зөвлөмж гаргана.

5.6. Хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний явц биелэлтийг Үндэсний зөвлөл жил бүр үнэлж дүгнэнэ.

5.7. Үндэсний зөвлөл нь хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлтийн тайланг жил бүрийн эхний хагас жилд багтаан Засгийн газарт хүргүүлж танилцуулна.

5.8. Үндэсний зөвлөл нь хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд шаардлагатай тохиолдолд зохих өөрчлөлт, тодотгол оруулах арга хэмжээг авна. Өөрчлөлт оруулахдаа олон улсын байгууллагаас гаргасан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой стандарт зөвлөмж, олон улсын сайн туршлагад үндэслэнэ.

5.9. Үндэсний зөвлөл болон Хамтын ажиллагааны зөвлөл нь хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг хангуулах чиглэлээр зөвлөлийн гишүүн байгууллагуудад дэмжлэг үзүүлж болно.

---o0o---

**ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 Зөвлөмж болон
Хөтөлбөрийн 8 Зорилго**

Зөвлөмж	Тайлбар	Зорилго
А-Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого, хамтын ажиллагаа		
1.	Эрсдэлээ үнэлэх, эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх	Зорилго 1, 2, 3, 4
2.	Үндэсний хамтын ажиллагаа болон уялдаа холбоо	
Б-Мөнгө угаах гэмт хэрэг болон хөрөнгө хураах		
3.	Мөнгө угаах гэмт хэрэг	Зорилго 6, 7
4.	Хөрөнгө хураах болон түр зуурын арга хэмжээ	
В-Терроризм болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх		
5.	Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг	Зорилго 5, 6, 7
6.	Терроризм болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой зорилтот санхүүгийн хориг арга хэмжээ	
7.	Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ	
8.	Ашгийн бус байгууллага	
Г-Урьдчилан сэргийлэх арга хэмжээ		
9.	Санхүүгийн байгууллагын нууцлалын хууль тогтоомж	Зорилго 4, 5, 6
10.	Харилцагчийг таньж мэдэх	
11.	Баримт материал хадгалах	
12.	Улс төрд нөлөө бүхий этгээд	
13.	Корреспондент банкны үйл ажиллагаа	
14.	Мөнгө, үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ	
15.	Шинэ технологи	
16.	Цахим шилжүүлэг	
17.	Гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх	
18.	Дотоод хяналт болон гадаад дахь салбар, охин компани	
19.	Өндөр эрсдэлтэй улс орнууд	
20.	Сэжигтэй гүйлгээг мэдээлэх	
21.	Мэдээллийг задруулах болон нууцлал	
22.	Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч: Харилцагчийг таньж мэдэх	
23.	Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч: Бусад арга хэмжээ	
Д-Эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд болон хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, ил тод байдал		
24.	Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон ил тод байдал	Зорилго 1, 3, 4, 5, 6
25.	Эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн ил тод байдал болон эцсийн өмчлөгч	
Е-Холбогдох байгууллагын эрх мэдэл, үүрэг хариуцлага болон авах арга хэмжээ		
26.	Санхүүгийн байгууллагын зохицуулалт, хяналт шалгалт	



27.	Хянан шалгагчийн эрх мэдэл	Зорилго 3, 4, 6, 7, 8
28.	Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчийн зохицуулалт, хянан шалгалт	
29.	Санхүүгийн мэдээллийн алба	
30.	Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагын үүрэг	
31.	Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагын эрх мэдэл	
32.	Бэлэн мөнгө зөөвөрлөгчид	
33.	Статистик мэдээлэл	
34.	Зааварчилгаа, эргэх холбоо	
35.	Шийтгэлийн арга хэмжээ	
Ё- Олон улсын хамтын ажиллагаа		
36.	Олон улсын арга хэрэгслүүд	Зорилго 3
37.	Эрх зүйн харилцан туслалцаа	
38.	Эрх зүйн харилцан туслалцаа: хөрөнгө царцаах, хураах	
39.	Гэмт хэрэгтэн шилжүүлэх	
40.	Олон улсын хамтын ажиллагааны бусад хэлбэр	

---o0o---

**ФАТФ-ын үр дүнтэй байдлын 11 Шууд хэрэгжилт болон
Хөтөлбөрийн 8 Зорилго**

Шууд хэрэгжилт	Тайлбар	Зорилго
Явцын хэрэгжилт: Бодлого, уялдаа холбоо болон хамтын ажиллагаа нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулдаг байх		
1.	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг илрүүлж, үнэлж, ойлгодог, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого стратегийг хамтран боловсруулж, үндэсний хэмжээнд хэрэгжүүлдэг байх	Зорилго 1, 2, 3, 4, 8
2.	Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд гэмт хэрэгтэн болон тэдний хөрөнгийн талаар шаардлагатай санхүүгийн болон бусад мэдээ мэдээлэл, нотлох баримтыг олох боломжтой байх	
Явцын хэрэгжилт: Гэмт хэргийн замаар олсон болон терроризмыг дэмжих хөрөнгө мөнгийг санхүүгийн болон бусад салбарт нэвтрэхээс сэргийлдэг болон дээрх байгууллагууд өөрсдөө илрүүлж, мэдээлдэг байх.		
3.	Хянан шалгагч нар санхүүгийн байгууллага болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг эрсдэлтэй нь уялдуулан шаардлагатай түвшинд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүргээ хэрхэн биелүүлж байгааг хянадаг, зохицуулдаг байх, мөн санхүүгийн байгууллага, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид нь зохих түвшинд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг өөрийн эрсдэлд уялдуулан хэрэгжүүлж, сэжигтэй гүйлгээг мэдээлдэг байх	Зорилго 1, 2, 3, 4, 5, 6, 8
4.	Хянан шалгагч нар санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч нарыг эрсдэлтэй нь уялдуулан шаардлагатай түвшинд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүргээ хэрхэн биелүүлж байгааг хянадаг, зохицуулдаг байх, мөн санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч нар нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг өөрийн эрсдэлд уялдуулан хэрэгжүүлж, сэжигтэй гүйлгээг мэдээлдэг байх	
5.	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх хууль бус үйлдлээс хуулийн этгээдийг урьдчилан сэргийлсэн, эрх бүхий байгууллага нь тэдгээрийн эцсийн өмчлөгчийн тухай мэдээллийг саадгүй авах боломжтой байх	
Явцын хэрэгжилт: Мөнгө угаах оролдлогыг илрүүлдэг, таслан зогсоодог, гэмт хэрэгтнүүдэд хариуцлага хүлээлгэдэг болон хууль бус орлогыг хураан авдаг байх. Терроризмыг санхүүжүүлэх оролдлогыг илрүүлдэг, таслан зогсоодог,		



террористуудын эх үүсвэрийг таслан зогсоодог болон терроризмыг санхүүжүүлсэн этгээдүүдэд хариуцлага хүлээлгэдэг нь террорист үйлдэл үйлдэгдэхээс сэргийлдэг байх		Зорилго 1, 2, 3, 4, 6, 7, 8
6.	Эрх бүхий байгууллага нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйлдлийг шалгахдаа санхүүгийн мэдээлэл болон бусад холбогдох мэдээллийг зүй зохистой ашигладаг байх	
7.	Мөнгө угаахтай холбоотой үйлдэл болон гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг байх, гэмт этгээдүүдэд үр дүнтэй нөлөөлөх, үйлдсэн зөрчилтэй нь дүйцэхүйц, давтан үйлдэхээс сэргийлсэн хариуцлага хүлээлгэдэг байх	
8.	Гэмт хэргээс олсон орлого болон үйлдэхэд ашиглагдсан хэрэгсэл зэргийг хураан авдаг байх	
9.	Терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой үйлдэл болон гэмт хэрэгт мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулдаг байх, буруутай этгээдүүдэд үр дүнтэй нөлөөлөх, гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, давтан үйлдэхээс сэргийлсэн хариуцлага хүлээлгэдэг байх	
10.	Террорист, террорист байгууллага болон терроризмыг санхүүжүүлэгч нарыг хөрөнгө мөнгө цуглуулах, шилжүүлэх, ашиглахаас урьдчилан сэргийлэх	
11.	НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолд заасны дагуу үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх үйл ажиллагаатай холбоотой хувь хүн, этгээдүүдийг хөрөнгө цуглуулах, шилжүүлэх, ашиглахаас урьдчилан сэргийлэх	

---o0o---

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 8.25

Индекс: 200003